

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

# ХҮНИЙ ЭРХ

---

ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

“Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр,  
эрхийнхээ хувьд адил тэгш байна...”

---

(11 дэх жилдээ)

2012/02

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл

2012/02(40)

Улсын бүртгэлийн дугаар 244

Жилд 2 удаа хэвлэгдэнэ

11 дэх жилдээ

П.Оюунчимэг Ерөнхий редактор (ХЭҮК-ын гишүүн)

Ц.Адъяахишиг Хариуцлагатай нарийн бичгийн дарга (ХЭҮК-ын ахлах референт)



Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй, зөвхөн зохиогчийн үзэл бодол болно.

## АГУУЛГА

**ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ БУЙ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Хууль зүйн яам.....	04
Монгол Улсын ерөнхий прокурорын газар.....	08
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар.....	10
Үндэсний тагнуулын академи.....	11

**ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ***П.Оюунчимэг (PhD)*

Хүний эрхийн Үндэсний байгууллагаас шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа өнөөгийн нөхцөл болон гарч буй хүндрэлүүд.....	12
--	----

*Р.Оюунбадам (Докторант)*

Шинэчлэл ба хорих байгууллага.....	17
------------------------------------	----

*П.Амаржаргал (Докторант)*

Үндсэн хууль болон үндэсний хууль тогтоомжид үзүүлэх олон улсын эдийн засгийн эрх зүйн нөлөөлөл.....	21
--	----

*С.Айнагүл (Докторант)*

Цөөнхийн эмэгтэйчүүдийн эрхийн асуудал.....	28
---	----

*Б.Банзрагч (Докторант)*

Монгол Улсын Үндсэн хуулиар хувийн өмчийн хамгаалагдсан байдал.....	34
---	----

*Г.Агар-Эрдэнэ (Докторант)*

Эрүүл орчинд амьдрах эрх хүний үндсэн эрх болох нь.....	38
---	----

*Б.Болорсайхан (Докторант)*

Хүний эрхийн үндэсний байгууллагыг тодорхойлох зарим асуудал.....	44
---	----

*Н.Арвинтариа*

Байнгын хүчирхийлэл, дарамтын улмаас гэмт хэрэг үйлдэх явдал ба гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага.....	63
---	----

**МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА***Амартя Сен*

Хүний эрх ба Азийн Үнэт зүйлс орчуулсан Ө.Ундрах.....	66
---	----

**ЗОЧНЫ ЯРИА**

“Монгол Улсад эрэгтэй судлалыг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна” Монголын Эрэгтэйчүүдийн Холбооны гүйцэтгэх захирал Д.Бадамцэцэгтэй хийсэн ярилцлага.....	80
--	----

## ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ

### **Хууль зүйн яамнаас боловсруулж буй эрүүгийн багц хуулийн төслийн талаарх товч мэдээлэл**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар эхэлсэн шүүхийн шинэтгэлийг Улсын Их Хурлын 2012 оны сонгуулийн үр дүнд байгуулагдсан Шинэчлэлийн Засгийн газар үргэлжлүүлэхээр үйл ажиллагааныхаа хөтөлбөрт томоохон зорилт болгон тусган ажиллаж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН гэсэн бүлэгт “Төр засгийг түмэн олондоо тунгалаг, нээлтэй болгож, хариуцлага, хяналтыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгон мөрдүүлж, хүнд сурталгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг бий болгож, улмаар төрийн албыг нийтийн алба, төрийн үйлчилгээг нийтийн үйлчилгээ болгон үндсээр нь өөрчилж, хууль дээдлэн, хүн бүр эрх тэгш, эх орондоо, аймаг, хотдоо сайхан амьдрах нийгмийг цогцлоход энэ чиглэлийн эрхэм зорилго оршино” гэж заажээ.

Энэхүү зорилтын хүрээнд Хууль зүйн яам эрүүгийн тогтолцооны шинэтгэлийг эхлүүлж, эрүүгийн багц хуулийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хурлын 2012 оны намрын чуулганд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

### **Эрүүгийн хуулийн төслийн талаар**

2002 онд батлагдсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш даруй 10 гаруй жил өнгөрч, хууль тогтоогч болон хэрэгжүүлэгч, эрдэмтэн судлаачдын зүгээс уг хуулийг шинэчлэх цаг үеийн хэрэгцээ,

шаардлага гараад байгааг хүлээн зөвшөөрч байна.

Эрүүгийн хуулийг шинэчлэхдээ тулгарч буй бэрхшээл, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, нийгмийн хөгжлийг даган нягтарч, өөрчлөгдөж буй нийгмийн харилцааны агуулгад нийцүүлэн шинээр үйлдэгдэх болсон гэмт хэргийн агуулгад тохирсон, Монгол Улсын иргэн, нийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлд төрийн эрүүгийн бодлогыг тодорхойлж байна.

Монгол Улсад эрүүгийн хариуцлагын тогтолцоонд хорих ял хамгийн их хувийг эзэлдэг. Шүүхийн 2011 оны шүүн таслах ажиллагааны нэгдсэн мэдээгээр тухайн онд шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 7.6 хувиар, ял шийтгүүлэгчид 12.6 хувиар өссөн ба нийт ялын дотор хорих ялын эзлэх хувь 77.4 хувь, 5.8 хувь албадан ажил хийлгэх, 12.5 хувь баривчлах ял, бусад ял 0.1 хувь гэсэн судалгаа байна.

Шоронгоос суллагдсан хүмүүсийн дунджаар 70 орчим хувь нь дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлжээ. Ял, шийтгэл гарцаагүй байх ёстойдоо чухал болохоос гэмт явдлын шалтгаан байх учиргүй юм. Энэ чиглэлд онцгой анхаарч сонгон хэрэглэх боломжтой албадлагын арга хэмжээ болох нийтэд тустай ажил хийлгэх, эрх чөлөө хязгаарлах (электрон гав), хүүхдэд хүлээлгэх хариуцлагыг шинээр оруулж байна. Ингэснээр хорих ялыг багасгаж, үр нөлөөтэй, хүний хувийн байдалд тохирсон эрүүгийн хариуцлагын хэлбэрийг шинээр тусгахад анхаарч байна.

Түүнчлэн, гэмт хэрэг, зөрчлийн ялгаа заагийг тодорхой гаргаж, зөрчлийн тухай

хууль, Эрүүгийн хууль харилцан бие биенээ нөхөх чиглэлд анхаарч, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийтийн эрх ашгийг хангах бодлогыг нэн тэргүүнд баримтална. Гэмт хэргийн төрлийг шинээр бүлэглэж, шинэ гэмт хэрэг, тухайлбал, хүн худалдаалах, хар тамхи, мөнгө угаах, мэдээллийн аюулгүй байдал, түүнд халдсан зарим гэмт хэргийг хуульчлах, авлига, албан тушаалын гэмт хэргийг тодорхой зааж, шан харамж авах гэх мэт зарим гэмт хэргийн бүрэлдэхүүнийг өөрчилнө.

Онц аюултай гэмт хэрэгтэн, урьд ял шийтгүүлсэн, давтан үйлдсэн гэж хүнийг “шошгожуулж” нэрлэн, хүндээр шийтгэдэг хууль зүйн үр дагавар үүсгэж байсан ойлголтыг өөрчилж ялын бодлогоор гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Цаазаар авах ялыг халж, түүний оронд бүх насаар нь хорих ялыг шинээр нэмж оруулан, хорих ялын нээлтэй, хаалттай дэглэмд шилжих зохицуулалтыг оруулж байна.

Хууль алагчилж хүрдэг, ялимгүй хэрэг үйлдсэн хүн хүнд ял авч, авлига албан тушаалын хэрэг үйлдэж их хэмжээний хохирол учруулсан хүн хөнгөн ял авдаг гэсэн иргэдийн дүгнэлтийг үндэслэж авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулахаар ялыг чангатгана. Эрүүгийн хуулийг Улсын дээд шүүхийн тогтоолоор тайлбарлаж, төсөөтэй хэрэглэдэг явдлыг багасгах үүднээс хууль зүйн техник, нэр томъёоны асуудалд анхаарал хандуулан ажиллаж байна.

### **Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаар**

Монгол Улсад өнөөдөр мөрдөгдөж буй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээ хэлэлцээрт тусгагдсан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахтай холбогдсон хэм хэмжээнд нийцүүлэх шаардлагатай байна.

Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх ашгийг хангах, яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явагдах зарчим бүхэн хэрэгжих нөхцөл бүрдүүлэх, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур шүүгчийн зөвшөөрөлгүйгээр хүний эрхэд халдах, хязгаарлах явдлыг хориглох зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулах зорилгоор эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинэчлэн найруулах төсөл боловсруулж байна.

### **Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төслийн талаар**

Монгол Улсад хууль сахиулах чиг үүргийг олон салбарын мэргэжлийн байгууллага хэрэгжүүлдэг боловч өнөөг хүртэл төрөлжсөн хуульгүй явж ирлээ.

Хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг гэмт хэрэг болон зөрчлийг шалган шийдвэрлэх салбар эрх зүйн хүрээнд төдийгүй байгууллагын хэм хэмжээ тогтоосон салбарын хуулиудаар зохицуулж байгаа нь эрх зүйн хийдэл, цоорхой, давхардлыг бий болгож улмаар хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхагдахгүй байх Үндсэн хуулийн зохицуулалтыг гажуудуулах нөхцөл болж байна.

Иймд гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх, мөрдөн шалгах эрх бүхий цагдаа, мөрдөх болон хилийн алба, татвар, гааль зэрэг хууль сахиулах байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид нэгдсэн зарчим, журмаар хэрэгжих эрх зүйн баталгааг бүрдүүлэх шаардлагад үндэслэн Хууль сахиулах үйл ажиллагааны тухай бие даасан хуулийн төслийг боловсруулж байна.

**Цагдаагийн байгууллагын тухай,  
Цагдаагийн албан хаагчийн эрх зүйн  
байдлын тухай хуулийн төслийн талаар**

Монгол Улсын нийгмийн амьдралд гарч буй өөрчлөлт, олон улсын туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, иргэний хяналтыг бий болгох зорилгоор Цагдаагийн байгууллагын тухайн хуулийн төслийг шинэчлэн боловсруулж байна. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг нь үнэлж дүгнэх, хяналт тавих үүрэг бүхий иргэдийн төлөөлөөс бүрдсэн Иргэний зөвлөлийг орон нутаг, нийслэлд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд байгуулахаар, мөн тодорхой нутаг дэвсгэрт нийтийн амгалан тайван байдлын төлөө цагдаагийн албан хаагчид дэмжлэг үзүүлэн ажиллах олон нийтийн цагдаагийн ажилтныг ажиллуулдаг болох юм.

Цагдаагийн байгууллагын албан хаагчийн эрх зүйн байдлыг өөрчлөн тодорхойлж, гэмт хэрэг, нийгмийн хэв журам хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг албан хаагчийг тэдэнд туслах, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажилтнаас зааглан ялгаж, цагдаагийн албан хаагчийн цалин хөлс, амралт, шагнал урамшуулал, зэрэг дэв,

тэтгэвэр тэтгэмж, нийгмийн халамжийн бодлогыг шинэчлэн, үйл ажиллагаагаа хараат бусаар, үр дүнтэй явуулах нөхцөл бололцоог хангахаар зорьж байна.

**Мөрдөх албаны тухай хуулийн төслийн  
талаар**

Сүүлийн жилүүдэд манай улсад хүний наймаа, мөнгө угаах, хар тамхины, албан тушаалын зэрэг зохион байгуулалттай шинжтэй, нууц далд аргаар үйлдэгддэг гэмт хэргүүд ихээр үйлдэгдэх болж, гэмт хэргийн гаралт эрс нэмэгдэж байгаа нь эдгээр гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг цагдаагийн байгууллага дангаар хариуцах боломж, хүний нөөц, техник хэрэгсэл, бүтэц зохион байгуулалтын хувьд ямар ч хүрэлцээ, боломжгүй байгаа нь цаашид Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд аюул учруулах хэмжээнд хүрч байна. Иймд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар анхаарч, шинэ арга барил, шинэ түвшинд, шинэ бодлогоор энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх шаардлага зүй ёсоор гарч байгаа тул зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй, бие даасан байгууллагыг байгуулах зорилгоор Мөрдөх албаны тухай хуулийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.

Мөрдөх албаны хуулиар тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, хамгаалах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг Монгол Улсын төдийгүй хамтын ажиллагааны хүрээнд гадаад улсад ажиллах чадамж бүхий мөрдөх албыг байгуулах хууль эрх зүйн үндэс бүрдэнэ.

### **Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төслийн талаар**

Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, эрх зүйн бие даасан зохицуулалтыг бий болгох зорилгоор олон улсын гэрээ, конвенц, бусад улсын хууль тогтоомжийг судалсны үндсэн дээр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж байна.

Хуулийн төсөлд гэрч, хохирогчийн аюулгүй байдлын болон сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг авах, тэдэнд эрх зүйн болон эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх талаарх зохицуулалтыг тусгасан болно.

Гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэнээр гэрч, хохирогчийг хамгаалах нэгдсэн тогтолцоо бий болж, гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирол учирсан болон учирч болзошгүй этгээдийг хамгаалах, тэдэнд хууль зүйн болон эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх асуудал эрх зүйн хүрээнд баталгаажихаас гадна Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд чухал ач холбогдолтой болох юм.

### **Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийн талаар**

Монгол Улсын иргэний Үндсэн хуулиар баталгаажсан хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, түүнчлэн

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасан “...өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, ... өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө, хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх” баталгаагаар хангагдах эрхийг баталгаажуулах зорилгоор Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийг боловсруулж байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан хүн амын амьжиргааны түвшинг илтгэх ядуурлын хамралтын хүрээ 2011 онд 29.8 хувь буюу Монгол Улсад 3 хүн тутмын 1 нь ядуурлын түвшинд амьдарч байна. Гэтэл эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон, шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүсийн 80 гаруй хувь нь боловсролын түвшин доогуур, эсхүл боловсролгүй, ядуу иргэд байдаг гэсэн судалгаа байдаг. Гэвч хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа өнөөгийн тогтолцоо хүн амын хамгийн ядуу хэсэгт хүртээмжтэй биш байна.

Иймээс төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг зохицуулсан бие даасан хууль батлах шаардлага үүсээд байгаа бөгөөд уг хуулийн төсөлд хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны тогтолцоо, зохион байгуулалт, санхүүжилт, хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг тусгаж өгнө.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар сайшаан дэмжиж хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосон “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор “Прокурорын байгууллагаас 2011-2016 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий хөтөлбөр”-ийг баталж гаргалаа.

Дээрх хөтөлбөрийн бодлогод нийцүүлэн прокурорын байгууллагын удирдамжийн баримт бичгүүдийг дахин боловсруулж, 72 баримт бичгийг хүчингүй болголоо. Энэ нь прокурорын байгууллагын үйл ажиллагаанд хүнд суртал, давхардал, шаг дамжлагыг багасгаж, прокурорын хяналтыг тасралтгүй жигд тавих, хяналтын объект нэг бүрт хүрч үр дүнтэй ажиллах, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах, зөрчигдсөн эрхийг нь сэргээхэд үндсэн ажлаа чиглүүлж, иргэд олон нийтэд түргэн шуурхай үйлчлэх боломж нөхцөл олгосон удирдлага зохион байгуулалтын чухал арга хэмжээ болжээ.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, конвенц, Үндсэн хууль бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, сахин хамгаалах, эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа, баривчлах, цагдан хорих, ял эдлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа аливаа илрэлүүдийг гаргахгүй байх, хүний эрхийг

зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход хамтран ажиллах зорилгоор 2011 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Хүний эрхийн Үндэсний Комисс, Улсын ерөнхий прокурорын газар харилцан тохиролцон байгуулсан “Хамтран ажиллах санамж бичиг”-т гарын үсэг зурсан.

Хэрэг бүртгэх мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд сэжигтэн, яллагдагч, ялтны эрхийг хангуулах, эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар харьцах, хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчих явдлыг гаргуулахгүй байхад прокурорын хяналтын ажлыг чиглүүлэн ажиллаж байна.

Цагдан хорих байранд хоригдогсад бие биенээ дарамталдаг, хэрэг хүлээлгэх зорилгоор өрөө дамжуулан хорьдог тухай гомдолмэдээлэл ирсэний дагуу прокурорын байгууллагаас холбогдох шалгалтуудыг хийж, эрх бүхий байгууллагуудад асуудал тавьж цагдан хорих төвд 4 прокурорыг байнга ажиллуулдаг болгосон.

Мөн цагдан хоригдож байгаа хүний өрөөг солих, өрөө сольж шилжүүлэх тохиолдолд прокурорт танилцуулж шийдвэрлэдэг журам тогтоосон нь сэжигтэн, яллагдагчаар хэрэг хүлээлгэх зорилгоор өрөө дамжуулан хорьж, тэдэнтэй хүнлэг бус харьцааг таслан зогсооход ач холбогдолтой ажил болсон.

Хоригдлын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор хорих ял эдлүүлэх байгууллагад иргэний нийгмийн хяналтыг хэрэгжүүлэх ажлыг Улсын ерөнхий прокуророос санаачлан хэрэгжүүлж эхлээд байна.



НҮБ, “Каритас Чех”, “Эмнести Интернэйшнл”, “Нээлттэй нийгэм форум” зэрэг иргэний нийгмийн байгууллагатай хамтран 2013 онд хорих байгууллага дахь хүний эрхийн байдлыг хянаж үзэхээр төлөвлөөд байна.

Прокурор шүүхийн өмнөх шатанд бүх шийдвэрийг гаргадаг бүрэн эрхийг эдэлдэг тул тухайн хэрэгт хөндлөнгөөс, хойно нь хяналт тавьдаг идэвхгүй хяналтын арга хэлбэрээс салж байнгын тасралтгүй хяналт тавьдаг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг удирдан чиглүүлдэг дэлхий нийтийн прокуроруудын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд дагаж мөрдөх аргачилсан зааврыг батлан гаргалаа.

Прокурор хэрэг хянах, удирдан чиглүүлэх үүргийг хэрэгжүүлэхдээ хэрэг шалгах аргачлал буюу хяналтын стандарт тогтоосон баримт бичгийг боловсруулж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд эрүүгийн хэргийн мөрдөн байцаалт явуулах хугацааг 2 жил 6 сар хүртэлх хугацаагаар сунгахаар тогтоосон, энэ боломжийг үндэслэн хэрэг шалгах ажиллагааг удаашруулан, янз бүрийн шалтаг шалтгаанаар хугацааг сунган шалгаж байгаа нь хүнийг залхаах, хэргийн нотлох баримтыг үнэгүйдүүлэх, хэргийг шийдвэрлэх боломжийг багасгах зэргээр сөрөг байдлыг бий болгож байна.

Түүнчлэн тухайн хэрэгт гэрч, хохирогчийг удаа дараалан дуудаж, нэг

асуудлаар олон дахин байцаах, сэжигтэн, яллагдагчийг байгууллагын үүдэнд тодорхой зорилгогүйгээр өдөр бүр, удаан хугацаагаар суулгах, шинжээчийн дүгнэлтийг гаргуулахдаа асуултыг буруу, дутуу тавьснаас болж, дүгнэлтийг дахин дахин гаргуулах, хэрэг удаашруулах зэргээр хүний эрхийг бүдүүлгээр зөрчих явдал байсаар байна.

Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанд хууль зөрчсөн үндэслэлээр 2011 оны 10 сарын байдлаар хэрэг бүртгэгч 18, мөрдөн байцаагч 22, цагдаагийн байгууллагын ажилтан 165, тагнуулын байгууллагын ажилтан 14 тус тус шалгагдаж байсан бол 2012 оны 10 сарын байдлаар хэрэг бүртгэгч 16, мөрдөн байцаагч 25, цагдаагийн ажилтан 121, тагнуулын байгууллагын ажилтан 5 тус тус шалгагджээ.

Дээрх тоон баримтаас харахад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хүний эрхийг ямар нэгэн хэмжээгээр зөрчиж байгаа асуудал төдийлөн буурахгүй байна гэж үзэхээр байна.

Иймд прокурорын байгууллагын зүгээс хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагааг аль болох Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндсэн хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх, шалтгаангүйгээр хэргийн хугацаа сунгаж удаашруулсан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорт хүний эрхийг ноцтой зөрчсөн үндэслэлээр арга хэмжээ тооцох ажлыг эрчимжүүлэхээр болоод байна.

## ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР

Монгол Улсад Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрт тусгагдсан тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хүний эрхийг хангах талаарх заалтыг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын ажлын төлөвлөгөө болон албан хаагчдын сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ирсэн байна.

Тус байгууллага нь 2012 оныг “Ахлагчийн жил” болгон зарласнаар нийт ахлагч бие бүрэлдэхүүний санал, хүсэлтийг сонсох, тэдний ахуй амьдрал, ажил үйлсийг дэмжих ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Энэ онд албан хаагчдынхаа эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангуулах тухай журам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Нээлттэй бодлогыг хэрэгжүүлэхэд баримтлах журам зэргийг шинээр батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шинээр томилогдсон удирдлагын зүгээс тус

байгууллагад мөрдөгдөж буй бүх журам, дүрэм, зааврыг хүний эрхийг хангах, албан хаагчдын эрх, аюулгүй байдлыг хангах бодлогод нийцүүлэн шинэчлэх ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Энэхүү ажлын хүрээнд албан хаагчдын эрх, аюулгүй байдлыг хамгаалах харилцааг зохицуулж буй Дотоод хяналт, шалгалтын журам, албан хаагчдыг томилох, чөлөөлөх, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл оногдуулах харилцааг зохицуулж буй боловсон хүчний ажлын заавар, албан хаагчдад орон сууц олгох харилцааг зохицуулж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын орон сууцны журам зэргийг шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

Мөн Хууль зүйн яамнаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын бүтцийг шинэчлэн батлахдаа тус ерөнхий газрын хүний эрхийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг ажиллуулахаар баталсан болно.

## ҮНДЭСНИЙ ТАГНУУЛЫН АКАДЕМИ

Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхээр Үндсэн хуулиндаа тунхаглаж, хүний эрх, эрх чөлөөг цоо шинэ утга агуулгаар баталгаажуулсан өнөөгийн нийгэмд эрх зүйн шинжтэй аливаа асуудалд хүний эрхийн мэдрэмжтэй ханддаг тагнуулын ажилтан бэлтгэх зорилгын үүднээс Үндэсний тагнуулын академид “Хүний эрх” хичээлийг сургалтын хөтөлбөрт оруулан судалж байна.

Үндэсний тагнуулын академи нь “Хүний эрх” хичээлийн зорилгыг сонсогчдод хүний эрхийн талаар өндөр мэдлэг олгож, хүний эрхийг хангах, хамгаалах арга механизмыг ашиглах чадвар, хүний эрхийг эрхэмлэн хүндэтгэх хандлага бүхий цогц чадамжийг төлөвшүүлэхэд оршино гэж тодорхойлсон.

Тус Академи нь “Хүний эрх” хичээлийн хөтөлбөрийг хүний эрхийн тухай ойлголт, хүний эрх, эрх чөлөөний үзэл санааны түүхэн хөгжил, хүний эрхийн ангилал болон тодорхой эрхүүд, хүний эрх ба төрийн эрх, үүрэг, захиргааны эрх зүйн актыг хүний эрхийн зарчимд нийцүүлэх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд

хүний эрхийг хангах, гүйцэтгэх ажил ба хүний эрхийн асуудал, хүний эрхийг хангах, хамгаалах үндэсний болон олон улсын механизм гэсэн сэдвүүдийн хүрээнд лекц, семинарын хэлбэрээр боловсруулан сургалтыг явуулж байна.

Академи “Хүний эрх” хичээлийг аюулгүй байдлын бакалаврын зэрэг олгох 4 жилийн сургалтын 3 дугаар дамжаанд 1 дүгээр улиралд 1.5 кредит цаг, мөн 2 жилийн сургалтын 1 дүгээр дамжаанд нэгдүгээр улиралд 1.5 кредит цаг тус тус судалдаг бөгөөд аюулгүй байдлын магистрантурын ангид сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Хүний эрх” хичээлийг сонгон суралцах хичээлээр судалдаг.

Мөн үндэсний тагнуулын академи нь албан үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хөндсөн асуудалтай учирч байдаг тагнуулын ажилтнууд, мөрдөн байцаагч нарын хүний эрхийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч, жил бүр Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран хүний эрх сургалтыг зохион байгуулж байна.

## ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГААС ШҮҮХЭД ТӨЛӨӨЛӨН НЭХЭМЖЛЭЛ ГАРГАЖ БАЙГАА ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БОЛОН ГАРЧ БУЙ ХҮНДРЭЛҮҮД



**П.ОЮУНЧИМЭГ**  
Хүний эрхийн Үндэсний  
Комиссын гишүүн  
(Хууль зүйн ухааны доктор)

1991 онд НҮБ-ын Хүний эрхийн Комиссоос зохион байгуулсан уулзалтаар “Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын талаарх зарчмууд”-ыг баталсан бөгөөд энэ нь Парисын зарчим гэдэг нэрээр алдаршиж 1993 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48/134 тогтоолоор батламжилсан байна. 1993 онд Австрийн Вена хотод болсон Хүний эрхийн Дэлхийн бага хурлаар олон улсын гэрээ конвенцид заасан хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдлийг хүлээн зөвшөөрч, түүнийг хангаж хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг бүхий Хүний эрхийн Үндэсний байгууллагыг Парисын зарчмуудад нийцүүлэн байгуулахыг гишүүн орнууддаа уриалсан билээ.

Монгол Улс 1992 оны шинэ ардчилсан Үндсэн хуулиндаа анх удаа хүний эрх, эрх чөлөөний талаарх заалтуудыг 16 дугаар бүлэгтээ оруулж тунхагласан байна.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний

Байгууллагын гишүүн орныхоо хувьд олон улсын өмнө хүлээсэн үүргээ хүндэтгэн сахиж, Үндсэн хуулийнхаа заалтыг амьдралд хэрэгжүүлэх үүднээс 2001 онд Монгол Улсад анх удаа Парисын зарчимд нийцсэн бие даасан хараат бус байнгын ажиллагаатай Үндэсний байгууллага болох Хүний эрхийн Үндэсний Комиссыг байгуулж хуулийг нь батлан гаргажээ.

Комисс хуулийнхаа дагуу хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд Комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д заасан үндэслэлээр өнөөдрийг хүртэл шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гарган хянан шийдвэрлүүлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14-т зааснаар Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг

нөхөн төлүүлэх эрхтэй гэж заажээ. Хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиар ихэвчлэн зохицуулсан байдаг.

Шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргахдаа Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Шүүхийн тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиудад заасан хүний эрх чөлөө тэр дундаа хүүхдийн эрхийг зөрчсөн тухай асуудлаар нилээдгүй нэхэмжлэлийг шүүхэд гарган шийдвэрлүүлсний зарим нь шүүхийн практикт анх удаа шийдэгдэж байгаа болон цаашид шүүхийн практикт жишиг болохоор анхаарч үзэхээр олон нэхэмжлэлүүд гарчээ.

Комисс 2001 оноос хойш шүүхийн цагаатгах тогтоол болон прокурорын хэрэгсэхгүй болгосон тогтоолууд мөн бусад хуулиудын зүйл заалт болон олон улсын гэрээний заалтуудыг зөрчсөн гэсэн үндэслэлээр хохирсон иргэдийн эрхийг хамгаалахын тулд 19 хүнд холбогдох 1 022 374 846 төгрөгийн хохирол нөхөн төлүүлэх 15 төлөөлөн нэхэмжлэлийг нийслэл, дүүрэг, аймаг, сум дундын шүүхэд гаргаснаас өнөөдрийн байдлаар шүүх 14 нэхэмжлэлийн 160 245 113 000 төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс гаргаж 16 хохирогчид олгуулахаар хянан шийдвэрлэжээ.

Эндээс харахад нийт гаргасан нэхэмжлэлийн үнийн дүнгийн зөвхөн 15.7 хувийг шүүх ханган шийдвэрлэж байгаа

нь энэ талын хэрэг маргааныг шүүхэд шийдвэрлэж байсан туршлага дутах, олон улсын гэрээний заалтуудыг шүүхийн шатанд хэрэглэж дадаагүй, мөн одоогийн үйлчилж байгаа хуулийн заалтууд нь өөр хоорондоо зөрчилтэй байгаагийн нэг илрэл яах аргагүй мөн.

Хуулинд тайлбар өгөх эрх бүхий субъектын хувьд Улсын дээд шүүх хуулийн зүйл ангийг тайлбарлах болон олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай тайлбаруудыг гаргасан байна. 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн Улсын дээд шүүхийн 09 тоот тогтоолоор батлагдсан “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” тайлбарын 6-д зааснаар шүүх Монгол Улсын олон улсын гэрээг эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хэрэглэхээр<sup>1</sup>... заасан боловч практикт хэрэглэж хэвшээгүй, ойлголт муутай байгаагаас хэрэг маргааныг бүрэн гүйцэд шийдэхгүй байна.

Комисс 2003 оны 4 дүгээр сард Үндсэн хуулиар олгогдсон иргэд оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг тодорхой хууль тогтоомжгүйгээр хязгаарлаж байна гэж үзэж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2000 оны 46 дугаар тогтоолын 1 дэх заалт буюу орон нутагт Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн үйлчилгээний хөлсний хэмжээг шилжин суурьшихаар ирсэн насанд хүрэгчдээс 50.0 мянган төгрөг,

<sup>1</sup> 2008 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн УДШ-ийн 9-р тогтоол

18 хүртэлх насны хүүхдээс 25.0 мянган төгрөг байхаар тогтоосныг хүчингүй болгуулахаар Чингэлтэй дүүргийн шүүхэд нийтийн эрх ашгийг хамгаалсан анхны төлөөлөн нэхэмжлэл байсан бөгөөд шүүх нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаагүй гэж үзэн дээд шатны шүүхэд давж заалдах өргөдөл гаргасныг 2003 оны 7 дугаар сард Улсын дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанаас эцэслэн шийдвэрлэсэн<sup>2</sup> байна.

2004 онд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт заасан заалтуудыг удирдлага болгон УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын тогтоолыг Завхан аймгийн харьяат Ч.Э-т холбогдуулан шалгаж байсан эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн хүчин төгөлдөр тогтоолыг үндэслэн Баянзүрх дүүргийн шүүхэд төлөөлөн нэхэмжлэлийг гаргасан ба энэ төрлийн нэхэмжлэлийг шүүх анх удаа хүлээн авч, шийдвэрлэжээ. Энэ төлөөлөн нэхэмжлэл нь шүүхийн практикт жишиг тогтоосон анхны нэхэмжлэл болсон гэж үздэг бөгөөд түүнээс хойш удаа тухайн хэргийн холбогдогчийг цагаатгасан болон хэрэгсэхгүй болгосон хэргүүдэд олон тооны нэхэмжлэлүүдийг шүүх хүлээн авч хянан шийдвэрлэсэн байна.

Иргэн Ч.Э-д холбогдох төлөөлөн нэхэмжлэлийн үндэс нь түүнийг онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан 6 жилийн турш (1996-2002 онуудад) хорьж шалгасан бөгөөд энэ хугацаанд цагдан хорих байранд 2 жил 6 сар 16 хоног, гянданд 4 жил 2 сар 7 хонон ял эдэлсэн нийтдээ 6 жил 8 сар 23 хоног хоригдож эрүүдэн

<sup>2</sup> ХЭҮК-ын архив, УБ., 2003 он.

шүүгдсэн нь 1984 оны Эрүү шүүлтийн эсрэг конвенцийн тодорхой заалтуудыг зөрчсөн байсан тул энэ нэхэмжлэлийг<sup>3</sup> гаргаж байсан. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 389 дүгээр зүйлд заасны зааснаар ... иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүсэн... арга хэмжээ хэрэглэсний улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана... гэж заажээ.

Комиссоос гаргасан төлөөлөн нэхэмжлэлүүдийн 80 гаруй хувь нь хуулийн энэ зүйл заалт болон олон улсын гэрээний тодорхой заатуудыг үндэслэн гарсан байна.

Хэдийгээр энэ нь нэг хүний асуудал шийдсэн мэт боловч энэ нь нөгөө утгаараа нийтийн эрх ашгийг хамгаалах ажлын эхлэл болсон бөгөөд үүний дараа гарч буй нэхэмжлэлүүд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирсон иргэдийн эрх ашгийг хамгаалах ажилд хууль хяналтын байгууллагууд болон Засгийн газар ч мөн адил тодорхой анхаарал хандуулж эхэлсэн байна. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүх, прокурорын хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг Засгийн газрын нөөц сангаас гаргах, энэ талаар шүүхийн шийдвэрт тусгаж байхаар Улсын дээд шүүхийн тайлбар гарсны дагуу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирсон иргэдийн хохирлыг төлөх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар тухай бүр хэлэлцэн шийдвэрлэж байна. Тухайлбал, эрүүгийн байцаан шийтгэх

<sup>3</sup> ХЭҮК-ын архив, УБ., 2005 он.

ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүх, прокурорын хууль зөрчсөн ажиллагааны улмаас хохирсон 20 гаруй иргэд, байгууллагын 500 гаруй сая төгрөгийн хохирлыг Засгийн газрын нөөц сангаас гаргаж барагдуулах арга хэмжээ авчээ. Мөн төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлыг барагдуулах зориулалтаар 3.4 тэрбум төгрөгийг 2009 оны улсын төсөвт тусгаж урьд жилүүдэд хуримтлагдсан иргэний нэхэмжлэлтэй төрөөс барагдуулах хохирлын асуудлыг нэг мөр шийдвэрлэх ажлыг зохион байгуулж эхэлсэн талаар НҮБ-д Монгол улсын Засгийн газраас хүргүүлсэн илтгэлд дурьдсан нь эхлүүлсэн ажлын тодорхой үр дүнгийн нэг гэж үзэж болохоор байгаа юм.

Конвенцийн заалтын дагуу улс орон өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай нөхөн төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран халамжлагч нөхөн төлбөр авах эрхтэй гэж НҮБ-ын гишүүн орнууд тэр дундаа конвенцид нэгдэн орсон улс орнуудын дотоодын эрх зүйн тогтолцоонд шууд энэ заалтыг тусгаж өгөхөөр зохицуулсан. Харамсалтай нь манай улс энэ конвенцид нэгдэн ороод 9 жил болж байгаа боловч 2002 онд шинээр баталсан эрүүгийн байцаан шийтгэх хуулиндаа мөн 2008 онд хийсэн нэмэлт ч энэ заалтыг тусгаагүй байна. Гэтэл практик дээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд эрүү шүүлт тулгуулж бие махбодь, сэтгэл санаа,

эд материалаараа хохирсон иргэд хохирлоо арилгуулахаар шүүхэд хандсаар байгаа бөгөөд энэ төрлийн нэхэмжлэлийг шүүхэд хүлээн авч шийдвэрлэхэд хүндрэлтэй.

Өнөөдрийн байдлаар практикт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд эрүү шүүлт тулгуулсны улмаас хохирсон хохирогч нарын хохирлыг хэрхэн арилгах талаар Монгол Улсын дээд шүүхийн гаргасан тайлбарыг л ганцхан энэ төрлийн нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэхдээ шүүхийн практикт<sup>4</sup> хэрэглэж байна.

Мөн хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлж байсан, сэтгэл санаагаар нь дарамталсан, хүүхдийг хүчирхийлэлд байлгасан нагац ахынх нь талаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 16,17 дугаар зүйлийг үндэслэн Баянгол дүүргийн шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргаж практикт анх удаа хэрэглэж гомдол гаргасан хүүхдийн нагац ахыг нь тухайн хүүхэдтэй 3 сараар уулзах уулзалтыг хориглож, 7 хоногийн хугацаанд зан үйлд нөлөөлөх албадан сургалтанд хамруулахаар хянан шийдвэрлүүлсэн бөгөөд энэ нь тодорхой үр дүнд хүрсэн байна. Мөн Гэр бүлийн тухай хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан ... гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн хүүхдийг ялгаварлан гадуурхаж эрх ашгийг хохироохыг хориглоно. Эцэг эх нь хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалж, хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, асран хамгаалах, тэжээн тэтгэх үүрэгтэй... гэж заасны дагуу төрсөн хүүхдийн эрхийг хамгаалах үүднээс төрсөн эцгээс хүүхдийн асрамж хамгаалалтанд зориулан 13.5 сая төгрөгийг

<sup>4</sup> Монгол Улсын Засгийн газраас Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд хүргүүлсэн илтгэлээс., УБ., 2010 он.

гаргуулан эхэд нь олгуулахаар мөн Баянгол дүүргийн шүүхээс шийдвэрлэсэн байна. Энэ гаргасан төлөөлөн нэхэмжлэл нь эх хүүхдийн эрх ашгийг хамгаалахад хуулийн байгууллагуудын шийдвэр ямар их нөлөөтэй болохыг амьдралд харуулсан шийдвэр болсон гэж үзэхээр байна.

Комисс төлөөлөн нэхэмжлэлийг гаргахдаа тухайн иргэний (хохирогчийн) хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд болон прокурорын шүүхийн шатанд хоригдож байсан хугацаагаар нь түүний олох ёстой байсан бодит орлогыг тухайн үед мөрдөгдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож гаргах, өмгөөлөл болон хууль зүйн туслалцаа авахад зарцуулсан төлбөрүүд, сэтгэл санаа, эрүүл мэндийн хохирол, нэр төр, алдар хүндээрээ хохирсон хохирлыг цугларсан нотлох баримтыг үндэслэн хохирлын хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлэн гаргадаг. Төлөөлөн нэхэмжлэл гаргах явцад гардаг хамгийн хүндрэлтэй зүйл бол яахын аргагүй сэтгэл санааны болон эрүүл мэндийн хохирлыг тооцож гаргах асуудал байдаг. Төлөөлөн нэхэмжлэлийн энэ хэсгийн үнийн дүнг өөрийн бие махбодоороо туулсан, давсан, сэтгэл санааны хувьд тогтворгүй айсан, шаналсан тухайн хувь хүн өөрөө гаргадаг бөгөөд үүнийг бид ямар нэгэн засвар, тайлбар хийлгүйгээр төлөөлөн нэхэмжлэлд шууд тусгадаг бөгөөд үүнийг шүүх шийдэхдээ өөрийн дотоод итгэл дээрээ тулгуурлан тухайн үнийн дүнгээс ямар үндэслэлээр хасаж шийдвэрээ гаргаж байгаа нь тодорхойгүй байдаг. Тэр байтугай олон хоног сараар хоригдсон хүнийг сэтгэл санаагаараа хэрхэн яаж хохирсноо батал гэсэн шаардлага тавьж

байгаа нь шүүгч нарын чадвар чадавхитай шууд холбоотойгоос гадна олон улсын гэрээний заалтыг хэрэглэх тал дээр мэдлэг туршлага хангалтгүй байгаагийн нэг илрэл гэж үзэхээс өөр аргагүй юм.

Мөн нөгөө талаас бидэнд учирдаг зарим хүндрэлүүдийн нэг нь зарим төрлийн эрүүгийн хэрэгсэхгүй болгосон цагаатгасан хэргийн материалуудтай танилцах, төлөөлөн нэхэмжлэл гаргахад шаардлагатай материал хувилж авахад хуулийн байгууллагуудын зүгээс шалтгаан тоочсон хүндрэлүүд ихээр гарч байна.

#### Цаашид:

Төлөөлөн нэхэмжлэлийн хүрээг тэлэх тэр дундаа газар эзэмших, байгаль орчинтой холбоотой эрхүүдийн зөрчил, иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхүүдтэй холбоотой нийтийн эрх ашгийг хангах хамгаалах асуудалтай холбоотой төлөөлөн нэхэмжлэлүүдийг гаргах,

Комиссын хуульболонбусадпроцессын хууль тогтоомжуудад Комиссын оролцоо, эрх үүргийн талаар нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах, Комиссоос гарч буй эрх зүйн актуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх,

Энэ талаар мэргэшсэн хуульчдын баг, өмгөөлөгчдийн хэсгийг бий болгох, чадвар чадавхи бий болгосон сургалтуудыг тогтвортой давтамжтайгаар зохион байгуулах, шийдвэр гаргах субъектүүдэд хандсан чадавхийг бий болгох, олон улсын гэрээ конвенцийг практикт шүүх болон хуулийн байгууллагууд өргөнөөр хэрэглэдэг болгох зайлшгүй шаардлагатай байна.



## ШИНЭЧЛЭЛ БА ХОРИХ БАЙГУУЛЛАГА



### Р.ОЮУНБАДАМ

Шихихутуг Хууль зүйн Дээд  
Сургуулийн багш  
(Докторант)

Саяхан Хууль зүйн яам “Хорих байгууллага ба хүний эрх” хэлэлцүүлэг хийсэн юм.

Хэлэлцүүлгийн гол зорилго нь хорих, цагдан хорих байгууллагуудад хүний эрхийг хангах, дэлхий нийтийн жишиг стандарттай нийцүүлэх зорилгоор өнөөгийн дагаж мөрдөж байгаа журмуудад зайлшгүй шаардлагатай өөрчлөлт оруулах тухай байлаа.

Олон улсын шоронгийн системийн шинэчлэлийн чиг хандлага, дэлхий нийтийг хамарсан даяарчлалын үйл явц аливаа улс орны цагдан хорих болон хорих ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагаанд ихээхэн хамааралтай болохыг улам бүр харуулсаар байна. Иргэдийг гэмт хэргийн учир шалтгаанаар хорьж цагдах, ял эдлүүлэх ажиллагаанд шинэ шаардлага тавигдаж, түүнийг зөв шийдвэрлэх явдал зөвхөн тухайлсан нэг орны асуудал биш юм. Хорих ангийн дотоод журам,

баривчлах, цагдан хорих байрны дотоод журам, ялаас чөлөөлөх өвчний жагсаалт, хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн болон бусад байгууллагын туслалцаа үзүүлэх зэрэг хэд хэдэн журмуудад өөрчлөлт оруулах болсон шалтгаан нь эдгээр журмууд журам байх шаардлага хангаагүй, ерөнхийдөө хуулиас хуулбарласан зүйл олонтой бас өөр хоорондоо давхардалтай хүний эрхийг зөрчсөн заалт ихтэй гэдгийг тэмдэглэсэн.<sup>5</sup>

Хоригдож байгаа хүн, бусдын нэгэн адил нийгмийн халамж хүртэх, бие бялдарын болон сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалуулах, эрүү шүүлтээс ангид байх, халдашгүй дархан байх, өмгөөлүүлэх, өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрх нь Монгол Улсын Үндсэн хууль тогтоомжоор хамгаалагдсан байдаг билээ.

<sup>5</sup> Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга Ж. Баярцэцэг (2012.11.02)

Олон улсын эрх зүйн баримт бичигт тухайлбал Хүний эрхийн түгээмэл тунхаглалд: хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн халамж эдлэх эрхтэй гэж заасан<sup>6</sup> бол Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад өндөр настан, хөдөлмөрийн чадвараа алдсан хүн мөн хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй болохыг заажээ<sup>7</sup>.

Хорих ялаас үүсэх үр дагавар маш их хор уршигтай, зарим талаараа арилгах боломжгүй хүний амьдралд насан туршийн хар сүүдэр дагуулдаг талтай. Иймд өнөөгийн хорих байгууллагууд хоригдлыг нийгэмшүүлэх ажил тулгамдсан асуудал болж байна. Хорих ял ямар нэг хугацаагаар эдлээд суллагдсан хүн нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй, ажил хөдөлмөр олддоггүй, олдсон ч мэргэжил дутмаг, эцэг эх нь настай болсон, нас барсан хамаатан садан нь хөндийрсөн, ял эдлэхийн өмнө байсан гэр орон эд хөрөнгө нь үгүй болсон, гэр бүл салсан гээд хүндрэл бэрхшээлийг тоочоод байвал мундахгүй их, зарим нь суллагдаад ахин гэмт хэрэг үйлдэж, шоронд олон жилтэй хүний тоог нэмэгдүүлдэг нь зарим талаараа дээрхи шалтгаантай холбоотой юм.

Иймд хорих ангийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.4-т “Иргэний үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын дэвтэргүй ялтан хуваарилагдаж ирсэн бол энэ тухай түүний хувийн хэрэгт тэмдэглэл хийж, өөрөөр нь болон байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулна” гэсэн нь хорих анги ердөө гарын үсэг зуруулаад орхидог нь ял эдлээд суллагдаж байгаа хүн бичиг баримтгүй байхаар харагдаж байна.

<sup>6</sup> Олон улсын хүний эрх., 2002 он 34 дэх тал.

<sup>7</sup> Мөн ном., 56 дахь тал.

Тэгвэл дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.4 *Иргэний үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын дэвтэр, халамжийн дэвтэргүй ялтан хуваарилагдаж ирсэн бол энэ тухай түүний хувийн хэрэгт тэмдэглэл хийж, хорих ангийн захиргаанаас бичиг баримтын бүрдлийг хангаж, хуульд заасан халамжийн үйлчилгээнд хамруулна* гэж өөрчлөлт орууллаа.

Тус журмын 6 дугаар зүйлийн 6.1-д Хүнд, онц хүнд гэмт хэрэгт шийтгүүлсэн болон чанга түүнээс дээш дэглэмд ял эдлэж байгаа ялтныг клиникийн эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төв, орон нутгийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлж эмчлэхийг хориглоно гэж байсныг *энэ заалт нь хүний эрхийг хууль бусаар хязгаарласан заалт гэж үзээд Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар баталгаажуулсан эрхийг журмаар хязгаарлаж болохгүй. Аливаа хязгаарлалтыг гагцхүү хуулиар тогтоох учиртай. Тиймээс тус заалтыг хүчингүй болгохоор тогтсон. Яагаад гэвэл энэ заалт ялтан хүнд өвчний улмаас хорих ялыг үргэлжлүүлэн эдлэх боломжгүй үед авах арга хэмжээ юм.*

Дэглэм харгалзахгүй ялтан хорих ял эдлэх явцдаа эрүүл мэндээ хамгаалуулах, эмчилгээ үйлчилгээ авах нь хавьгүй өргөн асуудал байдаг. Монгол Улсын хорих, цагдан хорих байгууллага үүсэл хөгжлийнхөө эхэн үеэс өнөөг хүртэлх 90 гаран жилийн хугацаанд хэрэгтэн ялтны эрүүл мэндийн эмчилгээ үйлчилгээг зөвхөн бие бялдарын эрүүл мэндийг хамгаалсаар ирсэн, эрх зүйн зохицуулалт нь түүнд чиглэгдэж байдаг.

Тэгвэл олон улсын хорих байгууллагууд Нидерланд, Австрали, Канад зэрэг орон

шорон дахь сэтгэлийн эрүүл мэндийн асуудлыг онцгойлон авч үздэг. Тэд сэтгэл бол өвчилдөг бас шархалдаг үхэлд ч хүргэх аюултай учир аливаа хэлбэрээр буюу баривчлагдсан хүн сэтгэлийн өвчин түгээмэл тусдаг учир шоронгийн эрүүл мэндийн үйлчилгээ сэтгэлийн эрүүл мэндээс эхлэх учиртай гэж үздэг. Тэгвэл Монгол Улсын хууль тогтоомжид сэтгэлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэсэн зохицуулалт байхгүй, тэгээд ч манай хорих ангиудад зөвхөн биеийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг гэвэл маргах хүн гарахгүй байх. Амьдрал дээр эрүүгийн гэмт хэрэгт холбогдож баривчлагдах, мөрдөн байцаалгах, цагдан хоригдох, хорих ялаар шийтгүүлэх зэрэг бүх үе шатуудад гэмт хэрэгтний сэтгэл санаа гүнзгий хямралд ордог. Сэтгэл гутрал нь бие эрхтнийг нь гэмтээдэг. Хорих ангид ирж байгаа ялтан болгон ямар нэг өвчин даралт, зүрх судас, бөөр мэдрэл гэх мэт өвчтэй тухай заавал яригддаг.

Зарим хоригдогсад сэтгэл гутралаасаа гарч чаддаггүйгээсээ болоод өөрийн биеэ бусдын дотор авч явж чаддаггүй сул дорой, бас эрх зүйн зөрчил гаргах, амиа хорлохыг завдах зэрэг үзэгдлүүд байнга гарч байдаг. Хүн төрөлхтөн хэмээх нэгэн гэр бүлийн гишүүн адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх амгалангийн үндэс мөнхийг анхааран үзэж, эдгээр эрх нь хүн бүрийн төрөлхийн нэр төрөөс урган гардгийг хүлээн зөвшөөрдөг боловч байнга шүүмжлэл дагуулдаг байна.

Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг харьцаж эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандаж нэр төрийг нь доромжилж болохгүй. Улс орон

бүр өөрийн хууль тогтоомж үйлчилдэг аливаа нутаг дэвсгэр дээр эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжилон харьцах, шийтгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор байцаалт явуулж байгаа аргачлал, үйл ажиллагаа, цагдан хорих нөхцөл, тэдгээртэй харьцаж буй байдалд тогтмол хяналт тавьж байх ёстой гэж заажээ. Практикт манай хорих байгууллагын ажилтнууд эрүү шүүлт хүнлэг бус харилцааг зодох, занчих, гавлах, бороохойдох, харааж зүхэх гэх мэт их томоор ойлгоод байдаг.

Гэтэл тийм биш сэжигтэн яллагдагч ялтангай харилцах харилцааны хандлагаас хамаарна. Тэднийг хүн гэдэг үүднээс хүний ёс, хүнлэг энэрэнгүй ёсыг ямагт санаж хүн гэдэг нэрээр хүндэтгэх харьцах учиртай *нөгөө тал нь ялтан гэж бодож дээрэнгүй харьцах нэрээр нь биш, хулгайчаа гэж дуудах гэх мэт зүйл нь эрүү, шүүлтийн нэг хэлбэр мөн.*

Хорих ангийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.7-д Ялтны гадуур хувцасны баруун талын энгэрт хувийн дугаар, ялтны овог нэр, эдлэх ялын эрүүгийн хуулийн зүйл анги, хугацааг харуулсан 5x8 см-ийн хэмжээтэй таних тэмдэг байна гэснийг ялтны гадуур хувцасны баруун талын энгэрт хувийн дугаар, нэрийг харуулсан 5x8 см-ийн хэмжээтэй таних тэмдэг байна гэж өөрчлөв. Хуучин журмаар Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.4-өөр 10.6 жилийн хорих ялтай чанга дэглэмтэй Доржийн Дондог гэж бичиж ялтны баруун талын энгэрт зүүлгэж байсан нь ялтнууд бие биенээ хийсэн гэмт хэргээр нь дуудах зэргээр нэр төрийг нь гутаан доромжилсон агуулгатай байв.

1992 онд Монгол Улсын Үндсэн хууль Монгол Улсын иргэн бүр халдашгүй дархан байх эрх, эрх чөлөөтэй байх, амьд явах эрхтэй гэж заасан нь хоригдож байгаа болон цагдан хоригдож байгаа хүнд нэн хамаатай. Эдгээрийн дотроос **халдашгүй дархан байх эрхийг** дараах байдлаар тайлбарлаж байна. Хоригдогчид хоригдож байх хугацаандаа эрүү шүүлтэд өртөхгүй байх, хилсээр хэрэгт тулгуулахгүй байх, хэн нэгний дарамт шаардлагад өртөхгүй байх, тэдэнд сэтгэл санааны дарамт учруулахгүй байх, эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах зэргээр тайлбарлагдана. Сэжигтэн, ялагдагч, шүүгдэгч нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчийн хувьд мөн хорих ялаар шийтгүүлсэн ч олгогдсон эрх эдлэх, үүрэг хүлээх, мэдээлэл авах, гадаад ертөнцтэй харилцах, нөхцөл сайтай байранд амьдрах, биологийн хэрэгцээ болон алдсан энергийг нөхөх хэмжээний эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнс, ундны усаар хангуулах, эмнэлгийн үйлчилгээ авах, эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг олон зүйл багтана.

Дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.9 Ялтан буцалгасан ус уух боломжтой байна гэснийг хэрэгцээтэй үед нь уух ундны усаар ангийн захиргаа хангана гэж өөрчиллөө.

Тус журмын 3 дугаар зүйлийн 3.3-т Ялтныг аль болох цөөнөөр нь байрлуулах бөгөөд нийтийн байр, тасалгаа нь өдрийн цагт байгалийн гэрэл тусах ердийн цонхтой, оройн цагаар хяналт тавих бүрэн боломж бүхий гэрэлтүүлэгтэй байна.

Гэрэлтүүлэх хэрэгслийн унтраалгыг жижүүрийн хяналтад байхаар байрлуулна гэснийг ялтныг 6-гаас дээшгүй, цөөнөөр нь байрлуулах бөгөөд нийтийн байр, тасалгаа нь өдрийн цагт байгалийн гэрэл тусах ердийн цонхтой, оройн цагаар хяналт тавих бүрэн боломж бүхий гэрэлтүүлэгтэй

байна. Гэрэлтүүлэх хэрэгслийн унтраалгыг жижүүрийн хяналтад байхаар байрлуулна гэсэн бол 4.5.3. *Хоригдсон этгээдэд сахилгын шийтгэл эдлүүлэхдээ насанд хүрээгүй болон эмэгтэй хоригдогч, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон, онц хүнд гэмт хэрэгт шалгагдаж байгаа, удаа дараагийн ял шийтгэлтэй хоригдогч нарын сахилгын шийтгэлийг тусад нь эдлүүлэхээр зохион байгуулна. Гав, дөнгө, номхруулах хэрэгслийг сахилгын шийтгэлийн журмаар хэрэглэхийг хатуу хориглоно. Хоригдсон этгээдийг эрүүдэн шүүх буюу хэрцгий хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хатуу хориглоно гэхчилэн өөрчлөлт оруулахыг хэлэлцүүлэгт оролцогчид санал нэгтэй дэмжсэн юм.*

*Энэ бүхнээс дүгнэн үзвэл*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын өнөөгийн дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийг эргэн харж цаашид боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Хорин нэгдүгээр зуун бол цахим нийгэм учраас хүмүүс цаас унших дургүй, цаг алдана гэж үзэх болсон. Үг хэллэг нь орооцолдсон урт байдгаас ойлгомжгүй уншихаас төвөгшөөдөг сул талтай. Журам нь хуулийг хэрхэн, яаж, ямар замаар хэрэгжүүлэх аргачлалыг тов тодорхой зааж өгсөн байвал үр дүнтэй. Ер нь журмын үг хэллэг аль болохоор энгийн үг хэллэгтэй, ойлгомжтой тэгсэн хэрнээ журмыг хэрэгжүүлэхгүй байхын аргагүй боловсруулагдсан байвал мөрдүүлэхэд амар хялбар, хоригдогчид журам зөрчих боломжгүй болох сайн талтай. Цаашид хорих, цагдан хорих байгууллагын ажилтнууд зөвхөн дотоодын хууль журмандаа захирагдах байдлаар мэргэжлийн төвшингөө тогтоох бус даяарчилсан өнөө үед олон улсын хорих байгууллагын чиг хандлага ямар байна гэх мэтчилэн хүний эрхийн мэдрэмжтэй байх нь мэргэжлийн ур чадварыг тодорхойлох нэг үзүүлэлт болно.

## ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ҮЗҮҮЛЭХ ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН НӨЛӨӨЛӨЛ



**П.АМАРЖАРГАЛ**  
Улсын Их Хурлын Тамгын  
газрын Судалгааны төвийн  
референт-шинжээч  
(Докторант)

Дэлхий дахинд өрнөж буй даяарчлал, эдийн засгийн интеграцийн хурдацтай холбоотойгоор улс хоорондын эдийн засгийн харилцааны цар хүрээ улам бүр өргөжин тэлж, хэлбэр, агуулгын хувьд боловсронгуй болж байгаатай холбоотойгоор түүнийг зохицуулах эрх зүйн хэм хэмжээний үйлчлэлийн хүрээ ч мөн өргөжсөөр байна. Олон улсын эдийн засгийн харилцааны цар хүрээ өргөжиж буй үйл явц нь либералчилалын үзэл санаа дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж ирсэнтэй нягт холбоотой юм. Энэхүү онцлог харилцааг зохицуулах хэм хэмжээний бүрдэл, систем буюу олон улсын эрх зүй<sup>8</sup> мөн адил дээрх зарчимд суурилах нь гарцаагүй.

Монгол Улс 1990 онд чөлөөт зах зээлийн, нээлттэй эдийн засгийн хэв

маягийг сонгож 1992 оны Үндсэн хуулиар баталгаажуулсан нь эдийн засгийн харилцааны зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх үндэс<sup>9</sup> суурийг бий болгосон. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 1 дахь хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”, мөн уг зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан<sup>10</sup> нь Монгол Улс эдийн засгийн ямар чиг баримжаатай, түүнд төрийн зохицуулалт ямар хувь хэмжээтэй байхыг тодорхойлсон харагдана.

<sup>8</sup> International law (jus gentium, law of nations) Oxford Dictionary of law. Edited by Elizabeth A.Martin Jonathan Law, Sixth edition (2006) Oxford University press., 284.

<sup>9</sup> Дэлгэрэнгүйг үзнэ үү. Профессор Н.Лүндэндорж, LL.M П.Амаржаргал. “Монголын эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага” илтгэл. “Монгол Улсын эрх зүйн шинэчлэл, Ази-номхон далайн орнуудын эрх зүйн хөгжлийн чиг хандлага” сэдэвт Олон Улсын эрдэм шинжилгээний чуулган 2011.11.10-11 (Улаанбаатар 2011) Soyombo printing  
<sup>10</sup> Төрийн мэдээлэл эмхтгэл 1992 №1

Монгол Улс ийнхүү эдийн засгийн либералчилалын үзэл баримтлалыг хүлээн авснаар олон улсын эдийн засгийн эрх зүйн харилцааны идэвхитэй оролцогч болсон. Олон улсын эдийн засгийн эрх зүй нь олон улсын эрх зүйн<sup>12</sup> нэг бүрдэл хэсэг болох тул олон улсын эдийн засгийн харилцааны эх сурвалж нь олон улсын эрх зүйн хэм хэмжээ байна.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь уг харилцаанд оролцогч субъектууд өөрсдөө буюу тодорхой улс орнууд эсхүл олон улсын байгууллагуудаар тогтоогддоогоороо үндэсний эрх зүйн системээс ялгагддаг<sup>13</sup>. Ингэхдээ олон улсын эдийн засгийн эрх зүйн хэм хэмжээ нь талуудын зөвшилцлийн үндсэн дээр бий болдог учраас заавал биелэгдэх механизм нь санкц, шийтгэлийн хэм хэмжээнээс илүүтэйгээр эдийн засгийн бусад арга хэрэгслүүдээр хангагддаг онцлогтой. Тухайлбал, аливаа улс нь олон улсын эдийн засгийн эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд бойкот, экспортын хориг (эмбарго), бүслэлт, фондыг хасах, хөрөнгийг битүүмжлэх зэрэг арга хэмжээ авдаг байна.<sup>14</sup> Өөрөөр хэлбэл, олон улсын эдийн засгийн эрх зүйн зохицуулалтыг бий болгогч гол субъектууд нь төр болон олон улсын байгууллагууд байдаг.

Олон улсын эдийн засгийн эрх зүйн хэм хэмжээг бий болгож байдгийн хувьд төр өөрөө эдийн засгийн харилцаанд оролцогч

<sup>12</sup> Black's Law Dictionary. Editor in chief. Bryan A. Garner. Eighth edition (2004); Oxford Dictionary of law. Edited by Elizabeth A. Martin Jonathan Law, Sixth edition (2006) Oxford University press; М.Дүгэрсүрэн, Ч.Хосбаяр Олон улсын эрх зүй (1999)

<sup>13</sup> Joel P. Trachtman, The International Economic Law Revolution, University of Pennsylvania Journal of International Economic Law Spring, (1996) 17 U. Pa. J. Int'l Econ. L. 33

<sup>14</sup> Мөн тэнд 85-86 дахь тал

нэг субъект болж байдаг. Энэхүү олон улсын эрх зүйн хэм хэмжээг бий болгох журам нь тухайн улсын эрх зүйн үндсэн акт болох Үндсэн хууль, түүнээс салбарлан гарсан эрх зүйн бусад зохицуулалтаас хамааралтай байдаг. Тухайлбал, манай улсын хувьд олон улсын гэрээ байгуулах бүрэн эрх нь Засгийн газарт байдаг боловч үндэсний аюулгүй байдлын үүднээс улсын бүрэн эрхт болон аюулгүй байдал, нутаг дэвсгэр, улсын хил болон хүний салшгүй эрх, хууль тогтоомжид зааснаас өөр журам тогтоосон, төсвөөс гадуур нэмэлт хөрөнгө шаардах, зээлийн хэлэлцээрүүд болон талууд соёрхон батлахаар тохирсон бусад олон улсын гэрээ хэлэлцээрийг Улсын Их Хурлаас зөвшөөрөл авч соёрхон батлуулахаар заасан байдаг.

Ийнхүү олон улсын эдийн засгийн эрх зүйн хэм хэмжээг бий болгож, түүндээ захирагдах бүрэн эрх нь Монгол Улсад Үндсэн хуулийн дагуу олгогдсон байдаг. Гэвч эдгээр хэм хэмжээг бий болгосноор үүсэх эдийн засгийн (ашиг сонирхлын) болон хууль зүйн асуудлуудыг авч үзье.

#### Эдийн засгийн асуудлын талаар

Аливаа эрх зүйн хэм хэмжээ нь түүний зохицуулалтад захирагдах эсхүл хамаарагдах субъектуудын эдийн засгийн ашиг сонирхлыг хөндөж, эргээд тэдгээр субъектуудын гаргах эдийн засгийн зан байдлын хүрээг урьдчилан тодорхойлж, түүгээр дамжин эдийн засагт нөлөөлж байдаг<sup>15</sup>. Тэгвэл эрх зүйн хэм хэмжээний эдийн засгийн анализ гэсэн судлагдахууны үүднээс авч үзвэл олон улсын эдийн засгийн эрх зүйн хэм хэмжээг бий болгохдоо түүнээс гарах эдийн засгийн үр дагаврыг урьдчилсан байдлаар тандан

судалсан байх шаардлагатай гэсэн логик санаа харагдаж байна.

Олон улсын эдийн засгийн харилцааны хоёр болон олон талт гэрээ хэлэлцээрийг байгуулахдаа асуудлыг сайтар судлах шаардлагатай байгаа нь Үндсэн хуульд нийцүүлэн байгуулсан олон улсын гэрээний заалт<sup>16</sup> нь үндэсний хууль тогтоомжоос давуу байдлаар мөрдөгдөх эрх зүйн хүчин чадалтай холбоотой.

Тодруулбал, тодорхой салбарын хууль тогтоомжийн хүрээг тогтоохдоо хуулийн заалтад “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэсэн заалт бүхий хууль олон байдаг<sup>17</sup>.

Олон улсын гэрээний заалт нь үндэсний хууль тогтоомжтой зөрчилдсөн тохиолдолд олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөх энэхүү зарчим нь Монгол Улсын хувьд олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ чанд мөрдөх, үндэсний

хууль тогтоомжийн хүрээнд хийдлийг арилгах зэрэг давуу тал байдаг боловч дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын хууль тогтоомжуудаас тэр бүр ийм заалтуудыг олоход хүндрэлтэй<sup>18</sup>.

Хуульд ийм заалтыг хэвшмэл маягаар буюу тусгайлсан зорилгогүйгээр оруулах нь зохимжгүй юм. Учир нь зохих журмын дагуу байгуулагдсан олон улсын гэрээний заалтууд нь үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил, зарим тохиолдолд давуу байдалтайгаар үйлчлэх тул олон улсын эдийн засгийн эрх зүйн хэм хэмжээг бий болгохдоо түүний эдийн засаг, нийгмийн салбарт хэрхэн нөлөөлөхийг сайтар анхаарах хэрэгтэй байна.

Олон улсын гэрээний тухай хуулиар гэрээ байгуулах, гарын үсэг зурах асуудлыг нарийвчлан тодорхой зохицуулсан байх боловч гэрээ байгуулахын өмнөх шатанд зайлшгүй хийх ёстой судалгаа, шинжилгээний асуудлыг хуулиар тодорхой зохицуулаагүй байна. Ялангуяа хөрөнгө оруулалт, чөлөөт худалдааны хэлэлцээр зэрэг эдийн засгийн салбарт шууд нөлөөлөх гэрээ, хэлэлцээрүүдийг байгуулах, энэ талаар санал гаргахдаа тодорхой эдийн засгийн анализ судалгаа, шинжилгээнд үндэслэж байхыг хуульчилан зааж өгөх нь зүйтэй. Тухайлбал, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах талаар ярилцахын өмнө манай улсын ашиг сонирхол, манай үндэсний үйлдвэрлэгч, худалдаачдад ирэх ашгийн талаар тодорхой мэдээлэл, тооцоотой байх зэргээр өөрсдийн ашиг сонирхлыг

<sup>15</sup> Richard Posner. *Economic Analysis of Law*. Aspen publisher (2007)

<sup>16</sup> Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дах хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” гэж заасан байдаг. Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 №1. Өнөөдөр Монгол улсад олон талт гэрээ 1200, хоёр талт гэрээ 240 даган мөрдөгдөж байна.

<sup>17</sup> Жишээлбэл, зөвхөн бизнесийн салбарын 70 гаруй хууль тогтоомжоос Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 2.2, Газрын хэвлийн тухай хуулийн 2.2, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 2.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2.2, Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 2.2, Банкны тухай хуулийн 2.2, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 2.2, Дампуурлын тухай хуулийн 2.2 зэрэг 40 гаруй хуульд Монгол Улсын олон улсын гэрээний заалт нь үндэсний хууль тогтоомжоос өөр бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөх тухай заалт байна.

<sup>18</sup> Миний бие Нагоягийн Их сургуулийн хуулийн сургуулийн магистрантурт суралцаж байхад “Олон Улсын эдийн засгийн эрх зүй” хичээлийн профессор багш манай улсын олон хууль тогтоомжид ийм заалт байдгийг ихэд гайхан сонирхож байсан билээ. П.А

тэргүүн ээлжинд тодорхойлсон байх шаардлагатай.

Олон улсын харилцаанд баримтлах үндсэн зарчмыг тодорхойлдог Англи Улсын Ерөнхий сайд асан У.Черчелийн хэлсэн үг болох “Мөнхийн дайсан гэж байхгүй, харин мөнхийн ашиг сонирхол гэж байна” гэснийг олон улсын эдийн засгийн хэм хэмжээг бий болгохдоо хамгийн түрүүнд анхаарах ёстой болов уу.

Өнөөдөр энэ асуудлыг гаргаж тавих шаардлага үүсээд байгаа нь дэлхийн нийтийн чиг хандлагаас гадна манай улсын олон улсын эдийн засгийн эрх зүйн харилцаанд оролцож ирсэн туршлага, түүхтэй холбоотой юм. Манай улсын хувьд 1990 ээд оныг хүртэл хуучнаар Зөвлөлт социалист бүгд найрамдах холбоот улс (ЗСБНХУ), Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн хүрээнд хийгдэж байсан буюу улс орны тусгайлсан ашиг сонирхлоос илүүтэйгээр социализмыг байгуулах гэсэн зорилтын хүрээнд шийдвэрлэгдэж ирсэн.

Үүний дараагийн шатанд буюу зах зээлийн нээлттэй эдийн засагт шилжих үйл явцын хүрээнд олон улсын байгууллагуудад нэгдэн орох замаар хөнгөлөлттэй зээл авах чиглэлээр голчлон гэрээ хэлэлцээрүүд байгуулсан байдаг. Үүнд мөн л адил өөрийн ашиг сонирхлыг тодорхойлохоос илүүтэйгээр олон улсын байгууллагаас тавьсан шаардлагад нийцүүлэн, улс орны дотоодын тулгамдаад байгаа эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байсныг үгүйсгэхгүй бизээ.

Иймд манай улсын хувьд сүүлд байгуулсан эдийн засгийн хамтын ажиллагаа, олон талт болон хоёр талт

хөрөнгө оруулалтын гэрээнүүд зэрэгт дүн шинжилгээ хийх нь хуульч, эдийн засагчдын хамтын үүрэг болоод байна.

Харин сүүлийн хэдэн жилийн байдлаар ашигт малтмалын ордуудыг ашиглах болсон, дэлхийн зах зээл дээр ашигт малтмалын түүхий эдийн үнэ өссөн зэрэгтэй холбогдуулан эдийн засгийн өсөлт бий болсон зэрэг шалтгаанаар олон улсын санхүүгийн байгууллагуудын зээл тусламжид хамаарах нөхцөл ч өөр болж байна. Энэ тохиолдолд өөрсдийн ашиг сонирхлыг зөв тооцоо, судалгаатайгаар тодорхойлж гэрээ, хэлэлцээр байгуулах асуудлыг төрийн бодлогын хэмжээнд авч үзэх шаардлагатай байна. Энэ нь хэн гэрээ байгуулах эрхтэй эсэх асуудалд маргаж байгаа бус, харин гэрээ хэлэлцээр байгуулахдаа үндэслэл, судалгаатай байх шаардлагыг хуульчилж өгөх нь зүйтэй гэсэн санаа юм.

Аливаа гэрээнд нэгдэхэд хариуцлага үүсдэг. Түүнийг дааж чадах эсэхээ өмнө сайн бодох, судлах ёстой буюу “долоо хэмжиж нэг огтлох” гэдгийг санавал олон улсын гэрээнд яаран нэгдэж байх албагүй юм. Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцид улс орнуудын хувьд гэрээгээр хүлээсэн амлалт, үүргийн заавал биелэгдэх шинж чанарыг тодорхой заасан байдаг<sup>19</sup>.

<sup>19</sup> 1969 онд батлагдаж, 1980 оноос хүчин төгөлдөр болсон Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцид Монгол Улс 1988 онд нэгдэн орсон бөгөөд уг Конвенцийн 27 дугаар зүйлд “Оролцогч улс гэрээг биелүүлэхгүй байгаагаа зөвтгөхийн тулд дотоодынхоо эрх зүйн заалтыг баримтлан зааж үл болно. Энэ журам 46 дугаар зүйлд хохирол учруулахгүйгээр үйлчилнэ”, 46 дугаар зүйлд “Тухайн улс гэрээг заавал биелүүлэх зөвшөөрлөө хүчингүй гэж үндэслэхийн тулд гэрээ байгуулах эрх хэмжээний талаархи дотоодын хуулийн аль нэг заалтыг зөрчиж уг зөвшөөрлөө илэрхийлсэн гэсэн тохиолдолд хэрэв уг зөрчил нь илэрхий биш бөгөөд, дотоодын онцгой чухал ач холбогдол бүхий эрх зүйн хэм хэмжээг хөндөөгүй бол тийм чиг баримтлах эрхгүй” гэж заасан байна. ТМ, Тусгай дугаар, II боть. 2005



### Хууль зүйн асуудлын талаар

Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн байгуулсан<sup>20</sup> олон улсын гэрээний заалт<sup>21</sup> нь үндэсний хууль тогтоомжоос давуу байдлаар мөрдөгдөх эрх зүйн хүчин чадалтай байгаатай холбоотой үүсээд байгаа эдийн засгийн асуудлыг өмнөх хэсэгт товч авч үзсэн бол уг асуудалд хууль зүйн логикийн үүндээс хийсэн шинжилгээгээ товч хөндөж тавья. Тодруулбал, “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэсэн заалт нь Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлийг дангаар хэрэгжүүлэх үзэл баримтлалтай хэрхэн нийцэж байгаа талаар авч үзэх зайлшгүй шаардлагатай.

Хуулийн дээрхи заалт дахь “олон улсын гэрээ” гэдгийг хууль тогтоомжид хэрхэн тодорхойлсныг авч үзье. Олон улсын гэрээний тухай хуулиар олон улсын гэрээг “Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх

зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоо” гэж тодорхойлжээ<sup>22</sup>. Эндээс үзвэл олон улсын гэрээг байгуулах субъектууд нь Улсын Их Хурал (УИХ), Засгийн газар байна. Гэтэл уг хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Монгол Улсын нэрийн өмнөөс улс хоорондын олон улсын гэрээ байгуулах, яам, тусгай газрууд Засгийн газраас эрх олгосноор олон улсын гэрээ байгуулах эрхтэй зэргээр энэ заалтыг өргөжүүлэн, бас зөрчилдүүлэн заасан байх боловч энэхүү өгүүллийн хүрээнд судлаачийн хувьд зөвхөн Засгийн газар, УИХ-ын олон улсын гэрээ байгуулах бүрэн эрх, түүнээс үүсэх хууль зүйн асуудлыг авч үзсэн.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд зааснаар Засгийн газар нь “Улсын Их Хуралтай зөвшилцөн дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын өмнөөс олон улсын гэрээ байгуулах”, “Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах, цуцлах асуудлыг шийдвэрлэх” бүрэн эрхтэй ба Олон улсын гэрээний гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газар нь Улсын Их Хурлаар соёрхон батлуулахгүй олон улсын гэрээ байгуулах шийдвэрийг гаргана<sup>23</sup>.

<sup>20</sup> Монгол Улсын Их Хурлын тухай хууль 4 дүгээр зүйл болон Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 15 дах хэсэг “Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах” Төрийн мэдээлэл эмхтгэл 2006 №8

<sup>21</sup> Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дах хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”, мөн зүйлийн 4 дах хэсэгт “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” гэж заасан байдаг. Төрийн мэдээлэл эмхтгэл 1992 №1.

<sup>22</sup> Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйл

<sup>23</sup> Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйл. “1. Монгол Улсын Их Хурлаар дараа соёрхон батлуулахаар байгуулах олон улсын гэрээний төслийн талаар Засгийн газар зохих журмын дагуу Монгол Улсын Их Хуралтай зөвшилцөж, шийдвэр гаргана. 2. Монгол Улс болон Засгийн газрын өмнөөс байгуулах бөгөөд Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлуулахгүй олон улсын гэрээний төслийн талаар хэлэлцээ хийх, гарын үсэг зурах тухай шийдвэрийг Засгийн газар гаргана”.

Засгийн газрын дээрх бүрэн эрхийнхээ хүрээнд УИХ-аар соёрхон батлуулахгүйгээр байгуулсан “олон улсын гэрээ” нь Монгол Улсын цорын ганц хууль тогтоогч болох Улсын Их Хурлаас баталсан хуулиас давуу хууль зүйн хүчин чадалтай болохоор байгаа нь хууль дээд хүчин чадалтай байх, эрх зүйт төрийн зарчмуудтай шууд зөрчилдөж байна.

Улсын Их Хурал олон улсын гэрээ байгуулах бүрэн эрхтэй. Гэхдээ энэ эрхээ хэрхэн хэрэгжүүлэхийг хуульд тодорхой заагаагүй боловч УИХ-ын энэхүү бүрэн эрхийг Олон улсын гэрээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2-т заасан “парламент хоорондын хамтын ажиллагааны асуудлаар хоёр болон олон талын гэрээ байгуулах эрх”-ийн хүрээнд хязгаарлан ойлгож болохгүй. Учир нь Монгол Улсын Их Хурлын тухай хууль 4 дүгээр зүйл болон Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 15 дах хэсэгт зааснаар “Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах” бүрэн эрх Улсын Их Хуралд байна. Эндээс үзэхэд Улсын Их Хурал нь олон улсын гэрээ байгуулах бүрэн эрхээ олон улсын гэрээг “соёрхон батлах” замаар хэрэгжүүлэх хууль зүйн боломжтой байна. Энэ нь ч олон улсын жишигт нийцнэ.

Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах гэрээнд “Монгол Улсын хууль тогтоомжид зааснаас өөр журам тогтоож байгаа” гэрээ хамаардагаас үзэхэд хуулийн дээрхи бичвэрт заасан олон улсын гэрээг байгуулах нь зөвхөн Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарч байна.

Иймд хууль зүйн асуудал үүсгээд байгаа, эрх зүйт төрийн зарчимтай зөрчилдөөд байгаа, УИХ-ын бүрэн эрхэд халдсан шинжтэй “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэсэн заалтыг “зөвхөн Улсын Их Хурлаас соёрхон баталсан олон улсын гэрээ” гэсэн утгаар тайлбарлан хэрэглэх нь зохистой байна. Гэхдээ цаашид үндэсний хууль тогтоомжоос дээгүүр болон ижил хүчин чадалтайгаар үйлчлэх олон улсын гэрээ байгуулах, хуулийн зохицуулалтыг эрх зүйт ёсны зарчим, Үндсэн хуулиар Улсын Их Хуралд олгогдсон бүрэн эрхэд нөлөөлөхгүй байхаар өөрчлөх шаардлагатай байна.

Энэхүү өгүүллийн хүрээнд дараахь дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

**Нэгдүгээрт**, олон улсын эдийн засгийн эрх зүйн системийг бий болгох, хөгжүүлэх үйл явц нь үндэсний эдийн засаг, нийгмийн ашиг сонирхол дээр суурилах тул эдийн засгийн судалгаа, үндэслэлтэйгээр гэрээ хэлэлцээр байгуулах асуудлыг хуульчилан зааж өгөх нь манай улсын хувьд нэн шаардлагатай байна.

**Хоёрдугаарт**, Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Үндсэн хуультай зөрчилдөөгүй олон улсын гэрээ нь үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил мөрдөгдөх буюу хүчин чадлын хувьд үндэсний хууль тогтоомжтой ижил байна. Гэтэл салбарын хууль тогтоомжуудын 60-аас доошгүй хувьд олон улсын гэрээ нь үндэсний хууль тогтоомжтой зөрчилдвөл олон улсын гэрээг дагаж мөрдөх зохицуулалт тусгагдсан байна. Энэ тохиолдолд тухайн салбарт олон улсын гэрээ нь Үндсэн

хуулийн дараа орох эрх зүйн эх сурвалж гэж тооцогдохоор байна. Хэдийгээр энэ нь хууль тогтоогчийн шийдвэрээс хамааралтай асуудал боловч ийнхүү олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжоос илүү хүчин чадалтайгаар дагаж мөрдөх нөхцөл, шалгуурыг тодорхой болгох шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл ямар салбар, ямар хүрээний хууль тогтоомжид олон улсын гэрээний заалтыг үндэсний хууль тогтоомжоос давуутайгаар мөрдөх, алинд нь үндэсний хууль тогтоомж давуутай үйлчлэхийг тодорхой болгох хэрэгтэй юм.

**Гуравдугаарт**, одоогийн байдлаар олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил, зарим тохиолдолд давуу байдалтайгаар үйлчлэх

зарчим ажиглагдаж байх тул олон улсын эдийн засгийн эрх зүйн хэм хэмжээг бий болгосноор үүсэх эдийн засгийн үр дагаврыг урьдчилсан байдлаар тандан судлах аргачлалыг боловсруулах шаардлага гарч байна. Тухайлбал, эрх зүй дэх эдийн засгийн анализын аргыг хэрэглэх боломжийг эрэлхийлэхэд эдийн засгийн болон хуулийн салбарын судлаачдын хамтын ажиллагаа чухал байна.

**Дөрөвдүгээрт**, олон улсын гэрээ, хэлэлцээр нь үндэсний хууль тогтоомжтой адил болон дээгүүр хүчин чадалтай үйлчлэхээр заасан хуулийн заалтуудыг Улсын Их Хурлын хууль тогтоох бүрэн эрх (Үндсэн хуулийн 20, 25 дугаар зүйл), эрх зүйт төрийн зарчимд нийцүүлэн тайлбарлах, засаж залруулах хэрэгтэй байна.

## ЦӨӨНХИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙН АСУУДАЛ



### С.АЙНАГУЛ

Казах эмэгтэйчүүдийн  
Арулар Холбооны тэргүүн  
(Докторант)

#### Нэг. Олон Улсын бичиг баримтад эмэгтэйчүүдийн эрхийн асуудал тусгалаа олсон нь

Иргэний ардчилсан нийгэм байгуулж буй аливаа улс оронд эмэгтэйчүүдийн нийгэмд болон өрх гэрт гүйцэтгэж буй үүргийг нь бодитой үнэлж, олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн хэм хэмжээний хүрээнд хүндэтгэлтэй ханддаг билээ.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц нь эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар олон улсын хуулийг мөрдсөн баримт бичиг юм. Энэхүү конвенцид элссэн улс орнуудыг эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг арилгах, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрхийг хангахад НҮБ-аас гаргасан зарчмыг даган хэрэгжүүлэх үүрэг амлалтуудаа биелүүлэхийг тунхагладаг. Конвенцийн 1 дүгээр зүйлд

“Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах гэсэн ойлголт нь эмэгтэйчүүдээс тэдний гэр бүлийн байдлаас хамаарахгүйгээр эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон аливаа салбарт хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх, хэрэгжүүлэхэд нь хүйсээр ялгах буюу хязгаарлахыг хэлнэ” гэж тодорхойлсон байна.<sup>24</sup> Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах байдал байсаар байгаа бөгөөд энэ нь нэг талаар эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо нь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах найдвартай баталгаа болж чадахгүй байгаатай, нөгөө талаар зарим орнууд олон улсын өмнө хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаатай холбоотой юм.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах нь тэгш эрх, хүний нэр төрийг хүндэтгэх

<sup>24</sup> Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуургах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенц

зарчмыг зөрчиж байгаа хэлбэр бөгөөд улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоог эрэгтэйчүүдийнхтэй адил төвшинд бүрэлдүүлэхэд бэрхшээлийг учруулж, гэр, нийгмийн амьдралын хүрээнд дэвжин дээшлэхэд саад тотгор болж байна. Конвенцид улс орнуудын тэгш хөгжил, дэлхий нийтийн сайн сайхан, энх тайвны асуудлуудыг шийдвэрлэхэд эмэгтэйчүүдийн оролцоог бүрэн дүүрэн ашиглах хэрэгтэйг заасан билээ. Тухайн Конвенцид нэгдсэн улс орнуудаас авсан үүрэг амлалтуудын талаар 30 заалт байдаг. Нэгдсэн улс орнуудаас конвенцийн заалтыг хэрэгжүүлэх нааштай арга хэмжээ авахыг шаарддаг бөгөөд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах хэлбэрийг арилгах ба хамгаалах нааштай бөгөөд шийдвэртэй олон талын арга хэмжээ авахыг заасан байдаг. Конвенц нь улс орнуудаас иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгмийн ба соёлын салбаруудад эрхээ эдлэх явдлыг хэрэгжүүлэхийг шаардахдаа Конвенц нь 16 зүйлийн 60 гаруй заалтад нийгмийн амьдралын тодорхой салбаруудад ялгаварлан гадуурхаж байгааг тодорхойлон, энэ салбарууд дахь ялгаварлан гадуурхах явдлыг арилгах тухай заасан байна.

Конвенцийн зарим заалтуудын агуулгыг тоймлон авч үзье. Үүнд:

- 1 дүгээр хэсгийн 1-6 дугаар зүйлүүдэд эмэгтэйчүүдийг чадавхижуулах талаар зохистой арга хэмжээ авахаа улс орнууд зөвшөөрсөн байна.
- Конвенцийн 2 дугаар хэсгийн 7-9 дүгээр зүйлүүдэд улс төрийн болон нийгмийн салбарт эмэгтэйчүүдийн эрхийг

хамгаалах арга хэмжээ авахыг заасан. Эмэгтэйчүүдэд сонгох ба сонгогдох эрхийг эрэгтэйчүүдтэй адил тэгш олгох, төр засгийн болон төрийн бус байгууллагын эрх барих хэрэгт оролцуулах, олон улсын хэмжээнд улс орноо төлөөлөн ажиллах эрхийг нь эдлүүлэхийг заажээ. Түүнчлэн эмэгтэйчүүдийн болон тэдний үр хүүхдүүдийн үндэстний тэгш эрхийг баталгаажуулахаар зөвшөөрсөн байдаг.

- Конвенцийн 3 дугаар хэсгийн 10-14 дүгээр зүйлд боловсрол, ажил хөдөлмөр эрхлэх, эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн болон соёлын салбаруудын амьдралд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахгүй байхаар олон төрлийн үүргүүдийг амласан байна. Үүний зэрэгцээ хөдөөгийн эмэгтэйчүүдэд тохиолддог онцлог асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор хөдөө нутгийг хөгжүүлэх, тэндээс хувь хүртэхэд эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдийн нэгэн адил оролцуулахыг улс орнууд амласан байна.

- Төгсгөлийн 4 дүгээр хэсгийн үндсэн заалтанд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн гэр бүлийн хүрээнд дэх тэгш эрхийг хуулиар баталгаажуулахаар хүлээн зөвшөөрсөн байдаг юм.

**Хоёр. Казах-үндэстний цөөнхийн эмэгтэйчүүдийн улс төрийн идэвхи, жендэрийн асуудал**

Дээрхи олон улсын бичиг баримтуудын - конвенцуудын үзэл санаа Монголд хэрхэн хэрэгжиж, түүний дотор эмэгтэйчүүдийн эрх хэрхэн хамгаалагдсаныг авч үзье.

Монгол Улсын үндэстэн ястны эмэгтэйчүүдийн нийгмийн харилцааны суурь ижилхэн байсан ба уламжлалаар

эмэгтэйчүүд голдуу гэрийн ажилтай байв.

Түүхэн талаас нь авч үзвэл, 1930 оны 9 дүгээр сард казахын Шеруши хошуунд болсон иргэдийн хуралд 450 хүн оролцсон ба үүний 10 хувь нь эмэгтэйчүүд байсан байна. Энэ үеээс эхлэн эмэгтэйчүүд иргэдийн дунд явуулах ухуулга сурталчилгаанд оролцож эхэлсэн нь казах иргэдийн дунд шинэлэг зүйл болов. Тухайн үед эмэгтэйчүүдийн идэвхи, тэдний эрчүүдтэй адил тэгш эрх эдэлсэн байдлыг ойлгохгүй байсан тал бий. Энэ үеэс иргэдийн дунд байгуулагдсан намын болон залуучуудын үүсгэл санаачлагын олон нийтийн байгууллагууд эмэгтэйчүүдийг эрхээ эдлэх хязгаарлагдмал байдлаас чөлөөлсөн байна. 1930 оныг хүртэл казах эмэгтэйчүүдийн улс төрийн эрх хязгаарлагдмал байсан ба тэднийг зөвхөн гэр орны ажил хийлгэх зэргээр эрхийг хязгаарлаж ирсэн, харин 1930 оноос эхлэн нам, эвлэлийн байгууллагад сонгогдох, сонгох эрх эдлэх болж, сүй, бэлэггүй хүнтэй гэрлэх, өөрийн хүсэлтээр нөхөрт гарах зэргээр эрхээ эдлэх болжээ. 1930 оны 6 дугаар сард Ахбалших буюу Улаанхус суманд анхны улс төрийн байгууллага болох МАХН-ын үүр 22 гишүүнтэй байгуулагдсаны 2 нь эмэгтэй байв.

Аймгийн Эмэгтэйчүүдийн байгууллага анх 1930 онд нам, эвлэлийн байгууллагатай хамт Улаанхус суманд үүсэн байгуулагдаж, даргаар нь 17 эмэгтэй ажилласан байна.

1930 оны үед баян эрчүүдийн олон эхнэрүүдэд эрх чөлөө олгогдож, залуу охид өөрийн хүсэлтээр нөхөрт гардаг болсон байна. Тухайн үед ийм эмэгтэйчүүдийн тоо 30 хүрсэн аж. Үүний зэрэгцээ казах

эмэгтэйчүүдийн боловсролд анхаарч, суралцуулан, улс төрийн идэвхийг нь өрнүүлж, нам, төрийн ажилд оролцуулсан байна. Зөвхөн 1930 оны байдлаар Шеруши хошуунаас намын хорооны тэргүүлэгчээр 2, залуучуудын байгууллагын тэргүүлэгч гишүүнээр 5 эмэгтэй сонгогдон ажиллажээ.<sup>25</sup> Анхны эвлэлийн үүрийн байранд ном, сонин уншиж, оёдлын машин ажиллуулж сурсан байна. Тэднийг бичиг үсэгт сургаж, урлаг соёлын дугуйлан хичээллэж эхэлжээ.

Намын VII, VIII Их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Ховдод 1931 онд томоохон хурал болж, энэ хуралдаанаар авч хэлэлцсэн нэг асуудал нь сүй, бэлэг нэрээр эмэгтэйчүүдийн эрхийг зөрчих явдлыг нэг мөр хориглосон асуудал байлаа. Казах эмэгтэйчүүдийн эрхийн талаар энэ үеэс эхлэн яригдаж эхэлсэн боловч 1936 онд эмэгтэйчүүдийн эрхийг хангах шийдвэр гарч, өөрийн хүсэлтээр нөхөрт гарах, тодорхой хүрээнд сурч байсан ч энэхүү шийдвэр нь зөвхөн 1938 оноос ардын хувьсгал ялаад 17 жилийн дараа хэрэгжиж эхэлсэн байна.

1940-1981 онуудад Монгол Улсын Их болон Бага Хурал, Ардын Их Хурлуудад төлөөлөгч, тэргүүлэгчээр сонгогдож нийт 16 эмэгтэй ажиллаж байсан байна.<sup>26</sup> 1940 онд болсон Улсын VIII Их Хурлын төлөөлөгч, Улсын Бага Хурлын гишүүн бөгөөд Тэргүүлэгчээр анх удаа жирийн ажилчин эмэгтэй сонгогдсон нь казах эмэгтэйчүүдийн хувьд түүхэн асуудал

<sup>25</sup> А.Сарай. Хувьсгалын дараах Баян-Өлгийн казах, урианхайчууд. Эрдэнэт. 1999 он. 25 дах тал.

<sup>26</sup> Рысбек. Ардын хурал буюу орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагын үүсэл хөгжлийн түүхэн товчоон. УБ. 2007 он. 90 дэх тал.

байлаа. Тэрчлэн МАХН-ын Х Их хурлын төлөөлөгч, Улсын Бага Хурлын гишүүнээр сонгогдон ажилласан хоёр казах эмэгтэй энэ сонгуульт ажилд идэвхтэй зүтгэж, Баян-Өлгий аймгийг шинээр байгуулах Улсын комиссын гишүүнээр ажиллаж, казах, урианхайчуудын хүүхдүүдийг гадаад, дотоодод сургах, аймгийн нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулах талаар тодорхой санал дэвшүүлж, жинтэй хувь нэмэр оруулсан хүмүүс юм. 1940 оноос эхлэн эх орны улс төрийн амьдралд казах эмэгтэйчүүд ийнхүү идэвхтэй оролцож эхэлсэн гэж хэлж болохоор байна.

Ардчилсан шинэ тогтолцоонд шилжсэн сүүлийн 20 жилд Ардын Их Хурал болон Улсын Их Хурлын гишүүнээр нэг ч казах эмэгтэй сонгогдоогүй. 2000 оноос хойш хоёр ч эмэгтэй Улсын Их Хурлын гишүүнийг сонгох сонгуульд өрсөлдсөн боловч сонгогдоогүй байна. Монгол Улсын төрийн эрх баригч намууд болох МАХН, Ардчилсан намаас хоёр эмэгтэй, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайдаар томилогдож, үндэстний цөөнхийн төлөөлөл, тэр дундаа эмэгтэйчүүдийн төлөөлөл төрийн өндөр албан тушаалд дэвшин ажиллаж, тэд салбар бүрдээ өөрийн бодитой хувь нэмрийг оруулж яваа. Энэ нь үндэстний цөөнхийг түүхэн явцад дэмжиж, тэднийг бүх талаар нь хөгжүүлж ирсэн Монгол Улсын төрийн бодлоготой шууд холбоотой гэж болохоор юм.

Казах эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийн хувьд эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдэд захирагддаг ёстой гэсэн уламжлалт сэтгэхүй, уламжлалын дагуу гэр бүлийн хүрээнд янз бүрийн чиг үүргийг

гүйцэтгэж ирсэнтэй холбоотой. Казах гэр бүлд эцгийн эрхт ёсыг дээдлэн, эрэгтэй хүүхдийг илүүтэйд авч үздэг сэтгэхүй одоо хүртэл хадгалагдсан хэвээр байна. Үүнийг нэг жишээгээр харуулахад 2010 оны 3 дугаар сарын 1-ний байдлаар авсан албан бус судалгаагаар Баян-Өлгий аймгийн хэмжээнд улс төрийн өндөр албан тушаалд нэг ч эмэгтэй ажилладаггүй. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 2008 оны орон нутгийн сонгуулиар 5 эмэгтэй нэр дэвшсэнээс 1, Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 4 эмэгтэй сонгогдсон бол, аймгийн Засаг даргын дэргэдэх 20 гаруй харъяа газар, агентлагын дөнгөж 3 газрын дарга эмэгтэй байна. 13 сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нараас зөвхөн нэг, нэг эмэгтэй энэ албан тушаалд сонгогдсон нь тус аймгийн хүрээнд жендэрийн асуудал ямар хэмжээнд байгааг харуулж байна. Аймгийн хэмжээний банк, даатгалын системийн 8 байгууллагын 2 нь эмэгтэй, харин боловсрол, эрүүл мэндийн байгууллагын удирдлагын 90 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Аймгийн хэмжээнд ажилладаг 5 өрхийн эмнэлгийн болон 11 цэцэрлэгийн эрхлэгчид бүгд мөн 11 ерөнхий боловсролын сургуулийн захирлын 7 нь эмэгтэй байна. Боловсрол, эрүүл мэндийн салбарт эмэгтэйчүүд илүүтэй ажиллаж байгаа нь улс орны бүтцийн онцлогтой холбоотой юм.

Эцгийн эрхт ёс үндэстний цөөнх амьдардаг аймагт бусад аймгуудаас илүүтэйгээр байгаа нь дээрхи судалгаанаас харагдаж байгаа бөгөөд үүнийг шинэчлэхэд эрчүүдийн зүгээс уламжлалаа дагасан үзэл, эмэгтэйчүүдийн өөрсдийн ноомой байдал нөлөөлж байна. Хөвгүүдээс охидод нь илүү

дээд боловсрол эзэмшүүлдэг нь зөвхөн казах ч биш нийт монгол айл өрхийн дагаж мөрдөж ирсэн заншил гэж хэлж болох юм. Энэ нь их, дээд сургуульд суралцдаг оюутнуудын судалгаанаас харагдаж байна. Оюутнуудын 70 гаруй хувийг охид эзэлдэг гэсэн тоо баримт бий.

#### **Гурав. Эдийн засгийн хөгжилд казах эмэгтэйчүүдийн оролцоо**

Нийгмийн баялгийг бүтээгчдийн нэг хэсэг казах эмэгтэйчүүд өөрийн гэр орондоо болон нийгмийн хүрээнд эдийн засгийн амьжиргаагаа дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн.

Казах эмэгтэйчүүдийн төлөөлөл улс орны бүтээн байгуулалтанд оролцож, 1950, 1960 онуудаас Хэнтийн Бэрхийн уурхай, Налайхын ил болон далд уурхай, Эрдэнэт, Дарханы уулын баяжуулах, төмөрлөгийн болон цементийн үйлдвэр, шинээр баригдсан олон барилгын засал чимэглэл, өрөлтийг хийхэд гар бие оролцож явсан хөдөлмөрч эмэгтэйчүүд цөөнгүй билээ. Баян-Өлгий аймагт голдуу мал аж ахуйг хөгжүүлэхэд эмэгтэйчүүд гол үүрэг гүйцэтгэж байсан нь дараах судалгаанаас харагдаж байна. 1990 оныг хүртэл Тэргүүний малчин, саальчин 8 эмэгтэй Ардын Их Хурлын депутатаар сонгогдсон байна.

Монгол Улсын хэмжээнд эдийн засгийн хөгжилд казах эмэгтэйчүүд нийгэм эдийн засгийн бүх салбарт ажиллаж өөрсдийн хувь нэмрийг оруулж яваа. Улс орны хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж яваа Баян-Өлгийгээс гаралтай нэртэй бизнесмен эмэгтэйчүүд цөөнгүй.

Гэвч улс орны бүтээн байгуулалтанд

идэвхтэй оролцож яваа казах эмэгтэйчүүдийн нийгмийн үнэлэмж хангалтгүй байна. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй гэх улс орны гол салбарт ажиллагсдын 70 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлдэг мөртлөө, казах эмэгтэйчүүдийн дундаас 70 жилийн дотор ганц Хөдөлмөрийн баатар төрсөн нь үнэхээр чамлах тоо. Малчин эмэгтэйчүүд арын албаны бүх ажлыг хийдэг, малаа саадаг, үс ноосоо хураадаг, мал төллөхөд гол ажлыг нугалдаг мөртлөө аварга малчин цолыг эрэгтэйчүүд авдаг. Баян-Өлгий аймгаас төрөн гарсан гавьяат цолтон 135 хүн байгаагийн 80 хувь эрэгтэйчүүд, дөнгөж 20 хувь нь эмэгтэйчүүд, ардын цолтон 9 хүн, төрийн соёрхолт 7 хүн бүгд эрэгтэйчүүд. Ийм дүр төрх монгол эмэгтэйчүүдийн хувьд ч ойролцоо харагдаж байна. Нийгмийн үнэлэмж шударга бус байсан нь өнөө хирнээ үргэлжилж байна. Үндэстний цөөнхийн эмэгтэйчүүдийн хүч чармайлтыг маш бага үнэлдэг ба огт үнэлдэггүй, ажлынхаа үр дүнгээс болон хөгжлийн явцаас, үр ашгаас хүртэхэд нь үргэлж саад учирч байгаа нь дээрхи судалгаанаас харагдаж байна.

Казах үндэстний цөөнхийн хөдөө орон нутаг суманд, багт амьдардаг эмэгтэйчүүд боловсролтой болох, бичиг үсэгт тайлагдах сургалтанд хамрагдах, өөрсдөө хөдөлмөр эрхлэх, зах зээлийн мэдлэгийг дээшлүүлэх, хөдөө аж ахуйн зээллэг авах, нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдах, гэр бүлээ төлөвлөх, нөхөн үржихүйн мэдлэгтэй болох зэрэг эрхүүдээр хангагдах ёстой.

Казах эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийн сул тал нь зан заншил, түүх, соёл болон шашны үзэл бодлоос одоо хүртэл ихээхэн хамааралтай байгаа



явдал юм. Угсаатны цөөнх соёл, хэл шашны талаар эдлэх эрхийг Пактын 27 дугаар зүйлд заасан байдаг. Энэ нь аль ч улс орон, бүлэг этгээд эмэгтэйчүүд эдгээр эрхийг эдлэх болон хуулиар адил хамгаалуулах эрхийг зөрчих ёсгүй гэсэн үг. Оролцогч улс цөөнхийн гишүүн болсноороо эмэгтэй хүн ямар эрхээ адил тэгш эдлэх боломжгүй болох болон иргэний ба улс төрийн бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүд адил тэгш эдлэх талаар авсан арга хэмжээний тухай мэдээлэх үүрэгтэй. Оролцогч улс эмэгтэйчүүдийн эрхэд муугаар нөлөөлөх цөөнхийн соёлын болон шашны практикийг устгах талаар авсан арга хэмжээний талаар илтгэнэ. Оролцогч улс илтгэлдээ эмэгтэйчүүд тэдгээр бүлгийн соёлын амьдралд ямар хувь нэмэр оруулдаг асуудалд анхаарлаа хандуулна<sup>27</sup> гэж заасан билээ. Үндэстний цөөнх болон шашны бүлэглэлүүд задарч тарах эрхээ далимдуулан биеэ даан шийдвэр гаргах эрхээ эдлэхийг байнга хүсэж байдаг тухай Хороо тэмдэглэн хэлсэн байдаг. Аливаа Засгийн газар нь хүн амын дотор оршин байгаа үндэстэн, цөөнх, арьсны өнгөөр ялгаатай иргэдийг бүрэн төлөөлөх төлөөлөгч болно. Арьс үндсээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн 2 дугаар зүйл болон олон улсын бусад баримт бичгүүдтэй холбогдуулан Засгийн газар үндэстний цөөнхийн эрхтэй холбоотой асуудалд маш мэдрэмтгий хандах шаардлагатай бөгөөд тэдэнд өөрсдийн байр сууриа эзэлж, соёлоо хадгалах, өсч хөгжих, засгийн газарт төлөөлөлтэй байх эрмэлзлийг дэмжих нь зүйтэй. Мөн Засгийн газрууд үндсэн хуулийн хүрээнд үндэстний цөөнх болж байгаа иргэдийн эрхийг хөндөн тавих хэрэгтэй.<sup>28</sup>

<sup>27</sup> Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан ерөнхий зөвлөмж №28

### **Санал, дүгнэлт.**

*Үндэстний цөөнх эмэгтэйчүүдийн эрхийг хангах, хамгаалах ажил олон улсын эрх зүйн хэм хэмжээний түвшингээс хол хоцорч байна. Казах эмэгтэйчүүд монголын бусад үндэстэн, ястаны эмэгтэйчүүдийн нэгэн адил эмэгтэйчүүдийн хөдөлмөр хамгаалал, ажлын нөхцөл байдал, хүүхэд хүмүүжлийн асуудлын тэгш бус байдалтай байна.*

*Баян-Өлгий аймгийн удирдлага, нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллагууд жендэрийн тэгш байдлыг хангах, аймгийн хэмжээний удирдах дээд албан тушаалд эмэгтэйчүүдийг дэвшүүлэн ажиллуулах, тэдэнд өөрсдийгөө харуулах боломж олгох.*

*Дэлхий нийтээрээ хөгжлийн шинэ үеийн гарцан дээр зогсож байгаа, дэлхий даяар улс үндэстнүүдийн хоорондын хэлхээ холбоо улам бүр нэмэгдэн буй өнөөгийн үед дэлхийн хөгжлөөс хоцрохгүйн тулд үндэстний цөөнх ч өөрийн хэв шинж, өвөрмөц онцлогтой үндэстний чанараа хадгалахын зэрэгцээ үндэстний соёлын хүчин зүйлүүдийг залгамжлах, түгээн дэлгэрүүлэх явцад бусад олон үндэстэн ястантай хөл нийлүүлэн алхаж, өөрийнхөө давуу талаа ашиглан нийгэм эдийн засгийн салбарт бодитой хувь нэмрээ оруулж, өөрсдийгөө бүх талаар хөгжүүлэх, мэдээллийн шинэ эринээс хоцрохгүй нийгмийн сайн сайхны төлөө үйл хэрэгт идэвхтэй оролцох нь өнөөгийн нийгмийн зайлшгүй хэрэгцээний нэг хэлбэр болж байна.*

*Иймд казах эмэгтэйчүүдийн нийгмийн идэвхийг дэмжиж, улс төрийн асуудал, жендэрийн тэгш эрхэд анхаарч ажиллах нь чухал байна.*

<sup>28</sup> Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан Ерөнхий зөвлөмжийн Бие даан шийдэх эрхийн тухай ерөнхий зөвлөмж №21

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАР ХУВИЙН ӨМЧИЙН ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ



### Л.БАНЗРАГЧ

Монгол Улсын Их Сургуулийн  
Худалдааны Сургуулийн багш  
(Докторант)

*Энэхүү өгүүлэлд хүний оршихуйн үндэс болсон өмчлөх эрх нь Үндсэн хуулийн хүрээнд хэрхэн хамгаалагдсан байдлыг авч үзэж, цаашид анхаарах зарим нэгэн саналыг дэвшүүлсэн болно. Өмчлөх эрхийн Үндсэн хуулиар хамгаалагдсан байдлыг судлахын зэрэгцээ өмчлөх эрх нь яагаад Үндсэн хуулийн хамгаалалтын объект болох учиртайг тодруулан авч үзэхийг зорилоо.*

### I. ХУВИЙН ӨМЧИЙГ ҮНДСЭН ХУУЛИАР ХАМГААЛАХ ШААРДЛАГА

Өмчлөх эрх, хувийн өмчийн талаархи үзэл сэтгэлгээ Монгол Улсад харьцангуй шинэ тутам бий болсон хэдий ч зохих хэмжээнд төлөвшиж байгаа гэж үзэж болно. Өмчлөх эрхийн талаар олон зууны туршид сэтгэгчид оюун ухаанаа уралдуулан эргэцүүлсээр *жам ёсны эрх* гэж нэгэнт тогтсон төдийгүй хүний угаас заяасан туйлын эрх гэдгийг эртний Ромын эрх зүйгээс эхлэн томъёолсон юм.<sup>29</sup>

Өмчлөх эрх, хувийн өмчийг хүний эрх, эрх чөлөөний салшгүй хэсэг гэдэг утгаар нь өмчид хандаж, түүнийг төрөлх эрхийн онолын үүднээс тайлбарласан сэтгэгчдийн нэг нь Жон Локк юм. Тэрээр албадан хязгаарлаж болдог зарим эрхүүдийн дундаас өмчлөх эрхийг тусад нь салгаж, хязгаарлаж болдоггүй эрхүүдтэй нэгтгэх алхмыг хийжээ. Тодруулбал **“өмчлөх эрх бол амьд явах эрхтэй нэгэн адил үндсэн эрх болон бичигдэх ёстой”** гэж үзсэн. Харин Ф.Гегель “хүний эрхийн үндэс нь өмчлөх эрх бөгөөд энэ нь юуны өмнө хувийн өмч эзэмших эрхээр илэрдэг”<sup>30</sup> гэсэн байна. Энэ мэтчилэн өмчлөх эрхийг жам ёсны эрх хэмээн үзсэн сэтгэгчдийг цааш дурьдаж болно.

Өмчлөх эрхийг жам ёсны эрх гэж үзэж буй үндэслэл нь нэг талаас хүн төрөхдөө ертөнц дээр шалдан ирдэг ч өөрийгөө

<sup>29</sup> Совд.Г Үндсэн хуулийн тайлбар УБ., 2000, 44 дахь тал

<sup>30</sup> Дам ишлэв. Агар-Эрдэнэ Г. “Хувийн өмчийн онол” УБ., 2009, 56 дахь тал

өмчлөх эрхтэй гэдэг утгаараа хүн өмчтэй төрдөг. Тиймээс өмчлөх эрх нь төрөлх эрх юм. Нөгөө талаас өмч гэдэг бол хүний оршихуйн үндэс. Өмчгүй хүн гэж байхгүй, ямар нэгэн зүйлийн өмчлөгч байдаг нь үнэн. Ийнхүү өмчгүйгээр хүн оршин байх боломжгүй, хүн бүр өмчтэй байдаг гэдэг утгаар нь өмчлөх эрхийг төрөлх эрх гэж үздэг байна. Хэрэв энэхүү жам ёсны эрхийг нь хязгаарлан, өмчийг нь бүхэлд нь хураан авбал хүн оршиход бэрх болно.

Энэ ч утгаараа Францын Хүний ба иргэний эрхийн тунхаглалын арван долдугаар хэсэгт **“Өмчтэй байх нь халдашгүй, ариун эрх”** гэж, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд **“Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр эрхийнхээ хувьд адил тэгш байна”** гэж заажээ.

Өмчлөх эрхийг хамгаалаагүй тохиолдолд тэр эрх нь *“Naked liberty буюу нүцгэн эрх чөлөө”*<sup>31</sup> болдог байна. Үндсэн хуульд бүх эрх, эрх чөлөөг заах боломжгүй хэдий ч төрөхөөс заяасан жам ёсны эрхийг хүний үндсэн эрхийн хүрээнд хамгаалах ёстой. Үндсэн хууль болон олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөөг үндсэн эрх гэдэг.<sup>32</sup> Хүний ба иргэний эрхийн тунхаглалын арванзургадугаар зүйлд **“Хүний эрхийг хангаагүй, эрх мэдлийг хуваарилаагүй нийгэмд Үндсэн хууль оршдоггүй”** гэжээ.

Ийнхүү төр нь хүний жам ёсны эрх болох өмчлөх эрхийг Үндсэн хуулиар хамгаалах асуудал зайлшгүй шаардлагатай юм.

## II. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХҮРЭЭНД ХУВИЙН ӨМЧИЙН ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

Эрх, эрх чөлөөг анх удаа Францын Хүний ба иргэний эрхийн тунхагт хүний эрх, иргэний эрх гэж ялгаж заасан гэж үздэг.

Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс хүний эрх нь аль улсын иргэн эсэхээс үл хамааран бүх хүнд хамаарах эрх, харин иргэний эрх нь тухайлсан нэг улсын иргэнд хамаарах эрх, эрх чөлөө юм.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуульд хүний эрхийн асуудлыг зөвхөн Монгол улсын иргэдийн нэг хэсгийн эрх, эрх чөлөөгөөр хязгаарлаагүй, харин бүх иргэнээ хамруулж бас тэднээс гадна тус улсад байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг оролцуулан нийт **“Хүний эрх, эрх чөлөө”** гэсэн бүлгийг өргөн хүрээнд анх удаа дэвшүүлэн (Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг) тодорхойлсон.<sup>33</sup> Ийнхүү хувийн өмчийг хүлээн зөвшөөрч, өмчлөх эрхийг хамгаалсан боловч Монгол Улсын Үндсэн хуулиар хувийн өмчийг бодитойгоор хамгаалж чадсан эсэх нь эргэлзээтэй байна.

1. Монгол Улс шинэ Үндсэн хуулиараа өмчийн бүх хэлбэр, түүний дотор хувийн өмчийг анх удаа хүлээн зөвшөөрөн, хүний төрөлх эрх буюу жам ёсны эрхийг дээдлэн хүндэтгэсэн нь тухайн улс орны эрх зүйн сэтгэлгээ, хүний эрхийн мэдрэмж, эрх зүйн соёл төлөвшиж буйг харуулсан алхам болоод зогсоогүй, энэ нь эдийн засгийн харилцаанд ч томоохон ололтыг авчирсан

<sup>31</sup> Агар-Эрдэнэ Г. “Хувийн өмчийн онол” УБ., 2009, 140 дахь тал.

<sup>32</sup> Чимид Б. “Үндсэн хуулийн мэдлэг” УБ., 2008, 118 дахь тал.

<sup>33</sup> Амарсанаа Ж. “Ардчилсан эрх зүйт ёс” УБ., 2009, 31 дахь тал.

билээ. Өмчлөх эрхийн хамгаалалтыг Үндсэн хуулийн 5-р зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.” хэмээн шууд тодорхойлон зааж өгсөн.

Үндсэн хуулийн нийтлэг шинж бол иргэдийн эдлэх эрх, эрх чөлөөний баталгаа болох явдал билээ. Үндсэн хуулийн 5-р зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг эрх зүйн үүднээс дүгнэвэл Монгол Улс Үндсэн хуулиараа хувийн өмчийг хүлээн зөвшөөрөөд зогсохгүй хамгаалсан гэж үзэж болох юм. Гэхдээ өмчтэй байх нь жам ёсны эрх гэж үзэж байгаа бол **жам ёсны эрхийг төр хүлээн зөвшөөрдөггүй, зөвхөн хамгаалах үүрэгтэй** гэдэг нь эрх зүйн онолын хүрээнд маргаангүй зүйлийн нэг билээ. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулиар жам ёсны эрх болох өмчлөх эрхийг төр хүлээн зөвшөөрсөн байна. Төр хүний өмчлөх эрхийг хүлээн зөвшөөрч байгаа нь төр энэ эрхийг олгож байгаа хэрэг болжээ. Ийнхүү төр өмчлөх эрхийг олгосноор олгосон эрхээ буцаах буюу хязгаарлах боломж бүрдэж байгаа юм.

2. Үндсэн хуулийн 16-р зүйлийн 3 дахь хэсэгт иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөнд өмчлөх эрхийг багтаан “**хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө**”<sup>34</sup> хэмээн хуульчилсан.

<sup>34</sup> Монгол улсын үндсэн хууль, (1992) Ардын эрх сонин 1992.01.14 №9 (313) УБ. Мөн “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

Энэ заалтыг задлан эрх зүйн онолын үүднээс дүгнэлт хийвэл:

**“Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг шударгаар олж авах эзэмших, өмчлөх өв залгамжлуулах эрхтэй.”**

Энэ хэсэгт хөрөнгийг олж авахад хууль ёсны шаардлага тавигдаагүй, зөвхөн шударга ёсны шаардлага тавигдсан байна. Өөрөөр хэлбэл хөрөнгийг шударгаар олж авсан бол түүнийг тухайн хүн өмчлөх эрхтэй гэж үзсэн байна. Гэтэл өмчийг шударгаар олж авсан тохиолдол бүр нь үнэндээ өмчлөгч гэж үзэх үндэслэл болдоггүй. Энэ нь өмчийг шударгаар олж авч буй үйлдэл бүхэн хуульд нийцсэн байдаггүйтэй холбоотой юм.

**Жишээ:** Иргэн А нь 2 сая төгрөгний үнэ бүхий манан хөөрөгтэй. Түүний хөөргийг Б хулгайлан авч, В-д худалдсан байна. В бол А болон Б-г танихгүй төдийгүй уг хөөрөг нь анхны өмчлөгчөөс хууль бус замаар (хулгайлагдсан) гарсан гэдгийг мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан.

Энэ тохиолдолд В бол уг хөөргийг хулгайн хөөрөг гэдгийг мэдээгүй буюу мэдэх боломжгүй учир шударгаар олж аваагүй гэж үзэх үндэслэлгүй юм. Өөрөөр хэлбэл В хөөргийг шударгаар олж авсан.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт өмчлөх эрхийг шударгаар олж авах эрхтэй гэж заасан тул хөөргийг шударгаар олж авсан гэдэг утгаараа хөөрөгний өмчлөгч нь В болно.<sup>35</sup>

<sup>35</sup> Монгол улсын Иргэний хуулиар В-г өмчлөгч гэж үзэхгүй. Өмчлөгч нь зөвхөн А болно. Иргэний эрх зүйн онолын үүднээс В нь хууль бус шударга эзэмшигч тул А нь Иргэний хуулийн 106.1-д заасны дагуу В-ээс шаардах эрхтэй. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулиар бол тухайн хөөргийг шударгаар олж авсан гэдэг утгаараа өмчлөгч нь бас В болно.

Энэ зүйлд шударгаар боловч, хууль бусаар өмчлөх эрхийг олж авсан этгээдийг хамгаалан, харин хууль ёсны байх шаардлагыг орхигдуулсан байна. Ингэснээр анхны буюу жинхэнэ өмчлөгчийн өмчлөх эрхийн асуудал хөндөгдөнө. Монгол Улсын Үндсэн хууль нь дээрхи тохиолдолд анхны өмчлөгчийн өмчлөх эрхийг хамгаалж чадахгүй байдалд хүрч байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт өмчлөх эрхийг зөвхөн шударгаар олж авахаар заасан нь Монгол Улсын Үндсэн хуулиар өмчлөх эрх хангалттай хамгаалагдаагүй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Үндсэн хуулийн 16-р зүйлийн 3 дахь хэсэгт **“Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”** гэж заасан нь хууль гаргах замаар өмчлөх эрхийг зөрчиж болох боломжийг төрд олгосон гэж үзэж болно. Учир нь нийгмийн зайлшгүй хэрэгцээ гэж юуг ойлгох вэ? гэх мэтчилэн Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалт бүрхэг, тодорхой бус байгаа нь төр өмчлөх эрхийг зөрчих боломжийг бүрдүүлэн өгч байна.

Өмчлөх эрхийг улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал болон бусад зайлшгүй шалтгаанаар хязгаарлаж болох юм. Гэтэл ямар ч тохиолдолд жам ёсны эрхийг хязгаарлаж болохгүй гэсэн үзэл сэтгэлгээ нэгэнт тогтсон зүйл тул Үндсэн хуульчлагдсан бүх эрх өөртөө халдашгүй байдлыг хадгалж байх ёстой<sup>36</sup> байдаг. Өмчлөгч туйлын эрхээ (өмчлөх) хэрэгжүүлэхдээ бусад этгээдийн өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд нь саад болох буюу гэм хор учруулах, байгаль орчныг бохирдуулах замаар хэрэгжүүлж болохгүй. Өмчлөх эрхээ ийнхүү хэрэгжүүлсэн тохиолдолд

л хуульд зааснаар өмчлөгчийн эрхийг хязгаарлаж болдог. Жам ёсны эрх болох өмчлөх эрхийг Үндсэн хуулиар дээрхи байдлаар хязгаарласан нь хувийн өмч нь хуулиар зохих хэмжээгээр хамгаалагдаагүй байна гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна.

Монгол Улсын Үндсэн хууль нь хүний жам ёсны эрх болох хувийн өмчийн эрхийг үндсэн эрхийн хэмжээнд хуульчилсан боловч нөгөө талаасаа халдашгүй дархлагдсан эрх гэдгийг нь үгүйсгэсэн. Мөн Монгол Улсын Үндсэн хуульд заасан нөхөн олговор гэдэгт юуг ойлгох нь тодорхой бус байна.

### ДҮГНЭЛТ

Ийнхүү хувийн өмчийг хамгаалсан зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд шигтгэж өгсөн хэдий ч хувь хүний өмчлөх эрхийг төдийлөн хамгаалаагүй байна. Иймд хувийн өмчийг хамгаалах Монгол Улсын Үндсэн хуулийн хамгаалалтыг боловсронгуй болгоход чиглэсэн зарим нэг саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хувийн өмчийг хамгаалсан заалт нь логикийн хувьд хувийн өмчийг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг тул Үндсэн хуулийн 5-р зүйлийн 2 дахь хэсгийн **“Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”** гэсэн заалтын **“Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч”** гэдгийг нь хасах,

2. Хууль баталж байгаад хувийн өмчид халдаж болзошгүй тул Үндсэн хуулийн 16-р зүйлийн 3 дахь хэсэгт **“Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно.”** гэсэн заалтын хууль бусаар гэдгийг нь хасах,

Өмчлөх эрхийн асуудал нь зөвхөн Үндсэн хуулийн эрх зүйн төдийгүй бусад салбар эрх зүйн ч судлагдахуун болсон өргөн хүрээтэй асуудал тул зөвхөн энэхүү өгүүллийн хүрээнд судлах нь хангалтгүй гэдгийг онцлон тэмдэглэмээр байна.

<sup>36</sup> Дам ишлэв. Агар-Эрдэнэ Г. “Хувийн өмчийн онол” УБ., 2009, 103 дахь тал

## ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ ХҮНИЙ ҮНДСЭН ЭРХ БОЛОХ НЬ



### Г.АГАР-ЭРДЭНЭ

Хүний эрхийн Үндэсний  
Комиссын Гомдол, хяналт  
шалгалт, бодлого дүн  
шинжилгээний хэлтсийн дарга  
(Докторант)

#### *Нэг. Эрүүл болоод аюулгүй орчны тухай*

Аж үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, зам тээврийн хөгжил, хүний өдөр тутмын үйл ажиллагаа дэлхийн экосистемийн зүй тогтолд өмнө төсөөлж байгаагүй хэмжээгээр нөлөөлөх болжээ. Манай гаригийн байгалийн тэнцэл бүхэлдээ алдагдаж буй нь 21 дүгээр зуунд хүн төрөлхтөнд заналхийлэх хамгийн том аюул болоод буй уур амьсгалын өөрчлөлтөөс тодорхой харагддаг.

Тодруулбал, амьтай болон амьгүй биетийн хоорондын үл нийцлээс шалтгаалж байгалийн тэнцэл алдагдаж буй бөгөөд эдгээр нь цөм хүний үйл ажиллагаанаас хамааралтай. Агаарын, усны, хөрсний гэх мэт органик шинжтэй, мөн дуу чимээ, хог хаягдал, гэрэл гэх мэт хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй орчны бохирдол ч ихэсч байна.

Эрүүл, аюулгүй орчин нь дан ганц хүн бус, бусад амьд амьтан, ургамалд ч хамаарах өргөн хүрээтэй ойлголт. Энэ нь хүмүүс өдөр тутмын амьдралдаа амь бие, эрүүл мэнддээ халтай аливаа нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх боломж бөгөөд эрүүл орчин нь гол төлөв байгалийн тэнцэл, хүрээлэн буй орчны төлөв байдал дээр яригддаг, агаар, ус, газар болон үүнтэй холбоотой бусад өргөн хүрээний хүчин зүйлсийг хамардаг.

Аюулгүй орчин нь нийгэм-улс төрийн шинжтэй ойлголтыг илэрхийлэх бөгөөд үүнд наад зах нь нийгэм-улс төрийн шинжтэй хүчирхийллээс ангид байх, хүчирхийллийн үед төрийн онцгой бүрэн эрхийг хууль ёсны хүрээнд хэрэгжүүлэх, олон нийтийн хэв журмыг хангах, бие махбодын аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг бүрдүүлэх зэргийг ойлгож болно.

Харин энэ удаад эрүүл орчинд амьдрах хүний эрхийн тухайд тусгайлан авч үзье.

***Хоёр. Эрүүл орчинд амьдрах эрхийг тодорхойлох шаардлага***

Үндсэн хуульт ёс тогтож, хүний улс төрийн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан явдлыг хүний эрхийн хөгжлийн эхний үе гэж үздэг бөгөөд эдгээр эрхийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон дэлхийн улсуудын Үндсэн хуулиудад баталгаажуулсан билээ.

Хүний эрхийн хөгжлийн хоёр дахь үед эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөрлөх зэрэг эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад багтаасан хэдий ч Үндсэн хуулиудад улс төрийн эрхтэй адил өргөн хүрээнд баталгаажуулаагүй байна.

Харин эрүүл орчинд амьдрах эрх нь орчин үеийн нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилтэй уялдан хүний эрхийн хөгжлийн гурав дахь үед бий болсон хамтын болон эв санааны эрхүүдийн нэг юм. Гурав дахь үеийн эрхийг бий болгосон шалтгааныг “олон улсын нийгэмлэг цаг үедээ нийцүүлэн хэрэгцээ шаардлагаа тодорхойлж байгаа хэрэг<sup>37</sup>” гэж зарим судлаачид тодорхойлсон байдаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1966 онд баталсан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад “... орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах...”-ыг оролцогч улс бүрт үүрэг болгосон нь цаашлаад хүрээлэн буй орчны гэгдэх энэхүү эрх бий болох

<sup>37</sup> R.P. Nanda and G. Pring. 2003. International Environmental Law for the 21st Century. Ardsley, N.M.: Transnational Publishers, p. 455.

үндсийг тавьсан юм.

Үүнээс өмнө 1962 онд хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр идэвхийлэн ажилладаг судлаач Рэйчел Карсон “АНУ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтдөө хувь хүн, эсвэл төрийн зүгээс тархааж болзошгүй аминд халтай хорт бодисоос ангид байх баталгааг бүрдүүлэх нь зүйд нийцнэ<sup>38</sup>” гэсэн нь эрүүл орчинд амьдрах эрх байх ёстойг илэрхийлсэн анхны дохио болсон гэж үздэг.

Үндсэндээ хүний эрүүл орчинд амьдрах эрхийг онцлон хамгаалах шаардлага нь дэлхий нийтийг хамарсан хүрээлэн буй орчны бохирдол, түүнээс үүдэлтэй хямралаас эхтэй юм. 1967 онд Английн өмнөд хэсэгт Торри Канион тээвэрлэгч хөлөг онгоц их хэмжээний газрын тос далайд асгаснаас болж далайн амьтад ихээр сүйдсэн төдийгүй 15 мянга гаруй шувуу үхсэн томоохон гамшиг тохиолдсон, 1969 онд АНУ-д болсон Куяахога голын бохирдлоос үүдэлтэй гамшиг зэрэг нь дэлхийн нийтийн анхаарлыг татаж улмаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалт<sup>39</sup> шаардлагатай болсныг хүлээн зөвшөөрсөн байна.

<sup>38</sup> R. Carson. 1962. Silent Spring. Houghton Mifflin, pp. 12-13.

<sup>39</sup> Хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр олон улсын түвшинд ахиц дэвшил гарч Биологийн төрөл зүйлийн тухай конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын ерөнхий конвенц, Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц, Озоны үе давхаргад сөрөг нөлөө үзүүлэх бодисын тухай Монреалийн протокол, Ган цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенц, Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг, ялангуяа усны шувуу олноор амьдардаг орчны тухай Рамсарийн конвенц, Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц, Халим агнуурыг зохицуулах тухай олон улсын конвенц, Ургамал хамгааллын олон улсын конвенц зэрэг олон улсын эрх зүйн хэм хэмжээг батлан мөрдүүлж байна.

1972 оны 6 дугаар сард Хүний хүрээлэн буй орчны сэдвээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын чуулга уулзалт Шведийн нийслэл Стокгольм хотноо болж, уг чуулга уулзалтаар Хүрээлэн буй орчны тухай Стокгольмын тунхагийг баталсан юм. Энэхүү тунхагийг хүрээлэн буй орчны эрхийн үндсийг тавьсан анхны баримт бичиг гэж үздэг. Тунхагийн суурь зарчмуудын нэгдүгээрт: “Хүн бүр эрхэмсэг, сайн сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлдэг дээд зэргийн орчинд эрх чөлөөтэй, эрх тэгш байх, амьдралын таатай нөхцлөөр хангагдах үндсэн эрхтэй агаад одоо ба хойч үеийнхээ төлөө хүрээлэн буй орчноо хамгаалах, хөгжүүлэх журамт үүргийг хүлээнэ.” гэж заажээ.

Үүнээс хойш эрүүл орчинд амьдрах эрхийг бүрэн утгаар нь бий болгох, төлөвшүүлэх ажлын хүрээнд үндэсний хууль тогтоомжид уг эрхийг баталгаажуулах, бусад эрхтэй харилцан хамаарлыг тогтоох, төрийн болон нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, байгаль, орчны өөрчлөлтөд өртөгч бүлгийнхнийг хамгаалах бодлогыг бий болгох зэрэг ажлыг олон улсын болон бүс нутгийн түвшинд хийсээр иржээ.

### *Гурав. Хүний үндсэн эрх мөн үү?*

Эрүүл орчинд амьдрах эрх нь хүний үндсэн эрх мөн эсэх тал дээр эрх зүйн онолын хүрээнд маргаан, мэтгэлцээн байнга өрнөдөг. Уг эрхийг хүний үндсэн эрх мөн эсэхийг тодорхойлохын тулд юуны өмнө хүний эрхийн тулгуур гурван шаардлагыг авч үзэх нь зүйтэй.

Хүний эрх нь нэгдүгээрт, түгээмэл буюу хүн бүр эдлэх боломжтой байх, хоёрдугаарт, ёс суртахуунд үндэслэсэн

буюу тодорхой үндэстэн, төр засаг, эсвэл эрх зүйн тогтолцоо хүлээн зөвшөөрсөн эсэхээс үл хамааран хэрэгжих боломжтой байх, гуравдугаарт, хүний эрхэмсэг оршихуйг хангахад чиглэсэн байх үндсэн шаардлагыг хангах учиртай.

“Ёс суртахууны төсөөллөөр бол хүн бүр эрүүл мэнд, сайн сайхандаа шаардагдахуйц хүрээлэн буй орчинд амьдрах үндсэн эрхтэй байх нь маргаангүй<sup>40</sup>”, “цэвэр агаар, цэвэр ус, хүрэлцээтэй хоол хүнс нь хүний суурь эрхийн нэг мөн<sup>41</sup>” гэж цөөнгүй судлаачид үзсэн ба хамгийн чухал нь “хүрээлэн буй орчныг амьдралын үндсэн нөхцөл, хүний эрхэмсэг оршихуйд зайлшгүй хэрэгтэй, бусад эрхийг нөхцөлдүүлдэг хүчин зүйлс гэдэг утгаар нь ойлгох ёстой<sup>42</sup>” гэсэн байна. Харин энд нэмж дурдахад цөөн тооны судлаачид “Цэвэр агаар гэх мэт хүсэл эрмэлзэл нь эрх гэхээсээ илүүтэй зорилго юм<sup>43</sup>” гэсэн тайлбарыг хийжээ.

Улс төрийн болон эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг олон улсын пактаар баталгаажуулсан бол эрүүл орчинд амьдрах эрх зэрэг гурав дахь үеийн эрхүүдийг ямар нэг пактаар баталгаажуулаагүй. Тийм ч учраас зарим эрдэмтэд эрүүл орчин, энх тайван, хөгжил, дэвшил зэрэг ойлголт нь нийгмийн бодлогын зорилт болохоос эрх биш юм гэж тайлбарладаг.

<sup>40</sup> T. Hayward. 2000. “Constitutional Environmental Rights: A Case for Political Analysis” *Political Studies* 48(3): 558-72 at 568. T. Hayward. 2005. *Constitutional Environmental Rights*. Oxford: Oxford University Press.

<sup>41</sup> H. Shue. 1996. *Basic Rights: Subsistence, Affluence, and U.S. Foreign Policy*, 2nd ed. Princeton: Princeton University Press, p 23. See also S. Collins-Chobanian. 2000. “Beyond Sax and Welfare Interests” *Environmental Ethics* 22: 133-48.

<sup>42</sup> P. Birnie and A. Boyle. 2002. *International Law and the Environment*, 2nd ed. Oxford: Oxford University Press, p. 255.

<sup>43</sup> C. Miller. 1998. *Environmental Rights: Critical Perspectives*. London: Routledge, p. 92.



Үүний хариуд гурав дахь үеийн эрхийг хамгаалагчид хэлэхдээ, хүний эрх нь түүхэн цаг хугацааны туршид хувьсч өөрчлөгдсөөр ирсэнийг боолын худалдааг халсан, эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй адил тэгш гэдгийг хүлээн зөвшөөрсөн, ижил хүйстэний гэрлэлтийг баталгаажуулсан зэрэг жишээнээс харж болно гэдэг. Ерөөс хүний эрхийг чухал, чухал бишээр ялгах нь зохимжгүй бөгөөд нэг, хоёр, гурав дахь үеийн гэх мэтээр ч ангилах шаардлагагүй гэж үзэх болжээ<sup>44</sup>. 1993 оны НҮБ-ын Хүний эрхийн тухай Венийн тунхагт энэ чиг хандлагыг дэмжсэн байдаг. Уг тунхагт “Олон улсын нийгэмлэгийн зүгээс хүний эрхэд адил тэгш, ялгаваргүй хандах ёстой” гэсэн байна.

Дээрхээс үзвэл эрүүл орчинд амьдрах эрх нь хүний эрх, тэр дундаа хүний үндсэн эрх мөн гэсэн дүгнэлт хийж болох юм. Үүнийг баталгаажуулах үүднээс энэ нь позитив, негатив эрхийн аль шинжийг агуулж байна вэ гэдэгт хууль зүйн дүн шинжилгээ хийе.

Хэдийгээр орчин үед позитив, негатив эрхийн хоорондын ялгаа бүдгэрч байгаа ч тодорхой эрхийг онол, арга зүйн үүднээс судлах тохиолдолд түүний ялгааг гаргах нь чухал юм.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактын 2 дугаар зүйлийн 1-т “Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл,

шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй”, мөн зүйлийн 2-т “Хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээ аваагүй байгаа бол энэхүү Пактад оролцогч улс бүр үндсэн хуулийнхаа журам болон энэ Пактын заалтад нийцүүлэн түүнд хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байж болох хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээг авах үүрэгтэй.” хэмээн иргэний болон улс төрийн эрхийн хамгаалалт нэн даруй хэрэгжих ёстойг заасан. Харин Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 1-т “Энэхүү Пактад оролцогч улс бүр дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх боломжийнхоо хэрээр авах үүрэгтэй.” гэжээ. Эндээс үзвэл иргэний болон улс төрийн эрхүүд шүүхийн журмаар албадан хэрэгжих боломж бүрдсэн байхад эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүд нь ийм боломжоор хомс байгаа юм. Гэхдээ энд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хийсэн “хүний эрхүүдийн хоорондын төрлийн ялгаа бага багаар арилж байна<sup>45</sup>” гэсэн дүгнэлтийг эш татъя.

<sup>44</sup> M.J. Rogge. 2001. “Human Rights, Human Development, and the Right to a Healthy Environment: An Analytical Framework” Canadian Journal of Development Studies 22(1): 33 at 37.

<sup>45</sup> United Nations Food and Agriculture Organization. 2006. Juristicability of Food in The Right to Food Guidelines: Information Papers and Case Studies. Rome: FAO, p. 77.  
<http://www.fao.org/docrep/010/a0511e/a0511e00.htm>

Эрх зүйн онолд иргэний болон улс төрийн эрх буюу шүүхийн албадлагаар сэргээх боломжтой хүний үндсэн эрхийг негатив эрхэд хамааруулдаг. Тодруулбал, үг хэлэх, шашин шүтэх, эвлэлдэн нэгдэх зэрэг төрийн зүгээс албадах, оролцохыг чандлан хориглосон эрхүүд үүнд багтана. Нөгөө талаас төрийн зүгээс тухайн эрхийг эдлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар хэрэгжилтийг хангах позитив эрхэд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хамааруулдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-т заасан “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах” эрх нь негатив болон позитив эрхийн аль алиных нь шинжийг агуулснаараа онцлог юм. Тодруулбал, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах явдал нь негатив эрхийн шинжийг илэрхийлж байгаа бол, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь төрийн оролцоотойгоор хэрэгжих позитив эрхийн шинжийг хадгалж байна.

***Дөрөв. Эрүүл орчинд амьдрах эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан нь***

Монгол Улс эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг Үндсэн хуульдаа баталгаажуулсан нь олон улсын зарчим, хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж буй хэрэг бөгөөд хүрээлэн буй орчны эрхээр дагнан судалдаг Т.Хэйвордын тодорхойлсончлон уг эрхийг үндсэн хуульчлах шаардлага нь нэгдүгээрт, хүний үндсэн эрх бүрийг үндсэн хуулиар хамгаалдаг, хоёрдугаарт, ёс суртахууны ач холбогдол болоод бодит практикт тодорхой эрхийг хүлээн зөвшөөрсөн

байдлыг харгалзах, гуравдугаарт, логик дарааллын хувьд дээрх хоёр дүгнэлт дээр үндэслээд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх угаас үндсэн хуулийн хамгаалалт дор орших ёстойг илэрхийлж байна гэж үзсэнтэй санал нэг байна.

Өнөөдөр Монгол Улсаас гадна 140 улсын Үндсэн хуульд эрүүл орчинд амьдрах эрхийг олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлж, хүрээлэн буй орчныг хамгаалах явдлыг төрийн үүрэг болгон хуульчилсан байна. Үүнийг он дарааллаар авч үзвэл, 1972 оноос өмнө 5, 1973-1979 онд 16, 1980-1989 онд 24, 1990-1999 онд 68, 2000-2009 онд 27 улс Үндсэн хуульдаа хүрээлэн буй орчны эрх болон төрийн үүргийг тодорхойлсон байна. Зөвхөн 1992 онд 18 улс хүрээлэн буй орчны эрхийг Үндсэн хуульдаа баталгаажуулсан нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд энэ нь Рио де Жанейро хотноо Хүрээлэн буй орчин, хөгжил сэдвээр НҮБ-ын чуулга уулзалт болж, уг уулзалтад улс орнуудын төрийн тэргүүн, удирдах албан тушаалтнууд өргөнөөр оролцсонтой холбоотой. Чуулга уулзалтаас Риогийн тунхаг хэмээх 27 зүйл, зарчим бүхий баримт бичгийг гаргасан ба Зарчим 1-т: “Хүн нь тогтвортой хөгжлийг хангах явдлын төвд нь байна. Тэдэнд байгальтай нийцэж эрүүл, таатай амьдрах эрх олгогдсон” хэмээн тунхагласан юм.

Мөн эрүүл орчинд амьдрах эрхийг 86 улсын Үндсэн хуульд шууд утгаар нь баталгаажуулсан байна<sup>46</sup>. Эдгээр улсууд гол төлөв “эрүүл орчин”, “эрүүл мэндэд халгүй орчин”-д амьдрах эрх гэсэн ойлголтыг

<sup>46</sup> The Environmental Rights Revolution: Constitutions, Human Rights, and the Environment by David Richard Boyd, 2010 The University of British Columbia

Үндсэн хуульдаа тусгасан байх бөгөөд тухайн заалтад цэвэр /7/, аюулгүй /6/, таатай /5/, бохирдоогүй /2/, бохирдлоос ангид /2/, тогтвортой /2/ зэрэг үгс давхар дурдагдсан байна.

Уг эрхийг үндсэн хуульчлах үйл явц зарим эсэргүүцэлтэй тулгарч байсан ч хуульчид эрүүл орчинд амьдрах эрхийг үндсэн хуульчилснаар эрх зүйн орчин сайжирч, институц өргөжин тэлж, улмаар шүүхийн шатанд ч хохирсон иргэдийн амьдрах нөхцлийг сайжруулах чиглэлээр ахиц дэвшил гарсан гэж үздэг.

***Тав. Монгол Улсад эрүүл орчинд амьдрах эрхийн хууль зүйн баталгааг бүрдүүлсэн нь***

Хүний аливаа эрхийг амьдрал дээр хэрэгжүүлэх үйл явцыг энгийнээр тайлбарлавал эхлээд тодорхой эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулах, хоёрдугаарт, салбарын хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулах, гуравдугаарт, хууль хэрэгжүүлэх байгууллагууд дүрэм журам баталж мөрдүүлэх, дөрөвдүгээрт, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий байгууллагууд түүнийг хэрэгжүүлж ажиллах, тавдугаарт, хувь хүн, бизнес, иргэний нийгэм, төрийн бүх шатанд буюу нийгмийн төлөв байдалд өөрчлөлт илрэх, эцэст нь буюу зургадугаарт, амьдрал дээр үр дүн нь илэрч гарах явдал болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх ажлын хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг баталснаар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг

байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах эрх зүйн үндэс тавигдсан юм.

Мөн Агаарын тухай, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Ойн тухай зэрэг хуулиуд батлагдаж хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгаа тодорхой хэмжээнд бүрдсэн гэж үзэж болох ч Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах ажил нэн хангалтгүй байна.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд уул уурхайн үйлдвэрлэл эрчимжиж, түүний нийгэм, эдийн засгийн амьдралд үзүүлэх нөлөөлөл нэмэгдэхийн хэрээр иргэдийн эрүүл орчинд амьдрах эрх хөндөгдөж байгаа тул төрөөс тодорхой бодлого, шийдвэр цаг алдалгүй гаргаж, хууль хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, тодорхойлох, хяналт тавих шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Хүн амьд явах салшгүй эрхтэй. Мөн эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй. Харин эдгээр эрхээ зүй ёсоор эдлэхийн тулд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах зэргээр байгаль, нийгмийн элдэв сөрөг нөлөөллөөс ангид байх ёстой юм. Амьд явах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах үндсэн баталгаа нь эрүүл, аюулгүй орчин бөгөөд орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдах явдлаас төр иргэнээ хамгаалах үүрэг хүлээдэг. Төр энэхүү үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас хамааран амьд явах эрхийн хэрэгжилт хангагдах, эс хангагдах тухай асуудал яригдах учиртай юм.

## ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ ЗАРИМ АСУУДАЛ



**Б.БОЛОРСАЙХАН**  
Хүний эрхийн Үндэсний  
Комиссын референт  
(Докторант)

Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилготой Хүний эрхийн үндэсний байгууллагууд (цаашид ХЭҮБ-ууд гэх) болон холбогдох байгууллагууд нь төрийн эрх мэдлийн бүтэц, түүний үйл ажиллагаанд хяналт тавих хөндлөн шинжтэй (захиран тушаах буюу шаталсан бүтэцтэй, босоо хэлбэрийн хариуцлага тооцох хэлбэрийг эсрэгцүүлэн) хариуцлага бүхий төрийн институтууд юм<sup>47</sup>. Эдгээр байгууллагын олонх нь төрийн талаарх өөрийн шийдвэрийг гаргах эрхгүй байдаг. Харин тэдгээрт зөвлөгөө өгөх, зөвлөмж гаргах, үндсэн хуулийн болон бусад

шүүхүүдэд хандах зэрэг “зөөлөн” шинжтэй эрх мэдлийг олгосон юм<sup>48</sup>.

Сүүлийн хорин жилийн хугацаанд ХЭҮБ-уудад байнга анхаарал хандуулж ирсэн ч хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихээр ажиллаж байгаа ямар үндэсний байгууллагыг ХЭҮБ гэж тодорхойлох тухай харилцан адилгүй байр суурь байсаар байна. ХЭҮБ-ын тодорхойлолт нь олон улсын түвшинд Нэгдсэн Үндэстний Байгууллага, бүс нутгийн бусад байгууллагын хүний эрхийн механизмд хандах, хамтран ажиллахад чухал ач холбогдолтой. Гэхдээ хорин жилийн хугацаанд хүний эрхийн үйл ажиллагааг

<sup>47</sup> United Nations, National Human Rights Institutions: A Handbook on the Establishment and Strengthening of National Institutions for the Promotion and Protection of Human Rights (New York, 1995), 6 дахь нүүр; A. Schedler, L. Diamond, and M. F. Plattner (eds.) The Self-Restraining State: Power and Accountability in New Democracies (Boulder: Lynne Rienner, 1999).

<sup>48</sup> Linda Reif, “Building Democratic Institutions: The Role of National Human Rights Institutions in Good Governance and Human Rights Protection,” Harvard Human Rights Journal 13 (2000), 7-11; Christopher Elmendorf, “Advisory Counterparts to Constitutional Courts,” Duke Law Journal 56 (2007)...

хэсэгчлэн, эсвэл бүрэн дүүрэн явуулдаг төрөл бүрийн үндэсний байгууллагуудыг байгуулсан нь ХЭҮБ-ыг тодорхойлоход төвөгтэй байдал үүссэн. Дэлхий дахинд хүний эрхийн комиссыг ХЭҮБ-аар хүлээн зөвшөөрч, “гибрид” буюу нийлмэл шинжтэй хүний эрхийн омбудсманы байгууллагыг тооцох нь нэмэгдсэн ч зарим улсад омбудсманы үүргийг багасгах хандлагатай байна<sup>49</sup>. Сэдэвчилсэн буюу тодорхой асуудал (хүүхдийн эрх, тэгш эрх, цөөнхийн эрх гэх мэт) хариуцсан хүний эрхийн байгууллагуудыг ХЭҮБ-уудад татан оролцуулахаар санал болгох боломжтой ч явцуу хүрээтэй гэж эсэргүүцэх нь бий<sup>50</sup>. Хэдийгээр сонгодог шинжтэй омбудсманы байгууллагууд хүний эрхтэй холбоотой бүрэн эрх хэрэгжүүлдэггүй ч гэсэн зарим байгууллага хүний эрх болон хүний эрхийн хууль тогтоомж хэрэглэх талаар мөрдөн байцаалт хийх боломжтой байдаг<sup>51</sup>. Гэтэл эдгээрийг ХЭҮБ-ын

тодорхойлолтод багтаадаггүй<sup>52</sup>. Мөн хүний эрхийн үндэсний түвшнээс доогуур хүрээнд ажилладаг байгууллагуудыг ямагт багтаадаггүй онцлогтой.

Олон улсын түвшинд ХЭҮБ-ын тухай төрөл бүрийн тодорхойлолт байдаг ч Ерөнхий Дүгнэлтээс үүдэлтэй, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Парисын Зарчмуудад тулгуурласан Хүний эрхийн дээд комиссарын газар (ХЭДКГ), Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилготой үндэсний байгууллагуудын Олон улсын зохицуулах хороо (ОУЗХ)-ны ашигладаг тодорхойлолтыг түлхүү ашиглаж байна<sup>53</sup>. Энэхүү давамгайл шинжтэй тодорхойлолтод мөн чанарын хувьд үндэсний түвшний хүний эрхийн комисс, хүний эрхийн омбудсманы байгууллагуудыг хамруулж үздэг. Хэдийгээр ХЭҮБ гэсэн ойлголтод анхаарсан боловч консерватив шинжтэй. Гэтэл Европын бүс нутагт илүү чөлөөтэй байдлаар тус ойлголтыг томъёолж, хүний эрхийн асуудлаар ажилладаг үндэсний байгууллагуудыг тооцох хандлагатай ажээ. Эдгээр ялгаатай тодорхойлолтуудын дагуу тухайн байгууллага нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлж, бусад ХЭҮБ-ууд, гишүүн улсуудтай харилцдаг. Хүний эрхийн судлаачдын хувьд харилцан адилгүй нөхцөл байдалд илрэлээ олсон

<sup>49</sup> United Nations, Office of the High Commissioner for Human Rights, Survey on National Human Rights Institutions (Geneva: UN, 2009) Уг судалгаанд комисс, хүний эрхийн омбудсмануудыг багтаасан болно; Харин V. G. Ramcharan, *The Protection Role of National Human Rights Institutions* (Leiden: Brill, 2005) бүтээлд зөвхөн гибридийн шинжтэй Гана Улсын ХЭҮБ-ыг дурдсан; Gauthier de Beco, “Networks of European National Human Rights Institutions,” *European Law Journal* 14 (2008), 860-77 дахь тал. Уг бүтээлд олон тооны хүний эрхийн омбудсманы байгууллагыг хасч тооцсон төдийгүй “омбудсман” гэсэн нэр томъёог “төлөөлөгч” гэж хувь хүнээр тайлбарлан ашигласан болно.

<sup>50</sup> M. Kjaerum, *National Human Rights Institutions: Implementing Human Rights* (Copenhagen: Danish Institute for Human Rights, 2003), 6 дахь тал. United Nations, *National Human Rights Institutions: A Handbook on the Establishment and Strengthening of National Institutions for the Promotion and Protection of Human Rights* (New York, 1995), 8 дахь тал.

<sup>51</sup> L. Reif, *The Ombudsman, Good Governance and the International Human Rights System* (Leiden: Martinus Nijhoff, 2004).

<sup>52</sup> B. Lindnaes, L. Lindholt, and K. Yigen (eds.), *National Human Rights Institutions: Articles and Working Papers* (Copenhagen: Danish Institute for Human Rights, 2001), 2-3 дахь тал.

<sup>53</sup> Principles Relating to the Status of National Institutions, U.N.G.A. Res.48/134. UN Doc.A/RES/48/134 (1993). United Nations, *National Human Rights Institutions: A Handbook on the Establishment and Strengthening of National Institutions for the Promotion and Protection of Human Rights* (New York, 1995) 37-8 дахь хэсэг.

дээрх тодорхойлолтуудын хүрээг таньж, тухайн улсын нутаг дэвсгэрт хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд оролцож байгаа үндэсний байгууллагуудыг бүрэн дүүрэн тогтоох шаардлагатай тохиолдолд уг хүрээнээс хальж харах шаардлагатай билээ.

**НҮБ болон бүс нутгийн олон улсын байгууллагаас Хүний эрхийн үндэсний байгууллагад харилцан адилгүй хандах нь**

НҮБ болон бүс нутгийн олон улсын байгууллагуудад ХЭҮБ-ын тодорхойлолтыг өөр өөр харах хандлага бий. Эдгээр ялгаа нь харилцан адилгүй бүс нутагт тодорхойлолтыг өөрийнхөөрөө боловсруулсан учир улам ихсэх болсон.

Олон байгууллагын хувьд НҮБ-ын 1991 онд баталсан Парисын Зарчмууд дахь ХЭҮБ-ын тухай нарийн чанд тогтоосон ойлголттой нийцэж чаддаггүй. Энэ нь байгууллагын загварыг боловсруулах талаар Парисын Зарчмуудын төслийг бэлтгэж байхдаа орхигдуулсантай холбоотой. Тус зарчмуудад ХЭҮБ-ын тодорхойлолтыг заагаагүй бөгөөд зөвхөн “үндэсний байгууллага нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чадавхитай байна” гэж үндсэн чиг үүргийн зарчимд дурьджээ<sup>54</sup>. Мөн омбудсман болон зуучлагчид бол “хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүрэг бүхий бусад этгээд” гэж заасан нь хүний эрхийн байгууллага гэж хүлээн зөвшөөрсөн ч ХЭҮБ-ын тодорхойлолтоос хассан зөрчилтэй явдал болжээ<sup>55</sup>. Гэхдээ НҮБ-ын Хүний эрхийн төвөөс анхандаа Парисын Зарчмууд нь “хүний эрхийн үндэсний

комиссын статус, түүний зөвлөх үүргийн талаарх стандартууд” гэж тодорхойлж байсан<sup>56</sup>.

Зөвлөх шинжтэй комиссын загварт анхаарсан нь “гишүүнчлэл”-ийн олон талт байдал, “комисс” гэдэг нэр томъёог хэрэглэсэн, гомдол мөрдөн шалгах нэмэлт бүрэн эрхийн талаар онцгойлж үзсэнээс харж болно. Хүний эрхийн омбудсманыг 1991 оноос хойш Испани, Португали Улсаас Латин Америк (Гватемала, Колумб Улс), Төв Европ (Польш, Унгар, Хорват, Словян, Македони, Румын Улс), Африк (Намиби Улс) зэрэг олон улсад байгуулжээ<sup>57</sup>. Өнөөдөр хүний эрхийн омбудсмантай бараг эн тэнцүү тооны хүний эрхийн комисс байна. Парисын Зарчмуудын “комисс” гэсэн ялгаа нь байгууллагын бүтцийн хувьд хоцрогдсон гэж болно.

НҮБ-ын Хүний эрхийн төв НҮБ-ын үйл ажиллагаатай холбогдуулан 1995 онд ХЭҮБ-ыг “Үндсэн хууль, хууль эсхүл зарлигийн дагуу Төрөөс байгуулагдсан, хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахын тулд тусгайлан олгосон чиг үүрэг бүхий этгээд” гэж тодорхойлсон. Үүнээс харахад тухайн үеийн ХЭҮБ-ууд нь хүний эрхийн комисс/омбудсман гэсэн хоёр категори буюу ай савд хуваагдсан байсан<sup>58</sup>. Хэдийгээр

<sup>56</sup> United Nations, National Human Rights Institutions: A Handbook on the Establishment and Strengthening of National Institutions for the Promotion and Protection of Human Rights (New York, 1995), 6 дахь нүүр;

<sup>57</sup> Reif, Ombudsman and International Human Rights System, 157-60, 188-90, 234-7; G. Kucsko-Stadlmayer (ed.), European Ombudsman-Institutions: A Comparative Legal Analysis Regarding the Multi-faceted Realisation of an Idea (Springer Wein: New York, 2008).

<sup>58</sup> United Nations, National Human Rights Institutions: A Handbook on the Establishment and Strengthening of National Institutions for the Promotion and Protection of Human Rights (New York, 1995), 7-8 дахь нүүр;

<sup>54</sup> Мөн тэнд., Парисын Зарчмуудын 1 дүгээр зүйл

<sup>55</sup> Мөн тэнд., “Үйл ажиллагааны арга” (f).

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1995 онд гаргасан “Хүний эрхийн үндэсний байгууллагууд: Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилготой үндэсний байгууллагыг байгуулах, бэхжүүлэх тухай гарын авлага” бүтээлд хүний эрхийн омбудсманы хөгжлийг хүлээн зөвшөөрсөн ч санал болгосон тодорхойлолт нь сонгодог омбудсманыг тооцоогүй тул ХЭҮБ-д тооцох эсэх эргэлзээтэй болсон.

Удалгүй НҮБ-ын цөөнгүй хүний эрхийн байгууллагууд хараат бус ХЭҮБ-ууд, түүний ач холбогдлыг анхаарч дурдах болсон. Гэхдээ НҮБ-ын гэрээний хороодын Ерөнхий зөвлөмж болон бусад баримт бичигт тодорхойлсон буюу загварын тухай нарийвчлан заагаагүй ба хараат бус байх шаардлага, Парисын Зарчмуудтай нийцсэн байхын ач холбогдлыг тусгаагүй билээ<sup>59</sup>. Жишээлбэл, 2009 он хүртэл Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Ерөнхий зөвлөмжүүдэд “омбудсман”-ыг ХЭҮБ-ын ойлголтод багтаан, эсвэл шууд жагсааж байсан ба хүний эрхийн комиссууд бол Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын оролцогч талуудын эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн зөрчлүүдэд

<sup>59</sup> Human Rights Committee, General Comment No. 31, “The Nature of the General Legal Obligation Imposed on State Parties to the Covenant.” UN Doc. CCPR/C/21/Rev.i/Add.i3 (May 26, 2004), para.15 (ICCPR, art. 2(3). Committee on the Elimination of Racial Discrimination, General Recommendation No. 17, “Establishment of National Institutions to Facilitate Implementation of the Convention” (March 25,1993), para.i (“Үндэсний комиссууд буюу тохирох бусад этгээдүүд”).

анхаарч ажиллах байгууллага гэж үзэж байсан<sup>60</sup>. Хүүхдийн эрхийн хорооноос Парисын Зарчмуудад нийцсэн, хүүхдийн төлөө тодорхой асуудал хариуцсан ХЭҮБ-ууд байгуулах тухай уриалж, ХЭҮБ-ын ойлголтыг шууд үзэл баримтлалын хувьд хүүхдийн асуудал хариуцсан нэг омбудсман буюу комиссар болгож задалснаа тэднийг эргүүлэн ХЭҮБ-уудад тооцох болсон. Мөн тус хорооноос хязгаарлагдмал нөөцтэй улсуудын хувьд тодорхой асуудал хариуцсан ХЭҮБ байгуулах боломжгүй бол “өөрийн бүтэцдээ хүүхдийн эрхийг тусгайлан хариуцсан комиссар, эсвэл хүүхдийн эрх хариуцсан тусгай алба, хэсэг” бүхий “хүүхдийн асуудалд анхаардаг өргөн хүрээтэй ХЭҮБ” байх боломжтойг хүлээн зөвшөөрсөн. Парисын Зарчмуудад заагаагүй, хувь хүний гомдлыг хүлээн авах,

<sup>60</sup> Committee on Economic, Social and Cultural Rights: General Comment No. 10, “The Role of National Human Rights Institutions in the Protection of Economic, Social and Cultural Rights,” UN Doc. E/C.12/1998/25 (December 14,1998) para. 2 (ХЭҮБ-уудад хүний эрхийн үндэсний комиссууд, омбудсманы газар, хүний эрхийн өмгөөлөгчид, ард түмний хамгаалагчид (defensores del pueblo)); General Comment No. 16, “The Equal Right of Men and Women to the Enjoyment of All Economic, Social and Cultural Rights” (ICESCR art. 3), UN Doc. E/C.12/2005/4 (August 11, 2005), para. 38; General Comment No. 17, “The Right of Everyone to Benefit from Any Scientific, Literary or Artistic Production of which He or She Is the Author” (ICESCR art. 15(i)(c)), UN Doc. E/C.12/GC/17 (January 12, 2006) para. 54; General Comment No. 19, “The Right to Social Security” (ICESCR art. 9), UN Doc. E/C.12/GC/19 (February 4, 2008), para. 77. General Comment No. 18, “The Right to Work,” UN Doc. E/C.12/GC/18 (November 24,2005), para. 48. (Үйлдвэрчний эвлэлүүд, хүний эрхийн комиссууд хөдөлмөрлөх эрхийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ.) General Comment No. 20, “Non-discrimination in Economic, Social and Cultural Rights” (ICESCR art. 2(2)), UN Doc. E/C.12/GC/20 (June 20, 2009) para. 40 (институтуудад “хүний эрхийн үндэсний байгууллагууд/ эсвэл омбуд этгээд багтана”).

мөрдөн шалгах эрх мэдэлтэй ХЭҮБ “байх ёстойг” Хүүхдийн эрхийн үндэсний хороо тэмдэглэсэн байна<sup>61</sup>.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас үе үе ХЭҮБ-уудын талаар тогтоол гаргаж байсан. Жишээлбэл, 2008 оны хуралдаанаар Ерөнхий Ассемблей “хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилготой үндэсний байгууллагуудын тухай”, “хүний эрхийг хөхиүлэн, дэмжих, хамгаалах омбудсман, зуучлагч, хүний эрхийн үндэсний бусад байгууллагуудын үүргийн тухай” хоёр тогтоол баталсан. ХЭҮБ-уудын тухай 63/172 дугаар тогтоолоор ХЭҮБ-уудын байгуулах, бэхжүүлэх явдлыг урамшуулан, “Улс бүр хүний эрхийг хөхиүлэн дэмжих зорилгын хүрээнд өөрийн үндэсний түвшний хэрэгцээнд сайтар нийцсэн үндэсний байгууллагын хамрах хүрээг сонгох эрхтэйг” зөвшөөрч, Улсууд өөрийн ХЭҮБ-уудад хараат бус, бие даасан байдлыг олгож, мөн түүний мөрдөн шалгах чиг үүргийг дэмждэг. Харин 63/169 тогтоолд тодорхой байдлаар сонгодог омбудсманы байгууллагыг ХЭҮБ-ын ай савд багтааж, түүний хүний эрхийг

<sup>61</sup> UN Committee on the Rights of the Child: General Comment No. 2, “National Human Rights Institutions in the Promotion and Protection of the Rights of the Child,” UN Doc. CRC/GC/2002/2 (November 15, 2002), paras. 1 (“ХЭҮБ-ууд нь Хүүхдийн омбуд төлөөлөгч/Хүүхдийн комиссарууд байна”), 4, 6; General Comment No. 5, “General Measures of Implementation of the Convention on the Rights of the Child” (CRC arts. 4, 42, 44(6)), UN Doc. CRC/GC/2003/5 (November 27, 2003), paras. 65, 73 (independent human rights institutions for children); General Comment No. 9, “The Rights of Children with Disabilities,” UN Doc. CRC/GC/9 (February 27, 2007), para. 24 (“[ХЭҮБ-ууд] Омбудсман эсвэл Комиссар зэрэг олон төрлийн хэлбэр, бүтэцтэй байж болох бөгөөд өргөн хүрээг хамарсан эсвэл тодорхой асуудалд анхаарч болно”); General Comment No. 12, “The Right of the Child to Be Heard,” UN Doc. CRC/GC/12 (July 12, 2009), paras. 49 (“Хүүхдийн омбудсман эсвэл комиссар зэрэг хараат бус хүний эрхийн институт байгуулах”), 97.

хөхиүлэн дэмжих, хамгаалах үүргийг хүлээн зөвшөөрсөн байна.

Гэсэн хэдий ч НҮБ-ын хүний эрхийн механизмын бүрэлдэхүүн хэсгүүдээс омбудсманыг ХЭҮБ гэсэн ай саваас хассан шийдвэр гаргасан. Тодруулбал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Ерөнхий зөвлөмжийн болон ХЭДКГ, Олон улсын омбудсманы хүрээлэнгийн гишүүнчлэлийн талаарх харилцаанд илрэлээ олсон ч ХЭДКГ омбудсмануудын хүний эрхийг хамгаалах үүргийг хүлээн зөвшөөрсөн.

ХЭҮБ-уудын төлөөлөгчдөөс бүрдсэн ОУЗХ нь ХЭҮБ-ыг магадлан итгэмжлэх, дахин магадлан итгэмжлэх асуудлыг хариуцсан бүрэн эрхийг эдэлдэг. ОУЗХ Швейцарийн хууль тогтоомжийн дагуу байгуулсан хуулийн этгээд боловч түүний хурлуудыг ХЭДКГ-ын удирдлаган дор зохион байгуулдаг<sup>62</sup>. ОУЗХ-ны магадлан итгэмжлэх тогтолцоо нь сайн дурын үндсэн дээр Парисын Зарчмуудад нийцүүлсэн байгууллагуудыг эрэмбэлж жагсаах ба ХЭҮБ магадлан итгэмжлэлд (гол төлөв А статусын магадлан итгэмжлэл бүхий) тулгуурлан НҮБ-ын хүний эрхийн байгууллагуудад хандах боломжтой болдог. Магадлан итгэмжлэлийг А (Парисын Зарчмуудад нийцсэн), В (ажиглагчийн статус, Парисын Зарчмуудад бүрэн нийцээгүй), С (Парисын Зарчмуудад огт нийцээгүй) гэж ангилдаг. ОУЗХ-ноос Парисын Зарчмуудыг тайлбарласан шинжтэй Ерөнхий дүгнэлтүүдийг гаргасан нь нөгөө талаас ОУЗХ-ны магадлан

<sup>62</sup> НҮБ-ын ХЭДКГ-ын цахим хуудас [www.ohchr.org/EN/Countries/NHRI/Pages/NHRIMain.aspx](http://www.ohchr.org/EN/Countries/NHRI/Pages/NHRIMain.aspx).



итгэмжлэхэд зориулсан удирдамж буюу зөөлөн хэм хэмжээг тайлбарлаж байгаа зөөлөн хэм хэмжээний нэг хэлбэр юм<sup>63</sup>.

ОУЗХ-ны магадлан итгэмжлэлийн тогтолцоо бол ХЭҮБ-уудыг байгуулах, бэхжүүлэхэд чиглэсэн бөгөөд түүний үр нөлөө нь ихэнх үндэсний түвшний хүний эрхийн комисс, хүний эрхийн омбудсманы байгууллагуудыг Парисын Зарчмуудад нийцсэн ХЭҮБ-уудад тооцож, тэдний олонх нь А статус авсан болно. Гэхдээ уг тогтолцоог цогц шийдэлтэй гэж үнэлээгүй нь зарим комисс, хүний эрхийн омбудсмануудад үйлчлээгүйтэй холбоотой. Ерөнхий дүгнэлтүүдийн дагуу зарим уян хатан байдлыг олгосноор хүний эрхийн омбудсманууд тавигдсан шаардлагыг хангах боломжтой болсон байна. Хэдийгээр сонгодог омбудсманы байгууллага дурдагдаагүй боловч Ерөнхий дүгнэлтийн 1.2 дахь хэсэгт “бүх ХЭҮБ-ууд Парисын Зарчмуудад жагсаасны дагуу хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих тусгай чиг үүргийг нэгэн зэрэг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй байна” гэж заажээ. Үүний дүнд үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулдаг сонгодог хэлбэрийн омбудсманы байгууллагууд нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих бүрэн эрхгүйн улмаас ХЭҮБ гэж магадлан итгэмжлэх үйл явцаас хасагдаагүй ч С статусаас дээш гарахгүй нөхцөлтэй тулгарч байна.

Үндэсний түвшнээс доогуур байгууллага, тодорхой асуудал хариуцсан байгууллагыг “хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилготой, хуулийн

дагуу байгуулсан байгууллага” гэж тооцсон ба ХЭҮБ-ууд эдгээр байгууллагуудтай хамтран ажиллахыг урамшуулсан юм. ОУЗХ-ны зүгээс Их Британид хамаарах онцгой тохиолдлыг эс тооцвол үндэсний түвшнээс доогуур байгууллагыг ХЭҮБ-уудад тооцсон туршлага байхгүй байна<sup>64</sup>. Ерөнхий дүгнэлтийн 6.6 дахь хэсгийн дагуу тухайн улсад нэгээс илүү үндэсний байгууллагатай бол тус улс дахь “хамгийн үр нөлөөтэй, цогц шинжтэй” ХЭҮБ-ыг дэмжиж, “маш ховор тохиолдолд” нэгээс илүү үндэсний байгууллагыг магадлан итгэмжлэхээр үнэлэх боломжтой бөгөөд урьдчилан хэд хэдэн нөхцлийг хангасан байх ёстой ажээ.

Энэ байр суурь нь хүний эрхийн комисстой улсууд дахь хүний эрхийн үндэсний омбудсмануудад сул тал олгож, зарим улсын хувьд хүний эрхийн комиссыг магадлан итгэмжилж, омбудсманыг орхидог байна<sup>65</sup>. Тодорхой асуудал хариуцсан байгууллагуудын хувьд ОУЗХ-ны байр суурь хүүхдийн төлөө тодорхой асуудал хариуцсан ХЭҮБ-ууд байгуулах тухай НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны Ерөнхий зөвлөмжтэй зөрчилдөж байна. Иймээс тодорхой асуудал хариуцсан үндэсний байгууллагууд магадлан итгэмжлэл авахад хүндрэл учрахаас гадна хүсэлт гаргасан цөөн байгууллага В эсвэл С статус авчээ. Хэдийгээр энэ асуудлыг Ерөнхий дүгнэлтэд зааж өгөөгүй

<sup>63</sup> ОУЗХ-ны Магадлан итгэмжлэл хариуцсан дэд хороо, “General Observations” (June 2009): [www.nhri.net/2009/General percent20observations percent20june percent202009 percenho/English.pdf](http://www.nhri.net/2009/General%20observations%20June%202009/percenho/English.pdf).

<sup>64</sup> ОУЗХ-ны Ерөнхий дүгнэлт 1.5 (хүний эрхийн бусад институтуудтэй хамтран ажиллах). Их Британийн Тэгш байдал, хүний эрхийн комисс болон Хойд Ирландын Хүний эрхийн комиссыг магадлан итгэмжилсэн.

<sup>65</sup> Грек, Норвеги, Танзани, Малави гэх мэт.

ч магадлан итгэмжлүүлсэн, тодорхой асуудал хариуцдаг таван байгууллага нь ямарваа нэгэн үндэсний түвшний хүний эрхийн комисс, эсвэл омбудсман байхгүй улс оронд хамаарч байна.

Бүс нутгийн түвшинд авч үзвэл, ХЭҮБ-ын тодорхойлолтод болон үндэсний түвшний комисс, хүний эрхийн омбудсмануудыг багтааж, бусад боломжтой этгээдийг хасдаг оролцоог чухалчилдаг хандлагыг Африкийн, Ази Номхон далайн бүс нутгаас харах боломжтой. Хоёр бүсийн тухайд бусад төрлийн хүний эрхийн байгууллагуудаас хүний эрхийн комисс маш олон тоотой байдаг.

Жишээлбэл, Африкийн бүс нутагт, Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Африкийн сүлжээ (ХЭҮБАС) 32 гишүүнтэйгээс 28 нь хүний эрхийн комисс/зөвлөл, үлдсэн 4 нь омбудсманы эсвэл комиссын хэлбэрт суурилан хүний эрх болон захиргааны удирдлагатай холбоотой бүрэн эрх агуулсан гибрид буюу нийлмэл шинжтэй байгууллага ажээ<sup>66</sup>. Үүнээс гадна тус бүс нутгийн зарим хүний эрхийн омбудсманы байгууллагууд нь авлигатай тэмцэх, хүрээлэн буй орчныг хамгаалах зэрэг бүрэн эрхийг хүлээсэн байдаг онцлогтой. Урьд Британийн эзэнт гүрний бүрэлдэхүүнд байсан Африкийн цөөн улсууд сонгодог омбудсманы байгууллагатай бол Франц хэлтэн зарим улсууд зуучлагчийн байгууллагуудтай (сонгодог омбудсман дээр суурилан

<sup>66</sup> ХЭҮБАС: [www.nanhr.org](http://www.nanhr.org). Дөрвөн нийлмэл байгууллага нь Анголын Шударга ёс, эрхийг хангагч, Намибийн Хүний эрх, захиргааны шударга ёс хариуцсан комисс, Танзанийн Хүний эрх, сайн засаглалын төлөө комисс юм.

Францын Зуучлагчийн загварыг ашигладаг), харин зарим улсуудад комисс болон омбудсман /зуучлагчийн байгууллага нэгэн зэрэг оршдог. Африкийн хүний эрхийн тогтолцооны хэсэг болохын хувьд Хүний болон ард түмний эрх хариуцсан Африкийн Комисс нь Африкийн ХЭҮБ-ууд, ОУЗХ-той харилцаагаа хөгжүүлж, Парисын Зарчмуудад нийцсэн эсэхээр ХЭҮБ-ууд стандарт тогтоон, ОУЗХ-ны магадлан итгэмжлэлийн статусыг харгалздаг ба тухайн Комиссын хуралдаанд оролцох, үг хэлэхийн тулд ХЭҮБ-ууд хамтрагчийн холбоотой байх эсэхийг шийддэг. ХЭҮБАС нь Парисын Зарчмууд болон ОУЗХ-ны магадлан итгэмжлэлийн статусыг стандарт болгон ашигладаг ч ОУЗХ-ны магадлан итгэмжлэлийн статусыг гишүүнчлэл тавих үндсэн шалгуур болгодоггүй.

Ази Номхон далайн бүс нутагт, хүний эрхийн үндэсний комиссуудын зэрэгцээ төрийн түвшний болон хүүхдийн эрх зэрэг тодорхой асуудал хариуцсан комисс Австрали, Шинэ Зеланд зэрэг улсад бий<sup>67</sup>. Мөн омбудсманы байгууллагын төрөл бүрийн хэлбэрийг агуулсан. Ихэнх омбудсманы байгууллагууд нь давхар бүрэн эрхтэй ч Зүүн Тиморын Хүний эрх, шударга ёсыг хангагч зэрэг цөөн байгууллага хүний эрхтэй холбоотой бүрэн эрхийг хэрэгжүүлж, бусад нь авлигатай тэмцэх, ёс зүйн асуудал эрхэлсэн бүрэн эрхтэй байдаг. Хэдийгээр Ази Номхон далайн бүс нутагт ХЭҮБ-ууд хандах боломжтой бүс нутгийн хүний эрхийн тогтолцоо байхгүй боловч Хүний эрхийн үндэсний байгууллагуудын

<sup>67</sup> Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Ази Номхон далайн чуулган: [www.asiapacificforum.net/members](http://www.asiapacificforum.net/members)

Ази Номхон далайн чуулган (Ази Номхон далайн чуулган) бол тухайн бүс нутагт ХЭҮБ-уудыг байгуулах, бэхжүүлэх явдлыг дэмждэг ХЭҮБ-уудын бүс нутгийн сүлжээ юм. Ази Номхон далайн чуулган нь санал өгөх эрхтэй бүрэн эрхт гишүүн байхын тулд тухайн ХЭҮБ Парисын Зарчмуудад нийцсэн байхыг шаарддаг ба тухайн улсын төрөөс “хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор тусгай чиг үүрэгтэйгээр” үндэсний байгууллагыг байгуулсан бол Чуулганы зүгээс ХЭҮБ гэж ангилдаг. Иймээс нийт 15 бүрэн эрхт гишүүний 14 нь хүний эрхийн үндэсний комисс/ төв, зөвхөн 1 нь Зүүн Тиморын Хүний эрх, шударга ёсыг хангагч буюу омбудсман байдаг. Ази Номхон далайн чуулганы бүрэн эрхгүй гишүүнчлэл нь Парисын Зарчмуудад бүрэн нийцээгүй ХЭҮБ-уудад нээлттэй ч НҮБ-ын гишүүн нэг улсыг Чуулганы нэг гишүүнээр тооцдог онцлогтой<sup>68</sup>. Ази Номхон далайн чуулганы хандлага нь ХЭҮБ-т үндэсний түвшний хүний эрхийн комиссууд, хүний эрхийн омбудсманы байгууллагуудыг хамруулж, үндэсний түвшнээс доогуур байгууллага, тодорхой асуудал хариуцсан болон сонгодог омбудсманы байгууллагыг хасдаг ажээ.

Европ бол үндэсний хүний эрхийн байгууллагууд нь хоорондоо маш ялгаатай бүс нутаг юм. Хүний эрхийн омбудсман 1970-аад оны дунд үед Өмнөд Европод байгуулагдсанаас хойш Төв болон Зүүн Европод олноор байгуулагдаж, 1990-ээд оноос Баруун Европод өөрчлөгдсөн хэлбэр бүхий хүний эрхийн омбудсман байгуулагдах

болжээ. Европод хүний эрхийн комисс цөөн хэдий ч хүний эрхийн омбудсман, үндэсний түвшнээс доогуур байгууллага, тодорхой асуудал хариуцсан хүний эрхийн байгууллага их бий. Одоогоор 47 гишүүн бүхий Европын Зөвлөл нь омбудсманыг хүний эрхийг хамгаалах дотоодын чухал хэрэгсэл гэж үзсээр байна.

Европын Зөвлөлийн Сайд нарын хороо 1985 онд омбудсмануудад хүний эрхийг хамгаалах эрх мэдлийг олгох зөвлөмж гаргаж, 1997 онд өөрийн ХЭҮБ-гүй гишүүн улсуудыг “хүний эрхийн комисс... омбудсман эсвэл түүнтэй харьцуулж болох байгууллага” байгуулахыг уриалжээ<sup>69</sup>. Европын Зөвлөл 1999 онд Хүний эрхийн комиссарын албыг байгуулж, “үндэсний омбудсман буюу хүний эрхийн салбарын ижил төстэй байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэх” болон гишүүн улсууд дахь хүний эрхийн бүтэцтэй хамтран ажиллах гэсэн хоёр үндсэн чиг үүрэг хэрэгжүүлэх болсон. Тус комиссарын хууль ёсны бүтцээс ХЭҮБ-уудын талаар илэрхий тодорхой тайлбар гаргаагүй. Гэхдээ Европын Зөвлөлийн Хүний эрхийн комиссарын үйл ажиллагаа гишүүн улсуудын ХЭҮБ-ууд, үндэсний түвшнээс доогуур байгууллага болох омбудсманы албан газрыг татан оролцуулах болсон<sup>70</sup>. Комиссар “хүний эрхийн үндэсний байгууллагууд (ХЭҮБ-ууд) гэсэн ойлголт нь Парисын Зарчмуудыг эшлэн, гол төлөв Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүрээнд

<sup>68</sup> Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Ази Номхон далайн чуулган: [www.asiapacificforum.net/members](http://www.asiapacificforum.net/members)

<sup>69</sup> Council of Europe, Committee of Ministers, Rec. No.R(85)i3 (September 23, 1985); Committee of Ministers, Rec. 97(14) (September 30, 1997)

<sup>70</sup> Council of Europe, Committee of Ministers, Res. No. (99)50 (May 7, 1999), paras. 3(0)—(d); COE Commissioner for Human Rights: [www.coe.int/t/commissioner/default\\_en.asp](http://www.coe.int/t/commissioner/default_en.asp).

боловсронгүй болж байгааг” цохон тэмдэглэж, “хүний эрхийн үндэсний байгууллага” гэсэн нэр томъёогоор Парисын Зарчмуудад тулгуурлан байгуулсан хүний эрхийн комисс буюу байгууллагатай нэгэн адил хүний эрхийн омбудсманыг илэрхийлэх болсон байна<sup>71</sup>. Тэрээр мөн “хүний эрхийн үндэсний бүтэц” (ХЭҮБү) гэсэн ойлголтыг танилцуулан, “тухайн сүлжээний хамтрагчид бол Парисын Зарчмуудтай нийцсэн, Европын Зөвлөлийн үнэт зүйлсийг зөвшөөрсөн үндэсний, бүс нутгийн, орон нутгийн, тодорхой асуудал хариуцсан байгууллагууд”-ыг чухалчилсан билээ<sup>72</sup>. Хүний эрхийн омбудсман болон сонгодог омбудсманыг нэгэн зэрэг хүний эрхийн үндэсний бүтэцэд хамруулсан юм<sup>73</sup>. Иймээс Европын бүс нутаг хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр ажилладаг байгууллагуудыг аль болох татан оролцуулах буюу хамруулах хандлагатай ажээ.

Америкийн бүс нутгийн улс орнуудад хүний эрхийн омбудсманы байгууллагын зэрэгцээ хүний эрхийн комисс эсвэл сонгодог омбудсман байгуулжээ. Хэдэн жилийн өмнө Америкийн улсуудын байгууллагын (АУБ) Ерөнхий Ассемблейгаас омбудсманууд, ард түмний хамгаалагч, бусад хүний эрхийн омбудсманы байгууллагуудын хүний эрхийн үйл ажиллагаануудыг дэмжсэн

шинжтэй шийдвэр гаргажээ. Эдгээр тогтоолууд нь ОУЗХ-ноос А статус магадлан итгэмжилсэн үндэсний түвшний хүний эрхийн омбудсман болон комиссуудаас бүрдсэн Америкийн Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын сүлжээ (Америкийн сүлжээ), гол төлөв сонгодог омбудсмануудаас бүрдсэн Карибын Омбудсманы Холбооны үйл ажиллагааг баталгаажуулсан<sup>74</sup>. Тус бүс нутагт Омбудсмануудын Испани-америкийн Холбоо идэвхтэй ажилладаг бөгөөд гишүүнчлэлдээ үндэсний болон үндэсний түвшнээс доогуур түвшний хүний эрхийн омбудсмануудыг багтаасан байдаг<sup>75</sup>. Гэхдээ АУБ-ын Ерөнхий Ассемблей ОУЗХ-ны магадлан итгэмжлэл бүхий ХЭҮБ-уудын хүний эрхийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг чухалчилж, АУБ-ын хүний эрхийн тогтолцоонд Америкийн сүлжээний гишүүд оролцоход зориулсан тогтолцоо байгуулах талаар онцлох болжээ. Иймээс тус бүс нутгийн тухайд НҮБ-ын ХЭДКГ, ОУЗХ-ны ХЭҮБ-уудыг тодорхойлох хандлагыг нэвтрүүлж, сонгодог омбудсман болон бүх төрлийн үндэсний түвшнээс доогуур байгууллага, тодорхой асуудал хариуцсан байгууллагуудыг хамруулахгүй болсон байна.

#### **Олон улсын өмнө хүлээсэн төрийн үүргийг хэрэгжүүлэхэд Хүний эрхийн Үндэсний Байгууллагыг ашиглах нь**

Хүний эрхийн олон улсын гэрээ, зарим олон улсын санаачлагын зүгээс холбогдох улсуудыг олон улсын өмнө

<sup>71</sup> Thomas Hammarberg, COE Commissioner for Human Rights, “Recommendation on Systematic Work for Implementing Human Rights at the National Level,” CommDH (2009) 3 (February 18, 2009).

<sup>72</sup> COE Commissioner for Human Rights, “Co-operation with National Human Rights Structures,” [www.coe.int/t/commissioner/Activities/NHRS/default/\\_en.asp](http://www.coe.int/t/commissioner/Activities/NHRS/default/_en.asp).

<sup>73</sup> COE Commissioner for Human Rights, “National Human Rights Structures,” [www.coe.int/t/commissioner/links/omb\\_nhri\\_en.asp](http://www.coe.int/t/commissioner/links/omb_nhri_en.asp).

<sup>74</sup> Америкийн хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын сүлжээ: [www.rindhca.org](http://www.rindhca.org).

<sup>75</sup> [www.portalfio.org/inicio/ique-es-la-fio](http://www.portalfio.org/inicio/ique-es-la-fio)

хүлээсэн амлалтаа биелүүлэхийн тулд өөрийн үндэсний байгууллагыг ашиглахыг шаардах буюу уриалдаг. Жишээлбэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, аж ахуйн нэгж, корпорацийн зүй бус үйлдлийг зохицуулах зэргийг дурдаж болно. Хүний эрхийн комисс, хүний эрхийн омбудсман, сонгодог омбудсман, тодорхой асуудал хариуцсан хүний эрхийн байгууллагуудыг эдгээр үүргийг хэрэгжүүлэхэд ашиглаж байгаа буюу анхаарч байна.

Эрүү шүүлтийн эсрэг конвенцийн Нэмэлт протоколын (ЭШЭНП) дагуу эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийг харгалзах газруудад олон улсын болон үндэсний хэмжээний хяналт тавих тогтолцоог байгуулдаг. ЭШЭНП нь оролцогч улсуудыг нэг болон түүнээс их урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудыг (УСМ) Парисын Зарчмуудад заасан шалгуурын дагуу “тогтоох, томилох, байгуулах”-ыг шаарддаг. УСМ нь шаардлагатай тохиолдолд эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийн хамгаалалтыг бэхжүүлэх зорилгоор дээрх газруудад шалгалт хийх боломжтой. Оролцогч улсын зүгээс тогтмол, урьдчилан мэдэгдэлгүйгээр шалгалт хийхийг УСМ-д зөвшөөрөх, УСМ-д саатуулагдсан этгээдэд үзлэг хийх, саатуулагдсан этгээдтэй харьцах харьцаа, олон улсын өмнө хүлээсэн төрийн үүрэгтэй холбогдуулан нөхцөл байдлаа сайжруулахын тулд төрд зөвлөмж өгөх, өөрийн ажиглалт, одоогийн эсвэл хууль тогтоомжийн төсөлд санал өгөх эрх мэдлийг олгосон байх ёстой. Энэхүү Нэмэлт протоколыг соёрхон баталсан улсууд УСМ-уудыг бий болгохдоо хүний эрхийн комисс, хүний эрхийн омбудсман, байнга биш ганц нэг тохиолдолд сонгодог

омбудсман, тодорхой асуудал хариуцсан хүний эрхийн байгууллага зэрэг одоогийн идэвхтэй байгууллагуудыг ашиглаж байна. 2009 оны 11 сарын байдлаар 7 улс өөрийн хүний эрхийн комиссыг УСМ-аар томилж, өөр 4 улс ийм шийдвэр гаргахаар бэлтгэж байжээ<sup>76</sup>. Европ, Латин Америк дахь хүний эрхийн 14 омбудсманыг томилж, 7 байгууллагыг томилохыг судалж байна<sup>77</sup>. Дани, Шинэ Зеланд дахь сонгодог омбудсманы байгууллагуудад УСМ-ын статус олгосон бол Люксембургийн омбудсманыг УСМ болгох талаар судалж байна. Англи, Шинэ Зеланд дахь Хүүхдийн Комиссарууд төрөөс байгуулсан цөөнгүй УСМ-уудад багтдаг. Европын хувьд омбудсманууд мөрдөн шалгах хүчирхэг эрх мэдэлтэй тул УСМ-аар ашиглах нь түгээмэл ажээ.

;НҮБ хүний эрхийг зөрчдөг эсвэл шууд бусаар хүний эрх зөрчихөд хүргэдэг корпорацийн үйл ажиллагаатай холбоотой хууль зүйн асуудлуудад анхаарал хандуулж эхэлсэн. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгч 2008 онд

<sup>76</sup> Мали, Мавритиус, Мексик, Мальдив, Шинэ Зеланд, Шотланд Улс томилж, Чили (байгуулах), Либери, Мадагаскар (байгуулах), Марокко томилохоор судалж байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг, ЭШЭНП Улсуудын статус: Соёрхон баталсан болон хэрэгжилтийн байдал (2009 оны 11 дүгээр сарын 17), [www.apt.ch/content/view/44/84leng/en/](http://www.apt.ch/content/view/44/84leng/en/).

<sup>77</sup> Албани, Армени, Азербейжан, Коста Рика, Кипр, Бүгд Найрамдах Чех Улс, Эстони, Гүрж, Македони, Молдав (Зөвлөх үүрэгтэй зөвлөл бүхий), Польш, Словян (төрийн бус байгууллагууд (ТББ)- тай хамт), Испани (УСМ-ын чиг үүргийг Хамгаалагчийн орлогчид шилжүүлсэн), Швед (Хууль зүйн канцлертай хамт) томилж, Хорват, Финланд, Гана, Бүгд Найрамдах Киргизстан Улс, Монтенегро, Никарагуа, Украин томилохоор судалж байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг, ЭШЭНП Улсуудын статус: Соёрхон баталсан болон хэрэгжилтийн байдал (2009 оны 11 дүгээр сарын 17), [www.apt.ch/content/view/44/84leng/en/](http://www.apt.ch/content/view/44/84leng/en/).

“Хамгаалах, хүндэтгэх, сэргээн эдлүүлэх: Бизнес болон хүний эрхийн хүрээ” (Рагги тайлан) сэдэвт өөрийн тайлангаа танилцуулсан<sup>78</sup>. Энэхүү илтгэлийн “сэргээн эдлүүлэх” гэсэн бүрэлдэхүүн хэсэгт корпорациудын хүний эрхийн эсрэг зүй бус үйлдлийн улмаас хохирсон хохирогчдод илүү үр нөлөөтэй шүүхийн болон шүүхийн бус сэргээн эдлүүлэх арга хэмжээ шаардлагатайг дурдаж, ХЭҮБ-уудыг шүүхийн бус чухал сэргээн эдлүүлэх бүрэлдэхүүнд тооцон, шүүхүүд нь үр нөлөөгүй болсон улсуудын хувьд шүүх эрх мэдлийг орлох хэмжээнд үнэлсэн байна. Тус илтгэлд корпорацийн үйл ажиллагааг ХЭҮБ-ууд хуулийн дагуу хянах “үзэл баримтлалын хувьд тохиромжтой, боломжтой, нээн илрүүлэх чадвартай төдийгүй маргаан таслах эсвэл зуучлах эсэхээс үл хамааран ялангуяа эдгээр үйл явцыг эрхлэх нөхцөл байдлыг хангасан” гэжээ. Тайлангийн энэ хэсгийг бичихдээ хүлээн зөвшөөрөгдсөн 85 ХЭҮБ-уудын дунд хийсэн судалгаагаар 40 нь хүний эрхтэй холбоотой корпорацийн үйл ажиллагааны талаарх гомдлыг хүлээн авах боломжтой болохыг онцолсон байна. Тус судалгаа нь зөвхөн ОУЗХ-ноос магадлан итгэмжилсэн ХЭҮБ-уудыг хамарсан тул магадлан итгэмжлээгүй олон тооны байгууллагуудыг орхисон учир дутагдалтай ч магадлан итгэмжлэл бүхий сонгодог омбудсманы байгууллагыг хамарчээ.

Тухайн тайланд илэрхийлсэн хандлагыг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс албан

<sup>78</sup> Хүний эрх, үндэстэн дамнасан корпорациуд, бусад бизнесийн нэгжүүдийн асуудал хариуцсан Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгчийн тайлан, “Хамгаалах, хүндэтгэх, сэргээн эдлүүлэх: Бизнес болон хүний эрхийн хүрээ,” UN Doc. A/HRC/8/5 (April 7, 2008)

ёсоор дэмжсэн ба тусгай төлөөлөгч 2009 онд хүрээний үйл ажиллагааг тодорхойлсон тайланг танилцуулсан юм<sup>79</sup>. Энэхүү 2009 оны илтгэлд ХЭҮБ-уудын сэргээн эдлүүлэх боломжит үүргийг тодруулан, “зарим ХЭҮБ-уудын бүрэн эрх нь тэднийг бизнес болон хүний эрхийн талаарх үйл ажиллагаанд оролцох боломжгүй болгож байгаа ч зарим байгууллагын хувьд сонголт, уламжлал, чадавхийн асуудал байсаар байна” гэжээ. Тусгай төлөөлөгч илүү олон ХЭҮБ-ууд бизнесээс үүдэлтэй хүний эрхийн зүй бус үйлдлүүдэд анхаарал хандуулах арга замыг бий болгоно гэдэгт итгэлтэй байгаагаа тэмдэглэсэн байна. Мөн Австралийн банк, харилцаа холбооны үйлдвэрлэл дэх сонгодог омбудсманы тогтолцоог хүний эрх бизнесийн нөлөөнд чиглэх салбар хоорондын тусгай загвар байж болох талаар дурдсан ажээ.

#### **Хүний эрхийн Үндэсний Байгууллагад тооцох боломжтой этгээд**

Анх НҮБ-ын зүгээс ХЭҮБ-уудыг өргөн хүрээгээр үзсэн ч аажимдаа шүүх, захиргааны тусгай шүүх, хууль тогтоох байгууллага, ТББ-ууд зэрэг этгээдийг байгууллагад тооцохоо больж, ХЭҮБ-ын ойлголтыг бий болгох явцад явцуу, чиг үүргийн талаас хандах хандлагатай болсон байна.

##### а. Хүний эрхийн комисс

Анхны хүний эрхийн комиссууд

<sup>79</sup> Бизнес ба хүний эрх: “Хамгаалах, хүндэтгэх, сэргээн эдлүүлэх” хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлэх нь. Хүний эрх, үндэстэн дамнасан корпорациуд, бусад бизнесийн нэгжүүдийн асуудал хариуцсан Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгчийн тайлан, “Хамгаалах, хүндэтгэх, сэргээн эдлүүлэх: Бизнес болон хүний эрхийн хүрээ,” Human Rights Council, 11th Sess., Agenda item 3, UN Doc. A/HRC/11/13 (April 22, 2009)

Дэлхийн хоёрдугаар дайны дараа Франц, Британийн эзэнт гүрний бүрэлдэхүүнд байсан улсуудад үүсч, 1990-ээд оноос маш эрчтэй нэмэгдэх болсон. Хүний эрхийн комиссууд нь үндсэн хууль, хууль тогтоох, эсвэл гүйцэтгэх эрх мэдлийн шийдвэрт тулгуурласан эрх зүйн хэм хэмжээний хүрээнд хууль тогтоох, эсвэл гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас томилсон хамтын удирдлагын байгууллага юм. Эдгээр нь зөвлөгөө өгөх, олон улсын хүний эрхийн гэрээнүүдийг соёрхон батлах, түүнийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд нөлөөлөх, хүний эрхийн судалгаа, боловсролын үйл ажиллагаа явуулах, НҮБ-ын хүний эрхийн гэрээний байгууллагуудыг мэдээллээр хангах, гэрээний байгууллагуудын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг хүний эрхийг хөхиүлэн дэмжих янз бүрийн чиг үүрэг хүлээдэг.

Судлаач Поёолайнен хүний эрхийн комиссуудыг

- Комисс (мөрдөн шалгах эрх мэдэлтэй)
- Зөвлөх шинжтэй комисс (гол төлөв мөрдөн шалгах эрх мэдэлгүй, төрд зөвлөгөө өгөхөд анхаардаг Франц загвар – Франц хэлтэн Африкийн орнуудад түгээмэл)
- Хүрээлэн (гол төлөв мөрдөн шалгах эрх мэдэлгүй, судалгаа, боловсролд анхаардаг – Баруун Европод түгээмэл) гэж ангилсан байна<sup>80</sup>.

Мөрдөн шалгах эрх мэдэл бүхий

комиссууд нь гомдлын үндсэн дээр, эсвэл өөрийн санаачлагаар мөрдөн шалгах, зөрчлийг арилгах буюу зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхээр зөвлөмж гаргах (зарим байгууллагын хувьд шүүхэд хэргийг шилжүүлэх), саатуулагдсан хүмүүс бүхий газар шалгалт хийх, хүний эрхийн асуудлаар шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах, ямарваа нэгэн зохицуулалт нь холбогдох эрх зүйн баримт бичгүүдтэй нийцэж буй эсэх талаар шийдвэр гаргаж болно. Мөн комиссууд өөрийн эрхлэх хуулиар тогтоосон хүний эрхийн асуудлаараа нэлээдгүй ялгагдах ба зарим комисс ялгаварлан гадуурхалтын эсрэг, цөөнгүй хэсэг нь тодорхой эрхүүдэд анхаардаг бол төрийн/нийтийн албаны асуудлыг харьяалсан комиссоос гадна төрийн алба, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд зэрэг хяналт тавих бүрэн эрхтэй байгууллага ч бий.

Дэлхийн улс орнуудын хувьд, ялангуяа Баруун Европ, Африк, Ази Номхон далай, Америкийн зарим хэсэгт үндэсний болон үндэсний түвшнээс доогуур байгууллага бүхий хүний эрхийн комиссууд байна. Үндэсний түвшний комиссын зэрэгцээ үндэсний түвшнээс доогуур байгууллагаас гадна хилийн чанадад ажилладаг 60 гаруй байгууллага ажилладаг<sup>81</sup>. Баруун Европод харилцан адилгүй бүрэн эрх бүхий төрөл бүрийн комисс, хүрээлэн байдаг бол Африкт мөрдөн шалгах, зөвлөх хэлбэртэй олон комисс үйл ажиллагаа явуулж байна. Ази Номхон далайд хүний эрхийн комисстой улс орнуудын тоо улам нэмэгдэх жишээтэй. Америкийн хувьд

<sup>80</sup> A. Pohjola, The Evolution of National Human Rights Institutions: The Role of the United Nations

<sup>81</sup> “Хүний эрхийн үндэсний байгууллагуудын тоо баримт” (хүний эрхийн болон сонгодог омбудсмануудыг хасч, 61 комиссыг тооцжээ), [www.nhri.net/nationaldatalist.asp](http://www.nhri.net/nationaldatalist.asp) (2009.10.23)

Канад (холбооны, мужийн, газар нутгийн түвшний), Мексик (үндэсний болон төрийн түвшний), Бермуда комиссуудтой ба Уругвай комиссоо байгуулж, Чили хүрээлэнгийн хэлбэрийг судалж байна. Зааг ялгаагүй шахам болсноор Гана, Танзани Улс комиссын хэлбэр дээр суурилан хүний эрхийн/омбудсманы байгууллагын нийлмэл институтыг бий болгожээ.

#### б. Омбудсман

XIX зуунд үүссэн сонгодог омбудсман 1960-аад оны эхээр Скандинаваас түгж, анх Британийн эзэнт гүрний бүрэлдэхүүнд байсан улсуудад, цаашид дэлхийд тархсан. Хууль тогтоох эрх мэдлийн салбартай хамтран, захиргааны хууль бус явдал, шударга бус үзэгдэлд хяналт тавих омбудсманы үндсэн эрх мэдэл бол олон нийтийн гомдлын үндсэн дээр эсвэл өөрийн санаачлагаар захиргааны бүтэц / гүйцэтгэх эрх мэдлийн салбарыг хараат бусаар мөрдөн шалгах, шүүхэд төлөөлөх, эрх зүйн болон захиргааны туршлагыг шинэчлэхэд зориулсан зөвлөмж өгөх, хууль тогтоох эрх мэдлийн салбарт, олон нийтэд жил бүр эсвэл тусгайлан бэлтгэсэн илтгэл гаргах болно. Омбудсманы байгууллагуудыг ихэвчлэн үндсэн хууль эсвэл хууль тогтоомжоор байгуулдаг. Зарим омбудсман нь олон гишүүнтэй байхад зарим нь гүйцэтгэх эрх мэдлээс томилох жишээтэй. Цөөнгүй омбудсманы байгууллага, ялангуяа Европын бүсийн байгууллага эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүс байрлах газруудыг шалгах эрх мэдэлтэй.

Сонгодог омбудсман хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах бүрэн эрхийг хэрэгжүүлдэггүй. Гэхдээ тэд захиргааны үйл ажиллагаанд нарийн хяналт тавих тул цагдаа, шорон, цагаачлалын албаны

ажилтан зэрэг хүний эрхийг зөрчиж болзошгүй захиргааны албан хаагчдыг байнга шалгадаг онцлогтой. Зарим омбудсман захиргааны үйл ажиллагааг хууль ёсны эсэхийг тогтоох зорилгоор омбудсманы шударга байдлын стандартыг улам өргөжүүлсэн, дотоодын хүний эрхийн хууль тогтоомжийг (олон улсын хүний эрхийн хэм хэмжээг өөрийн үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн хүлээсэн төрийн үүргийг хамруулан) ашиглах нь бий. Жишээлбэл, Европын сонгодог омбудсман (Нидерланд, Дани, Малта гэх мэт) Европын Хүний эрхийн тухай конвенц (ЕХЭТК) зэрэг олон улсын хүний эрхийн хэмжээг ашиглаж ирсэн. Канад Улсын мужийн омбудсман НҮБ-ын хүний эрхийн олон улсын гэрээ, шорон болон хорих ангиуд дахь хүмүүсийн харьцааг мөрдөн шалгах удирдамж зааврыг ашиглаж байсан<sup>82</sup>. Британийн Колумб, Нидерланд, Бермуда зэрэг улс хүүхдийн асуудлыг мөрдөн шалгасан тайлан, зөвлөмжүүддээ НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийг хэрэглэсэн. Үүний зэрэгцээ эн тэргүүнд Европын Холбооны бүсийн хэмжээнд хүний эрхийг үр нөлөөтэй захиргаатай уялдуулж, омбудсманыг бүхний голд байрлуулах замаар хүний эрхийн хэм хэмжээг сахиулах механизм болгож байна<sup>83</sup>.

<sup>82</sup> L. Reif, *The Ombudsman, Good Governance and the International Human Rights System* (Leiden: Martinus Nijhoff, 2004).

<sup>83</sup> EU Charter of Fundamental Rights, art. 41 (2000); in Treaty of Lisbon (2007); South Africa Constitution, s. 33(1); J. Wakefield, *The Right to Good Administration* (Netherlands: Kluwer Law International, 2007).



Сонгодог омбудсманы байгууллагуудын зохион байгуулсан хүний эрхийн үйл ажиллагаа нь тэдний ажлын ачааллын маш бага хувийг эзэлдэг бол зарим омбудсман огт хүний эрхийн асуудалд анхаардаггүй байна. Мөн ихэнх сонгодог омбудсман зөвхөн гомдол шийдвэрлэж, өөрийн санаачлагаар мөрдөн шалгадаг ч хүний эрхийн омбудсман, комисст олгосон илүү өргөн хүрээтэй хөхиүлэн дэмжих чиглэлийн бүрэн эрх байдаггүй. НҮБ-ын байр сууринаас үзвэл, сонгодог омбудсманыг ХЭҮБ-уудад тооцох нь Парисын Зарчмууд дахь шаардлагуудыг үндэслэлгүйгээр дордуулах, хүний эрхийг хангах хүсэлгүй төрийн зүгээс хүний эрхийн асуудалд огт анхаардаггүй сонгодог омбудсманы байгууллагыг бий болгох замаар хүний эрхийн зайлшгүй хамгаалалтыг үндэсний хэмжээнд үгүйсгэх боломж олгоно. Нэмж өгүүлэхэд омбудсмануудаас хүний эрхийн салбарын туршлагатай байхыг шаарддаггүй. Гэсэн хэдий ч зарим омбудсман хүний эрхийн хэм хэмжээг тасралтгүй хэрэглэдэгээр (Баруун Европын орнуудад) ХЭҮБ-ыг тодорхойлох зааг ялгаанд тулж ирдэг бол зарим нь тус зааг ялгаанд хүрэхгүй байх (ЭШЭНП-ын УСМ-ын статус бүхий сонгодог омбудсманууд) тохиолдол бий. Европын бүс нутгийн байр сууринаас үзвэл, сонгодог омбудсманууд нь илүү өргөн хүрээг хамарсан Хүний эрхийн Үндэсний Бүтцийн тогтолцоонд багтдаг. Улс орнуудын одоогийн чиг хандлагын тухайд сонгодог омбудсманаас илүүтэйгээр дор дурдах хүний эрхийн омбудсман байгуулахад анхаарч байна. Хэдийгээр сонгодог омбудсман алга болохгүй боловч тэдний тоо буурах нь дамжиггүй.

#### в. Хүний эрхийн омбудсман

Хүний эрхийн комисс, сонгодог омбудсманы загварууд бол материаллаг өөрчлөлтгүйгээр олон улсад бий болсон, амжилттай болсон “эрх зүйн рецепт” юм<sup>84</sup>. Зарим улсад (бүх Британийн Эзэнт гүрний бүрэлдэхүүн байсан улсуудад) комисс болон омбудсман нэгэн зэрэг байгуулсан байна. Харин эдгээр хоёр загварыг үндсэн хэлбэрээр нь нийцүүлэх явдал 1970-аад оны дундаас эхэлсэн. Харьяаллын хувьд ялгаатай ч гол төлөв ардчилсан байдлаар хөгжиж байгаа улсууд нь дээрх хоёр загварын бүрэлдэхүүн хэсгүүдээс сонгож, гибрид буюу нийлмэл шинжтэй байгууллага болох “хүний эрхийн омбудсман” үүсгэсэн<sup>85</sup>. Португалийн Шударга ёсыг хангагч (Provider of Justice), Испанийн Ард түмний хамгаалагч (Defensor del Pueblo) зэрэг байгууллагын чиг хандлага үүнээс эхтэй.

Хүний эрхийн омбудсманы байгууллага нь ихэвчлэн дангаар тэргүүлсэн (омбудсман, комиссар), зарим улсад орлогч омбудсман тавигдах шалгууруудыг хуульчилсан ажээ. Эдгээр зохицуулалтыг үндсэн хууль, эсвэл хууль тогтоомжид зааснаас гадна дийлэнх тохиолдолд хууль тогтоох байгууллагаас томилдог. Тэд хүний эрхийг хамгаалах болон захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих бүрэн эрхийг хослуулсан байхад зарим байгууллага нь үүний зэрэгцээ нэмэлт чиг үүрэг хэрэгжүүлэх жишээтэй.

<sup>84</sup> Michele Graziadei, “Comparative Law as the Study of Transplants and Receptions,” in M. Reimann and R. Zimmermann (eds.), *The Oxford Handbook of Comparative Law* (Oxford: Oxford University Press, 2006), 441–76.

<sup>85</sup> “Хүний эрхийн омбудсман” гэсэн нэр томъёог ашиглахын зэрэгцээ Ард түмний хамгаалагч (Defensor del Pueblo), Хүний эрхийн прокурор (Procurador) Иргэний эрх хариусан комиссар, Хүний эрхийн омбуд этгээд, Омбудсман гэж ижил институтуудад өөр нэршил ашиглаж байна.

Хүний эрхийн омбудсман олон нийтийн гомдлыг хянан шийдвэрлэх эрх мэдэл ямагт байх төдийгүй өөрийн санаачлагаар мөрдөн шалгах, хаалттай байгууллагад шалгалт хийх, Үндсэн хуулийн болон бусад шүүхүүдэд төлөөлөн нэхэмжлэх, төрийн албан хаагчдад хариуцлага тооцуулах, судалгаа хийх, боловсрол олгох эрхтэй. Ихэнх нь гагцхүү төрийн албаны үйл ажиллагаанд анхаардаг ч нэгэн зэрэг хувийн хэвшлийг харьяалах асуудалд багтаах тохиолдол бий.

Сүүлийн гучин жилийн хугацаанд олон хүчин зүйлийн улмаас шинэ байгууллага бий болгох, эсвэл ажиллаж байгаа сонгодог омбудсман хүний эрхийн асуудал хариуцах бүрэн эрх олгох байдлаар хүний эрхийн омбудсман олноор байгуулах болсон. Эдгээр хүчин зүйлд ардчиллын хөдөлгөөн, харьцуулсан эрх зүйн нөлөө (жишээлбэл, Латин Америкийн иргэний эрх зүйн улсууд Испанийн загварыг ихэд ашиглах болсон), тухайн улс хязгаарлагдмал нөөц баялгийн улмаас нэг байгууллагад хөндлөн шинжтэй хариуцлагын цөөнгүй бүрэн эрхийг олгох замаар зардлын үр нөлөөтэй байдлыг дээшлүүлэх, олон улсын санаачлагын зүгээс тухайн улсыг олон улсын өмнө хүлээсэн амлалтаа биелүүлэхийн тулд өөрийн үндэсний байгууллагыг ашиглахыг шаардах зэрэг болно<sup>86</sup>.

Үүнтэй уялдан 2003 оны дунд үе гэхэд дэлхий дахинд ойролцоогоор үндэсний түвшний 110 хүний эрхийн омбудсманы 50 орчим хувь нь хүний эрхийн омбудсман

байснаас гадна Испани, Аргентин зэрэг улсад үндэсний түвшнээс доогуур хүний эрхийн омбудсман бий болсон юм. Латин Америкийн ихэнх улс, Карибын нутгийн улсууд хүний эрхийн омбудсманы загвар ашигладаг. Төв, Зүүн Европын ихэнх орон хүний эрхийн омбудсманы байгууллагатай. Африк, Ази Номхон далайн бүс нутгаас нийлмэл шинжтэй байгууллагыг харах боломжтой<sup>87</sup>. Баруун Европын улсуудад омбудсманыг хүний эрхийн асуудал хариуцсан бүрэн эрхтэй байдлаар нийлмэл шинжтэй байгуулах нь нэмэгдсэн байна<sup>88</sup>. Гана, Танзани, Ямайка, Латви зэрэг улсын хувьд өөрийн ажиллаж байсан байгууллагыг нийлмэл шинжтэй болгожээ.

#### г. Тодорхой асуудал хариуцсан Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд

Хүүхэд, угсаатны цөөнх, уугуул хүмүүс зэрэг хүний эрхийн талаас нь тусгайлан анхаарал хандуулах шаардлагатай эмзэг бүлэг хүн амын дунд байдаг. Улс орнуудад, ялангуяа Европ тивд эдгээр хүмүүсийг хамгаалахын тулд тодорхой асуудал хариуцсан ХЭҮБ-уудыг ихээр байгуулах болсон<sup>89</sup>. Тодруулбал, хүүхдийн омбудсман, комиссар, угсаатны болон арьс үндэсний цөөнхийг хамгаалах асуудал хариуцсан комиссар, мөн тэгш эрх хариуцсан төрөл бүрийн хэлбэртэй комиссуудыг нэрлэж болно. Өмнө дурдсанчлан, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо нь Хүүхдийн

<sup>87</sup> Ангол, Этиоп, Гамби, Гана (нийлмэл комисс), Лесото, Малави, Намиби, Сейшелес, Танзани (нийлмэл комисс), Зүүн Тимор, Папуа Шинэ Гвиней (ялгаварлан гадуурхалт хариуцсан)

<sup>88</sup> Испани, Португали, Швед, Грек, Кипр, Андорра, Финланд, Норвеги зэрэг улсыг нэрлэж болно.

<sup>89</sup> Хүүхдийн төлөө омбудсманы сүлжээ: <http://crin.org/> енос; Шинэ Зеландын Хүүхдийн Комиссар: [www.occ.org.nz](http://www.occ.org.nz)

<sup>86</sup> Linda C. Reif, "Transplantation and Adaptation: The Evolution of the Human Rights Ombudsman," Boston College Third World Law Journal 31 (2011) z69(in press); Kucsko-Stadlmayer, European Ombudsman-Institutions, 491-2.

эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх тодорхой асуудал хариуцсан байгууллага бий болгохыг уриалсан.

Тодорхой асуудал хариуцсан байгууллагуудын хараат бус байдал, эрх мэдэл нь илэрхий ялгаатай. Нэг улс дахь нийтлэг болон тодорхой асуудал хариуцсан ХЭҮБ-уудын хоорондын харилцаа холбоо маш ээдрээтэй байх боломжтой. Эдгээр байгууллагатай холбоотой хууль тогтоомжоор сайтар зохицуулаагүй, хуулбарласан шинжтэй, эсвэл үр нөлөөг тооцоогүй тохиолдолд харьяаллын асуудал давхцах зэрэг нөхцөл үүсдэг. Нийтлэг ХЭҮБ-ын хувьд өөр этгээдэд өөрийн харьяалах асуудлыг дамжуулах шаардлага тулгарна. Гэхдээ олон үндэсний байгууллагатай улсын зүгээс нийтлэг ХЭҮБ-ыг тодорхой асуудал хариуцсан болгосон жишээ (Өмнөд Африкийн Хүний эрхийн Комиссыг Жендэрийн тэгш эрхийн комисс болгох) бий. Зарим судлаачид энэ үйлдлийг нийтлэг ХЭҮБ-ын бүрэн дүүрэн эрх мэдлээ хэрэгжүүлж чадахгүй гэж үзсэн ба тодорхой асуудал хариуцсан ХЭҮБ зөвхөн жендэрийн асуудалд анхаарал хандуулж, хооронд нь эрэмбэлэхэд маш хэцүү хүний эрхийн асуудлуудад “хөл алдахаас” илүүтэйгээр жендэрийн тэгш эрхтэй холбоотой нөхцөл байдлыг чухалчилдаг онцлогтой гэжээ.

Гэсэн хэдий ч тодорхой асуудал хариуцсан ХЭҮБ-ууд маш эмзэг билээ. ОУЗХ-ны зүгээс нэг улс дахь тал бүрийн үйл ажиллагаа явуулдаг нэг ХЭҮБ-ыг дэмждэг. Эрх мэдлийн цөөнх буюу нийгмээс гадуурхагдсан хүмүүст анхаарч ажилладаг, тодорхой асуудал хариуцсан байгууллагын чиглэл нь хүн амын дийлэнх хэсэгт хүрэхгүй байх боломжтой.

Үүнтэй уялдан нөөц чадамж багатай, эсвэл хязгаарлагдмал эрх мэдэлтэй байхыг үгүйсгэхгүй. Тодорхой асуудал хариуцсан ХЭҮБ-ууд нөлөөнд автахуйц учир өөрийн хараат бус байдлыг хялбар алдах, өргөн хүрээг хамарч ажилладаг ХЭҮБ-ын үйл ажиллагааг дагах нөхцөл байдал үүсч болно. Мөн олон ХЭҮБ-ууд бүхий улсуудын зүгээс төсвийн зардлыг танах, давхацсан бүрэн эрхийг нэг байгууллагад шилжүүлэх байдлаар бусад тодорхой асуудал хариуцсан байгууллагыг татан буулгасан туршлага бий. Жишээлбэл, хэдэн жилийн өмнө Швед Улсад ялгаварлан гадуурхалтын эсрэг тусгайлан үйл ажиллагаа явуулдаг дөрвөн омбудсманыг татан буулгаж, тэдний бүрэн эрх, статусыг Тэгш эрх хариуцсан нэг омбудсманд хариуцуулан хяналт тавих чиг үүргийг олгосон байна. Ирланд Улс өөрийн Засгийн газрын илтгэлдээ Хүүхдийн омбудсман зэрэг институтуудыг нэг Омбудсманы байгууллагад нэгтгэх тухай зөвлөмж гаргажээ. Франц Улсад Хүүхдийн хамгаалагчийг (Defender of Children) татан буулгаж, түүний хамгаалах чиг үүргийг Эрх хамгаалагч (Defender of Rights) гэсэн шинэ институт хариуцах зохицуулалт бүхий хуулийн төслийг 2009 онд болосвруулсан. Цаашилбал, өөрийн гэсэн чиг үүргийг холбогдох албан тушаалтны заавар, чиглэлийн дагуу хэрэгжүүлж байгаа тодорхой асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагааг дэмжихээс илүүтэйгээр зарим улсын засгийн газрын зүгээс хоёр тусдаа хөндлөн шинжтэй хариуцлагыг нэг байгууллагад “тохох” байдал гарсан юм. Жишээлбэл, Канадын Нью Брунсвик мужийн омбудсман нь тус мужийн Хүүхэд, залуусын өмгөөлөгчөөр (Children and

Youth Advocate) томилогдсон билээ<sup>90</sup>.

д. Үндэсний түвшнээс доогуур байгууллага

Холбооны болон төвлөрсөн эрх мэдлийг орон нутгийн нэгжид шилжүүлсэн улсуудын хувьд, хууль тогтоох эрх мэдлийг үндэсний болон үндэсний түвшнээс доогуур хүрээнд буюу муж, аймаг зэрэг нэгжид олгосон байдаг ба энэ шинж нь хүний эрхийн асуудлаар төрийн зүгээс анхаарах түвшин харилцан адилгүй болдог. Зарим холбооны улсад, үндсэн хуулийн эрх зүйн ойлголттой уялдуулан, үндэсний түвшний ХЭҮБ-ууд үндэсний түвшнээс доогуур байгууллагын шийдвэрлэх боломжтой хүний эрхийн асуудлыг харьяалан шийдэх боломжгүй байдаг. Мөн үндэсний түвшнээс доогуур хүрээнд ажилладаг тухайн байгууллага л өөрийн хамаарах асуудлаар хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах боломжтой ажээ.

Тус холбооны болон төвлөрсөн эрх мэдлийг орон нутгийн нэгжид шилжүүлсэн улсууд үндэсний түвшнээс доогуур хүрээг хамарсан, янз бүрийн хэлбэрийн хүний эрхийн байгууллагыг байгуулсан. Жишээлбэл, Канад, Мексик Улсад холбооны болон мужийн/аймгийн хүний эрхийн комисстой, Испани Улс нэг Ард түмний хамгаалагч болон өөртөө засах шинжтэй бүлэг хүмүүсийн нэгдлийн ихэнх нь хүний эрхийн омбудсмантай, Аргентин Улс үндэсний болон мужийн хамгаалагчидтай (defensores) ажээ.

<sup>90</sup> New Brunswick Ombudsman: [www.gnb.ca/0073/index-e.asp](http://www.gnb.ca/0073/index-e.asp), Child and Youth Advocate Act, S.N.B. 2007, c. C-2.7.

Эдгээр үндэсний түвшнээс доогуур хүрээнд үйл ажиллагаа явуулдаг институтуудыг магадлан итгэмжлэх тогтолцооноос шахан гаргах улс төр болон зохион байгуулалттай холбоотой илэрхий шалтгаан бий. Жишээлбэл, олон тооны байгууллагын төлөөллийг оролцуулахад захиргааны, улс төрийн хүндрэлтэй тулгарах, үндэсний хэмжээний байгууллагыг байгуулах буюу түүнийг бэхжүүлэхээс төр зайлсхийж өөрийн төлөөллөөс бүрдсэн этгээдийг томилох, тухайн улсын олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн төрийн үүргийг биелүүлэхээс татгалзах зэргийг дурдаж болно. Мөн үндэсний түвшинд ажилладаг ХЭҮБ-тай харьцуулбал маш хязгаарлагдмал бүрэн эрхийг олгож, тодруулбал үндсэн хуулийн шүүхэд хандах, олон улсын гэрээг соёрхон батлах талаар нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулах боломжгүй байдаг. Холбооны улсын хувьд тухайн үндэсний түвшний ХЭҮБ нь хүний эрхийн бүхий л асуудлыг харьяалах, төрийн бүх шатанд чиглэн ажиллах боломжгүй тохиолдолд уг институтуудыг татан оролцуулдаг онцлогтой. Ялангуяа тухайн улсад олон улсын хүний эрхийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, хүний эрхийг хамгаалах нь маш учир дутагдалтай үед хүний эрхийн тодорхой асуудлыг эсвэл салбарыг хамардаг ч нийгэмд тэр бүр үр нөлөөтэй байж чаддаггүй.

Иймээс ХЭҮБ-ыг ойлгомжтой тодорхойлох нь ХЭҮБ-ын бүтцийн загварт шаардлагатай чухал бүрэлдэхүүн хэсгийг тогтоох, үр нөлөөтэй ХЭҮБ болох хүчин зүйлсийг таньж мэдэхэд дөхөмтэй. Олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс

дэлхийн өнцөг булан бүрт ХЭҮБ-уудыг харилцан адилгүй тодорхойлсон талаар өмнө дурдсан.

Өргөн дэлгэр тархсан ойлголт бол үндэсний түвшний хүний эрхийн комисс нь ХЭҮБ мөн гэсэн тайлбар ажээ. Мөн үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулдаг хүний эрхийн омбудсмануудыг ч ХЭҮБ-уудад тооцож байна. Үүнээс харахад ХЭҮБ-ын ойлголт дахин анхаарлын төвд оржээ. Тодруулбал, ОУЗХ-ны магадлан итгэмжлэх үйл явц Парисын Зарчмуудад тулгуурлан, олон тооны үндэсний комисс, хүний эрхийн омбудсмануудад А статус олгосны зэрэгцээ НҮБ-ын хүний эрхийн тогтолцоо болон бүс нутгийн олон улсын байгууллага, институтын бүрэлдэхүүнээс хамааралтай болжээ. Гэхдээ ХЭҮБ-ыг тодорхойлоход чиглэсэн зааг ялгаа нь сонгодог омбудсманы институтууд, тодорхой асуудал хариуцсан, үндэсний түвшнээс доогуур хүрээнд ажилладаг хүний эрхийн байгууллагыг үгүйсгэн, “хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих бусад байгууллага” гэсэн нэр томъёогоор илэрхийлсэн байна.

Үүнээс үл шалтгаалан НҮБ-ын тогтолцоонд ХЭҮБ-ыг тодорхойлох өөр өөр хандлага байсаар байна. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо Хүүхдийн эрхийн тухай конвенцийн дагуу хүлээсэн үүргээ төрийн зүгээс биелүүлэхдээ хүүхдийн төлөө, тодорхой асуудал хариуцсан ХЭҮБ-уудыг байгуулах, тэднийг бэхжүүлэх явдлыг хөхиүлэн дэмжиж, НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас сонгодог омбудсманыг ХЭҮБ гэж ангилсан билээ. Мөн Европын бүс нутагт Парисын Зарчмууд болон ОУЗХ-ны Ерөнхий дүгнэлтийг чанд баримтлалгүй, Хүний эрхийн Үндэсний бүтэц буюу

ХЭҮБү гэсэн өргөн ойлголтыг бий болгон, түүний дагуу үндэсний, үндэсний түвшнээс доогуур хүний эрхийн омбудсман, сонгодог омбудсман, комисс, тодорхой асуудал хариуцсан институтуудыг багтаасан болно.

Олон улсын байгууллагын зүгээс ХЭҮБ-уудын талаар янз бүрийн тодорхойлолт, ангилал ашиглаж байгаа нь улс төрийн болон прагматик шинжтэй олон шалтгаанаас үүдэлтэй. Эдгээр талуудын зүгээс ХЭҮБ-ууд болон гэрээний оролцогч улсуудтай харилцахдаа хэлбэрийн төдий шинжтэй, оролцох, хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байх нөхцөлийг анхаардаг. Хэлбэрийн төдий сахин хамгаалах чиг үүрэг нь олон улсын байгууллагын хүний эрхийн механизмд өөрийн төлөөллийг оруулах, дуу хоолойгоо гаргах (бичгэн болон аман хэлбэр гомдол гаргах) боломжтой ХЭҮБ-уудын тоог хязгаарлахад ашиглаж, төрийн үйл ажиллагаанд хяналт тавихдаа олон улсын байгууллагуудтай хамтрах боломжгүй, тухайн байгууллагын загварыг боловсруулах, үр нөлөөт байдлыг дээшлүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдалд оруулдаг. НҮБ-ын ХЭДКГ, ОУЗХ-ны зүгээс хүний эрхийг хамгаалах талаар маш өөр хандлага бүхий улсуудтай ажиллаж байна. Үүнтэй уялдан ХЭҮБ-ыг нарийвчилсан тодорхойлолтыг хүний эрхийг дэмжих хүсэлгүй улсын зүгээс ашиглан, төрөөс байгуулсан хүний эрхийн институтуудын үйл ажиллагааг дордуулах, тухайн байгууллагын үр нөлөөт байдлыг дээшлүүлэх хүчин зүйлсэд шууд нөлөөлөх боломжтой оролцох, чөлөөтэй нэвтрэх боломжийг шууд хязгаарладаг туршлага бий. Гэсэн хэдий ч Европын бүс нутагт өөрийн омбудсманы институтуудын урт

хугацааны туршлагад тулгуурлан, тодорхой асуудал хариуцсан байгууллагыг дэмжих замаар хамгаалах чиг үүргийн үр нөлөөг нэмэгдүүлж, бүс нутгийн хүчтэй хүний эрхийн механизмд тухайн улсын дотоодод ажиллах төрөл бүрийн хүний эрхийн институтуудыг хүлээн зөвшөөрч ажиллах боломжтой.

Хэдийгээр НҮБ, бусад олон улсын байгууллагын зүгээс ХЭҮБ-уудыг ойлгох, тодорхойлох янз бүрийн хандлага байгаа ч ихэнх байр суурь нь гагцхүү үндэсний түвшний хүний эрхийн комисс, эсвэл хүний эрхийн омбудсманы институтуудад ач холбогдол өгдөг ОУЗХ-ны магадлан итгэмжлэх тогтолцоотой уялдаж байна. Сүүлийн үед НҮБ-ын хүний эрхийн тогтолцоо, бүс нутгийн ихэнх байгууллагын зүгээс ОУЗХ-ны магадлан итгэмжлэх чансаанд найдах нь нэмэгдсэн. Үүний зэрэгцээ нийтлэг байдлаар хүний эрхийн омбудсманы институтуудыг ХЭҮБ-уудад тооцож байгаа нь дэлхий дахинд сүүлийн хорин жилийн хугацаанд маш хурдтайгаар үндэсний түвшний, нийлмэл шинжтэй байгууллагууд гарч ирсэн өөрчлөлттэй нягт холбоотой. Зарим улсын зүгээс ХЭҮБ-уудыг чадавхгүй, үр нөлөөгүй, хэлбэрийн шинжтэй болгох (зүйрлэвэл “шүдгүй арслан” мэт) зорилгоор ХЭҮБ-

ын нарийн чанд тодорхойлолтыг ашиглах сөрөг хандлагатай ч НҮБ болон Европын улсуудад ХЭҮБ-ыг илүү чөлөөт байдлаар тодорхойлж байна.

Хүний эрхийн судлаачийн зүгээс ХЭҮБ-ыг тодорхойлох харилцан адилгүй хандлагуудын талаар мэдэж байхаас гадна шаардлагатай тохиолдолд эдгээр зааг ялгаанд баригдахгүй байх нөхцөл байдал үүсч байна. Хүний эрхтэй холбоотой олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээг нийцүүлэх, хэрэгжүүлэх, хүлээсэн үүргээ төрийн зүгээс хэрхэн биелүүлж байгааг тогтоохын тулд тухайн улсын нутагт дэвсгэрт хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг гүйцэтгэж байгаа, хөндлөн хариуцлага хүлээсэн бүхий л байгууллагыг (комисс, хүний эрхийн эсвэл сонгодог омбудсман, тодорхой асуудал хариуцсан институтууд, үндэсний түвшнээс доогуур хүрээнд үйл ажиллагаа явуулдаг институтууд) нягтлан тодруулах шаардлагатай.

Хавсралт. Магадлан итгэмжилсэн статус (2012 оны 5 сарын байдлаар)

Статус	ХЭҮБ-ын тоо	Эзлэх хувь
A	69	70 хувь
B	22	20 хувь
C	10 <sup>91</sup>	10 хувь

<sup>91</sup> Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилготой үндэсний байгууллагуудын Олон улсын зохицуулах хороо Үндэсний байгууллагуудын статус [http://nhri.ohchr.org/EN/Documents/Chart%20of%20the%20Status%20of%20NIs%20\(30%20May%202012\).pdf](http://nhri.ohchr.org/EN/Documents/Chart%20of%20the%20Status%20of%20NIs%20(30%20May%202012).pdf)

## БАЙНГЫН ХҮЧИРХИЙЛЭЛ, ДАРАМТЫН УЛМААС ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХ ЯВДАЛ БА ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА



**Н.АРВИНТАРИА**  
Хүчирхийллийн эсрэг  
үндэсний төвийн хуульч,  
өмгөөлөгч

Хүний аюулгүй байдлыг хангах явдал нийгмийн хөгжлийн гол хүчин зүйл бөгөөд хүн эрх чөлөөтэй, айх аюулгүй байснаар л түүний бие даан амьдрах, сэтгэх, хөгжих боломж нээгддэг.

Гэр бүлийн хүрээнд хүчирхийлэл, дарамт үйлдэх явдал нь бусдын аюулгүй орчинд амьдрах эрхийн эсрэг ноцтой зөрчил юм.

Гэр бүлийн хүчирхийлэл нь бусад төрлийн гэмт хэргүүдээс ялгагдах өвөрмөц онцлогтой. Тухайлбал, ойр дотны харилцаатай хүмүүсийн хооронд, нуугдмал, далд үйлдэгдэж, байнга давтагдан хэн нэгнийхээ амь насыг хөнөөх хүртлээ даамжирч байдаг. Сүүлийн 2 жил хагасын хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 37 хүн ойр дотныхныхоо гарт амь үрэгдэж, 4 хүн амиа хорлосон байна<sup>92</sup>.

<sup>92</sup> ЦЕГ-ын статистик мэдээ -2010, 2011, 2012 оны эхний 7 сар

Үүний нөгөө талд байнгын хүчирхийлэл, дарамтад байгаа хохирогчид болон эрсдэлд байгаа бүлгийн хүмүүс гэр бүлийн хүчирхийлэлд хариу үйлдэл үзүүлэхдээ гэмт үйлдлийг сонгож байгаа тохиолдлууд өссөөр байгаа юм.

2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 381 эмэгтэй хоригдож байгаагаас 62 нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн “Хүнийг санаатай алах” гэмт хэрэгтээ ял эдэлж байна<sup>93</sup>.

<sup>93</sup> Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүн амины гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгэгдсэн эмэгтэйчүүдийн хувийн хэрэгт хийсэн дүн шинжилгээ ХЭҮТ., 2012 он

Гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдийн 34% нь 5-10 жил; 28% нь 10-аас дээш жил гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан бол 40% нь байнгын зодуур, 26% нь хардалт, бусад нь бэлгийн болон сэтгэл санааны дарамтад өртөж байжээ.

Нийт ялтны 22.3% нь тухайн гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө аливаа дарамт, хүчирхийлэлд өртөж буй талаараа хуулийн байгууллагад мэдэгдсэн бол 9.7% нь гэр бүл цуцлуулах саналаа шүүхэд гаргаж байсан гэжээ<sup>94</sup>.

Эдгээр эмэгтэйчүүдийн 52% хувь нь 10-15 жилийн хорих ялыг “чанга” дэглэмтэй хорих ангид эдлэхээр шийтгэгдсэн байна.

Манай Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны практикт эд мөрийн баримт, мөр г.м нүдэнд харагдах биет зүйлүүдэд шинжилгээ хийгддэг хирнээ сэтгэл зүйн байдалд үнэлгээ дүгнэлт өгдөггүй. Зөвхөн хэрэг хариуцах чадвартай эсэхийг л шинжилдэг.

Хүчирхийлэл дарамтанд олон жил өртсөний улмаас эцэст нь хэрэгт холбогдогч болон хувирсан тэрхүү жинхэнэ хохирогч өөрөө аюулыг хэрхэн дүгнэж байна вэ гэдэгт онцгой анхаарал хандуулах ёстой байтал хайхардаггүй.

Шүүхүүд энэ төрлийн хэргийг шийдвэрлэхдээ гэмт хэрэг үйлдэгдэхэд олон жилийн хүчирхийлэл, дарамт нөлөөлсөн эсэх, гэмтээж бэртээх, амь насыг нь хөнөөх заналхийлэл байнга давтагдаж, амиа алдахаас аргагүй нөхцөл байдалд удаа дараа очиж байсан эсэх гэх мэт

<sup>94</sup> Хүн амины гэмт хэрэгт ял шийтгүүлж, ШШГЕГ-ын харьяа Эмэгтэйчүүдийн хорих 0407 дугаар ангид ял эдэлж буй ялтнуудын үйлдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд хийсэн судалгаа, ХЭҮК., 2011 он

субъектив талын шинжүүдийг харгалзан үзэлгүй хэргийн үйлдэл, хор уршигт хэт хөтлөгдөн, хэрэгт холбогдогчийн тухайн үйлдэлдээ хандсан хүсэл зориг болон айдсыг харгалзан үзэхгүй байна.

Олон улсын практикт энэ төрлийн хэргүүдийг хянан шийдвэрлэхдээ “хүчирхийлэлд өртдөг эмэгтэйчүүдийн нийтлэг чанар” хэмээх сэтгэл зүйн онолын ухагдахууныг харгалзан үздэг.

Байнгын хүчирхийлэл, дарамтанд байсан тэрхүү хохирогчийг сэтгэл мэдрэлийн хувьд эрүүл мөн эсэх дээр нь анхаарал төвлөрөхгүй, тэр хохирогч юуг туулсан, хүчирхийлэл үйлдэгч юу хийснийг олж харахыг хичээх нь хүчирхийллийн үр дагавар түүнд хэрхэн туссан дүр зургийг гаргаж ирэхэд ач холбогдолтой хэмээн үздэг байна.

Дээрх онол ёсоор, санаатайгаар хүний амь нас хөнөөсөн хэргийн тухайд гэр бүлийн хүчирхийлэлд өртөгч нь өөрийн болон гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдалд аюул занал бодитойгоор заналхийлж байгааг ойлгон, хүчирхийллийг даван туулах өөрийн гэсэн төлөвлөгөө хийж шийдвэр гаргадаг гэж үздэг.

Тэдний хүчирхийллээс гарах гарцыг хайж буй арга барил нь ерөнхийдөө нийтлэг байдаг бөгөөд ихэнх тохиолдолд үр дүнд хүрдэггүй мухардалд ордог. Тэдний энэхүү оролдлого нь давшилт - хамгаалалт - давшилт - хамгаалалт гэсэн хэмнэлээр буюу ороомог байдлаар явагддагийг сэтгэл зүйчид тогтоожээ.

Тэдний энэхүү давшилт нь хүчирхийлэл үйлдэгчидэд түүний хүчирхийллийг эсэргүүцэх, хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ



үзүүлэхийн тулд болон түүний үйлдлийг зогсоохын тулд хийгддэг.

Ихэнх тохиолдолд хүчирхийлэлд өртөгчийн зүгээс хүчирхийлэл үйлдэгчид чиглэж буй үйлдэл нь сэтгэл зүйн хувьд өрсөх болон хамгаалах дохиолол дээр үндэслэгдсэн байдгийг анхаарах нь зүйтэй. “Хэн ч намайг хамгаалж чадахгүй юм байна, зөвхөн өөртөө л найдах хэрэгтэй юм байна” гэсэн бодол хүчирхийллийг зогсоох гэсэн бүтэлгүй оролдлого бүрийн дараа хүчирхийлэлд өртөгчийн тархинд батжин үлддэг байна.

Энэхүү өрсөх болон хамгаалах механизм нь олон жилийн дарамтын улмаас сэтгэл зүйн хувьд ноёлох голомт болон үүсдэг байна. Хүчирхийлэл үйлдэгч нь өөрийн ойрын хүнийг хянах, эсхүл зөрчлийг шийдвэрлэхийн тулд янз бүрийн хүчирхийллийн арга ашигладаг ба тэрээр эдгээр зан байдлынхаа аль нь илүү нөлөөтэй гэдгийг, тодорхой сүрдүүлэгт

хүчирхийлэлд өртөгчийг итгэнэ гэдгийг мэддэг байна.

Харин хохирогчийн хувьд сүрдүүлэг болон урьдах хүчирхийллийн тухай дурсамж маш бодит байдаг. Хүчирхийлэлд өртөгч нь түүний сүрдүүлэг ба аюул заналхийллийг биелэгдэх магадлалтай гэдгийг хүчирхийлэлтэй харилцааныхаа туршлагаас сайн мэддэг болдог. Тухайлбал “хүзүүг чинь хугалчихна шүү, алчихна шүү” хэмээн удаа дараа заналхийлж, багалзуурдан боомилох, эсхүл хүнд гэмтэл учруулах зэргээр амьдрал, үхлийн зааг хичнээн ойрхон байдгийг мэдрүүлсэн байдаг жишээтэй” хэмээн тайлбарлажээ.

Байнгын хүчирхийлэл, дарамтанд байсан хохирогчдын сэтгэл зүйн эдгээр онцлогийг харгалзан, гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдал буюу “аргагүй хамгаалалт” гэж үзэж, гэмт хэрэгт тооцохгүй байхаар хуульчлах шаардлагатай байна.

## ХҮНИЙ ЭРХ БА АЗИЙН ҮНЭТ ЗҮЙЛС

Амартя Сен

1776 онд эх оронд нь Тусгаар тогтнолын тунхаглалыг баталж байх үест Томас Пейн “Нийтлэг Мэдэрэмж” зохиолдоо Ази тив эрх чөлөөг удтал таягдан хаясан хэмээн шүүмжилж байв. Ийн харуусахдаа Пейн Ази тивийг дэлхийн бусад хэсэгтэй хамтад нь харж байжээ. (Түүний найдаж байснаар Америк өөр байх байв). “Эрх чөлөөг дэлхийн өнцөг булан бүрт хяхан хавчиж ирсэн. Ази, Африк хоёр бол бүр эртнээс үгүйсгэсэн. Европ тив үүнд харилхуу хандаж, Англи бол энэ санааг үлдэн хөөх гэж мэрийсэн.” Пейний хувьд улс төрийн эрх чөлөө, ардчилал бол хаана ч байх ёстой үнэт зүйл боловч түүнийг бараг хаа сайгүй зөрчиж байжээ.

Дэлхийн өөр өөр өнцөгт магадгүй Пейний цаг үеийнх шиг бүхнийг хамарсан хэмжээнд биш боловч эрх чөлөө, ардчилалд харшилсан зүйлс болсоор л байна. Гэхдээ ялгаа бий. Шинэ төрлийн маргаантай асуудлууд гарч ирж эдгээр эрх чөлөөний нийтлэг ач холбогдлыг үгүйсгэх болсон байна. Эдгээр сөрөг хандлагуудын хамгийн тод илэрсэн нь Азийн үнэт зүйлс эрх чөлөөг өрнөдөд үздэг шиг чухалчлан авч үздэггүй гэсэн үзэл юм. Ингэж маргавал үнэт зүйлсийн тогтолцооны ялгаагаараа Ази нь өөрийн гүн ухааны, түүхийн эрхэм зүйлсийн тогтоолцоогоо үнэнчээр дагах ёстой болж байна.

Ази болон Өрнө дахины соёлын ялгаа, үнэт зүйлийн ялгааг 1993 оны Венийн Хүний эрхийн Дэлхийн Бага

хуралд оролцсон хэд хэдэн албан ёсны төлөөлөгчид онцлон авч үзсэн юм. Сингапурын гадаад хэргийн сайд “хүний эрхийг бүхнээс дээрд үздэгийг нийтээр хүлээн зөвшөөрөх, нийтээр дагах байдал нь олон талт ялгаатай байдлыг үгүйсгэх буюу халхлах гэсэн утгаар ашиглавал хор хөнөөлтэй байж болно,” хэмээн анхааруулсан юм. Хятадын төлөөлөгч бүс нутгийн ялгааг онцолж, тунхаглалаар батлах зөвлөмжийн баримт бичигт бүс нутгийн ялгаатай байдлуудыг тусгахад тэргүүлэх үүрэгтэй оролцов. Хятадын гадаад хэргийн сайд “Хувь хүн улс орныхоо эрх ашгийг өөрийнхөөсөө дээгүүрт тавих ёстой” гэсэн санааг Хятадад ч, өөр газар ч хэрэглэж болох юм хэмээн байр сууриа илэрхийлэв.

Би энд Азийн үнэт зүйлс эрх чөлөөний үнэлэмж багатай, дэг журам, сахилга батыг илүүтэй анхаардаг, тиймээс улс төрийн болон иргэний эрх чөлөөний агуулгаараа хүний эрхийн асуудал нь Азид, Өрнө зүгийнхийг бодвол уялдаа муутай, тохиромжгүй гэсэн үзэл санааг шинжлээ гэж бодлоо. Азийн үнэт зүйлийн онцлог мөн чанар гэдэг дээр тулгуурлан Ази тив дэх авторитар дэглэмийг хамгаалдаг түүхэн үүднээс задлан шинжилгээ хийх шаардлага гарч байгаа бөгөөд энэ талаар одоо өгүүлэх болно. Гэхдээ сүүлийн үед Ази дахь авторитар засаглалыг зөвтгөх өөр үзэл санаа анхаарал татах болов. Энэ нь авторитар засаглалыг эдийн засгийн хөгжлийн үүднээс өмгөөлж байгаа юм.

Сингапурын ерөнхий сайд асан, “Азийн үнэт зүйлс”-ийн үзлийн гол төлөөлөгч Ли Куан Ю эдийн засгийн амжилтад хүргэхэд захиргаадгалтын арга барил үр дүнтэй гэдгээр бамбай хийж ирсэн юм.

Авторитар дэглэм үнэхээр ашиг тустай байна гэж үү? Мэдээж зарим харьцангуй захиргаадгалтын хэлбэртэй улсууд (Өмнөд Солонгос, Ли Куан Югийн үед Сингапур, Шинэчлэлийн дараахь үеийн Хятад) захиргаадгалт багатай улс орнуудтай (Энэтхэг, Коста Рика, Ямаик зэрэг) харьцуулахад эдийн засгийн өсөлт илүүтэй байгаа нь үнэн. Гэхдээ Лигийн онол таамаглал нь өргөн хүрээтэй тоо баримт дээр тулгуурласан статистик үндэслэлтэй гэхээсээ илүү онцлон сонгосон, хязгаарлагдмал мэдээлэл дээр үндэслэж байна. Бид Хятадын, эсвэл Өмнөд Солонгосын эдийн засгийн хурдацтай өсөлтийг авторитар төр эдийн засгийг тэтгэхдээ илүү гэдгийн баталгаа болгон авч болохгүй юм. Тэр тусмаа Африк дахь эдийн засаг нь хамгийн эрчимтэй өсч буй орон болох Ботсван Улс (дэлхийд эдийн засгийн өсөлтөөр хамгийн тэргүүлж байгаа орнуудын нэг) тэрхүү золгүй тивийн ардчиллын баян бүрд болохынх нь хувьд авч үзвэл харин ч эсрэг дүгнэлт хийж болохоор байна. Нөхцөл байдлыг нарийн авч үзэхээс ихээхэн зүйл хамаарна.

Авторитар засаглал, улс төрийн болон иргэний эрхийг дарж байснаар эдийн засгийн хөгжлийг дэмжихэд ашиг тустай гэдгийг батлах нотолгоо тун бага байна. Статистикийн зураглал бүр ч ярвигтай гарч байгаа юм. Системчилсэн эмпирик судалгааны үр дүн бол улс төрийн эрхийн хэрэгжилт, эдийн засгийн хөгжлийн өгөөжтэй зөрчилдөнө гэсэн ойлголтод бодит нотолгоо өгөхгүй байна. Энэхүү уялдаа холбоо нь олон нөхцөл байдлаас

хамаарах төлөвтэй, зарим статистик судалгаа бага зэрэг сөрөг хамаарлыг илтгэж байхад заримаас нь нилээн нааштай хамаарал харагдаж байна. Харьцуулж үзвэл аль ч чиглэлд эрх чөлөө, хөгжил дэвшил хоёр хоорондоо огт хамаагүй гэдэг онол, таамаглалыг үгүйсгэхэд хэцүү юм. Улс төрийн эрх чөлөө өөрийнхөөрөө чухал учраас энэ тохиолдолд асуудал шийдэлгүй үлдэж байна.

Шинжилгээ судалгааны арга зүйн илүү суурь шинжтэй асуудал бас байна. Статистик уялдаа холбоог нь харахаасаа илүү, эдийн засгийн өсөлт, хөгжилд хүргэж байгаа хүчин зүйл болсон үйл явцад анхаарал хандуулах хэрэгтэй юм. Зүүн Азийн эдийн засгийн амжилтад хөтөлсөн эдийн засгийн бодлого, орчин нөхцлийг одоо шалтгаан үндэслэлтэйгээр ойлгох боломжтой болжээ. Эмпирик судалгаанууд ач холбогдлын хувьд харилцан адилгүй байгаа бол нилээн өргөн хүрээнд үр ашигтай хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн бодлого, үзэл баримтлалуудыг дурдаж болно. Тэдгээрийн дотор нээлттэй өрсөлдөөн, олон улсын зах зээлд гарах, бичиг үсэг тайлагдалт болон боловсролын өндөр түвшин, газрын амжилттай шинэчлэл, хөрөнгө оруулалтыг төрөөс урамшуулан дэмжих, экспорт, болон аж үйлдвэржилт зэрэг орж байна. Эдгээр бодлогын аль нэг нь ардчилалтай зохицохгүй гэхээр, мөн эдгээрийн аль нэгийг Өмнөд Солонгос, Сингапур, Хятад шиг захиргаадгалтаар тогтворжуулах шаардлагатай гэж ойлгохоор нотолгоо огт байхгүй. Энэтхэгийн сүүлийн үеийн туршлагаас эдийн засгийг улам хурдацтай өсгөхөд улс төрийн чанд хатуу тогтолцоо гэхээсээ илүү эдийн засгийн таатай уур амьсгалыг бүрдүүлэх хэрэгтэй болох нь харагдаж байгаа юм.

Энэ асуудлын хүрээнд нэг талаасаа улс төрийн болон иргэний эрхийн хоорондын холбоог харах, нөгөө талаасаа учирч болох томоохон гамшгуудаас сэрэмжлэх нь чухал юм. Улс төрийн болон иргэний эрх нь хүмүүст үндсэн хэрэгцээндээ анхаарал хандуулах, төрөөс зохистой арга хэмжээ авахыг шаардах боломж олгодог. Ноцтой бэрхшээл, зовлон тохиолдоход засгийн газар өөрт ирэх шахалт, шаардлагаас хамаарч хариу арга хэмжээ авдаг бөгөөд үүн дээр л улс төрийн (сонгох, шүүмжлэх, эсэргүүцэх, гэх мэт) эрх хэрэгжих нь ямар ач холбогдолтой болохын ялгаа гарч ирнэ. Судан, Этиоп, Сомали, бусад дарангуйлагч дэглэмтэй улсуудад, эсвэл 1930-аад онд ЗХУ-д, 1958-1961 онд Хятадад болсон (Их үсрэлтийн бодлого бүтэлгүйтэхэд 23-30 сая хүн үхсэн), одоо Хойд Солонгост болж байгаа өлсгөлөнгүүд дээрхийг баталж байгаа юм (Ардчилсан засаглалтай Британий бүрэлдэхүүнд байсан Ирландад 1940-өөд онд өлсгөлөн гарсан нь үнэн, гэхдээ Британий улс төрийн эрхшээл Ирландад маш хүчтэй байсан буюу хэрэг дээрээ колоний дэглэм байсан бөгөөд Ирландад нийгмийн ялгаа тэнгэр газар шиг, Спенсерийн найрсаг бусаар Ирландчуудыг тодорхойлсноор 16-р зууныхаараа хэт хуучинсаг байсан).

Энэ холбоо өлсгөлөнгөөс урьдчилан сэргийлэх тохиолдолд туйлын тодорхой байгаагийн зэрэгцээ улс төрийн, иргэний эрх нь эдийн засаг, нийгмийн шинжтэй гамшгаас урьдчилан сэргийлэхэд эерэг үүрэг гүйцэтгэнэ. Нөхцөл байдал таатай, бүх зүйл хэвийн байдлаар явж байгаа үед ардчиллын энэхүү шалтгаант чанарыг шууд хайхралгүй орхихгүй байх. Харин ямар нэг шалтгаанаар асуудал овоороод эхлэхээр тодорхой болно. Тэр үед ардчилсан засаглалаас үүдсэн улс төрийн

үр ашиг бодит үнэ цэнээ олдог. Зөвхөн эдийн засгийн ашгийг (зах зээлийн эдийн засгаас олж болох) хичээгээд, улс төрийн үр ашгийг (ардчилсан тогтолцооноос олж болох) орхих нь туйлын тэнцвэргүй эмх журмыг сонгосон дэглэм болно.

## II

Одоо Азийн үнэт зүйлсийн мөн чанар, утга учрын талаар ярилцъя. Үүнийг олж тодорхойлно гэдэг олон шалтгааны улмаас тийм ч хялбар хэрэг биш. Ази тивийн өөрийнх нь хэмжээ л гэхэд хүндрэл үүсгэж байгаа юм. Азид дэлхийн хүн амын 60% орчим нь аж төрж байна. Асар олон ялгаа бүхий өнгө төрхтэй ийм том бүс нутгийн үнэт зүйлээр бид алийг оноож ойлгох вэ? Эн тэргүүнд Азийг дэлхийн бусад хэсгийн хүн амаас ялгаатай бүлэг хүн болгочихоор энэ олон төрөл бүхий их хэмжээний хүн амын аль ч хэсэгт таарч тохирдог тийм бодитой үнэт зүйл байхгүй гэдгийг хэлэх хэрэгтэй. Азийг дан ганц нэгж болгож харах сонирхол бол гарцаа байхгүй Евро төвийн ойлголтыг харуулж байгаа юм. Мэдээж одоогийн Ази тив гэсэн утгаар удаан хугацааны турш голлон хэрэглэж ирсэн “Дорно” гэдэг нэр томъёо нь наран мандах зүгийг төсөөлж өгсөн Европын байр зүйн ойлголтыг илэрхийлнэ.

Бодит амьдрал дээр “Азийн үнэт зүйл”-ийг өмгөөлөгчид онцгойлон нэрлээд байгаа бүс нутгаа их төлөв зүүн Азийг гэж харах төлөвтэй байдаг. Өрнө хийгээд Азийн хоорондох ялгааг дүгнэхдээ Тайландаас зүүн тийш газар нутаг дээр тулгуурладаг боловч Азийн бусад хэсэг нь харин ч “хоорондоо адил төстэй” гэсэн санаа нь илүү түлхүү утгатай байж болох юм. Ли Куан Ю “Өрнөдийн болон Зүүн Азийн төр нийгмийн тухай ойлголтуудын ялгааг” тодорхойлохдоо

“Би Зүүн Азийнхан гэж онцлохдоо Хятад болон Энэтхэгийн дундах холимог болох Зүүн өмнөд Азиас ялгарах байдлаар Солонгос, Япон, Хятад, Вьетнамыг хэлж байна. Гэхдээ Энэтхэгийн соёл өөрөө мөн л төсөөтэй үнэт зүйлийг чухалчилдаг л даа” хэмээн тайлбарлажээ.

Үнэн хэрэгтээ зүүн Ази нь өөрөө маш олон онцлог ялгаатай байдлыг агуулдагаас гадна Япон, Хятад, Солонгос болон зүүн Азийн бусад хэсгийн хооронд маш олон төрөл ялгаа байдаг. Дотно, гадны олон янзын соёлын нөлөө энэ том нутгийн түүхэнд хүний амьдралд нөлөөлж ирсэн билээ. Эдгээр нөлөө нь одоо ч янз бүрийн хэлбэрээр оршсоор байна. Хьютон Мифлиний Нэвтэрхий толийг харвал 124 сая Япончуудын 112 сая нь Шинто шашинтан, 93 сая нь Буддын шашинтан байна. Зүүн Ази шиг бүс нутагт, тэр бүү хэл Япон, Хятад, Солонгос зэрэг улс орнуудад олон соёл уламжлал давхцан зэрэгцэн оршдог бөгөөд “Азийн үнэт зүйл”-ийг нийтэд хэвшүүлэх (энэ бүс нутаг дахь өөр өөр итгэл бишрэл, үзэл бодол, санаа бодолтой үй олон хүнд хүчээр, ихэнхдээ бүдүүлгээр тааруулдаг) гэсэн оролдлого нь хэт болхи болоод байна. Улс төрийн манлайллын хэв шинж болон Азийн үнэт зүйлийн албан ёсны тодорхойлолтыг өгдөг нийтээр дагах хандлага маш хүчтэй байгаа энэ цаг үед Сингапурын 2.8 сая хүнд ч гэсэн маш олон ялгаатай соёлын болон түүхэн уламжлал байдаг.

Тэгсэн хэдий ч Азийн олон уламжлалын ялгаа Азийн соёлд хувь хүний эрх чөлөө, улс төрийн эрхийг эрхэмлэх үнэлэмж байгаа юу үгүй юу гэдэгт баттай хариу өгөхгүй юм. Азид хадгалагдан үлдсэн уламжлалууд нь өөр хоорондоо ялгаатай боловч зарим нийтлэг шинжүүдийг агуулдаг. Жишээ нь Өрнөдийнхтэй харьцуулбал Азид

настангууддаа (тодруулаад өндөр настай эцэг эх) өргөж тэтгэх хандлага илүү байдаг гэж ярьж ирсэн. Энэ ойлголт дээр маргаж болох боловч Азийн олон ялгаатай соёл дунд энэ тэр нийтлэг шинжүүд тааралддаг байсан бол өвөрмөц онцлог гэж байхгүй байх сан. Ялгаатай байна гэдэг бол бүх зүйл дээр авч хэрэглэх шаардлагатай ойлголт биш. Харин эндээс асуух асуулт бол Азийн улс орнуудад эрх, эрх чөлөөнд эргэлзээтэй хандаж, дэг журам, сахилга батыг түлхүү тавьдаг нийтлэг шинж бий юу гэсэн асуулт байна. Азийн онцлогийг сурталчлагчид улс төрийн либерализмыг үгүйсгэдэг боловч Ази дотроо олон ялгаатай соёл уламжлалд хуваагддаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг байна.

Авторитар засаглалыг өмөөрөх үзэл Өрнөдийн тодорхой зарим үзэл санаанаас дэмжлэг авч байна. Америк, Европт шууд биш ч гэсэн улс төрийн эрх чөлөө, ардчилалыг тэргүүнд тавьдаг нь Европын соёлын суурь, эртний хэв шинж, харин Азид бол тэр бүр харагддаггүй зүйл гэж үзэх хандлага бас байна. Жишээ нь Күнзийн сургаальд байгаа дам утгаараа авторитар төрийн үзэл болон Өрнөдийн либерал соёлд гүн үндэслэсэн гэх эрх чөлөө, хараат бус байдлыг хүндэтгэх үзэл хоёрын хооронд эрс ялгаа байгаа гэх аж. Өрнөдийн бус ертөнц дэх хувийн болон улс төрийн эрх чөлөөг хөхиүлэн дэмждэг Өрнөдийнхөн иймэрхүү задлан шинжилгээ Ази болон Африкт Өрнөдийн үнэт зүйлсийг түгээхэд шаардлагатай урьдач нөхцөл гэж үздэг.

Энэ бүхэнд бүгдэд нь орчин цагаас буцаж ухрах бодит хандлага ажиглагддаг. Европын гэгээрэл болон бусад харьцангуй сүүл үеийн хөгжил дэвшлийн үр дүнд нийтэд түгэн тархсан гэх үнэт зүйлс нь мянга гаруй жил оршсон учраас үнэндээ зөвхөн Өрнөдийн өв соёлын нэг хэсэг гэж

үзэх аргагүй юм. “Хэзээ, яаж хувь хүний эрх чөлөөний тухай ойлголт Өрнөдөд гарч ирсэн юм бэ?” гэдэг асуултын хариуд Исаяа Берлин “Би эртний түүхэнд үүнийг томъёолсон гэхээр ямар ч үнэмшилтэй нотолгоо олоогүй” хэмээн тэмдэглэжээ. Ийм үзэл бодлыг Орландо Паттерсон тэргүүтнүүд үгүйсгэж байна. Тэрээр Өрнөдийн, ялангуяа Грек, Ромын болон Загалмайтны соёл дахь хувь хүний эрхийг сонгон өмгөөлөх тохиолдол байсныг илэрхийлэх тодорхой шинжийг онцлон заасан байдаг.

Тодорхой хариулах боломжгүйнэгасуулт бол (бараг асуудаггүй асуулт) бол бусад соёлд адил төстэй элементүүд бий юу гэсэн асуулт юм. Берлиний онол бидний одоо мэдэх хувь хүний эрхийн тухай ойлголтод хамаарах бөгөөд “үүнийг тодорхойлсон томъёолол” байхгүй байгаагийн зэрэгцээ хувь хүний эрх чөлөөний талаар орчин цагийн үзлийг бүрдүүлэх нарийн ойлголтыг бүрдүүлэгч тодорхой хэсгүүд бий гэсэн үзэл байна. Тийм бүрэлдхүүн шинжүүд Грек, Ромын ертөнцөд ч, Еврей, Загалмайтны сургаалийн ертөнцөд ч байдаг. Гэхдээ тэдгээрт байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөхдөө мөнхүү бүрэлдүүлэгч хэсгүүд өөр газарт, тухайлбал Өрнийн бус соёл иргэншилд байгаа юу, үгүй юу гэдгийг мөн шалгаж үзэх шаардлагатай. Бид бүхлээр нь хайхаасаа илүүтэй хэсэгчлэн авч Өрнөд, Ази, дэлхийн бусад хэсэгт хайгуул хийх хэрэгтэй.

Энэ ойлголтыг дэмжихээр хүн бүрт хувийн эрх чөлөө олгох нь зөв нийгэм оршин тогтноход чухал ач холбогдолтой гэдгийг авч үзэх нь зүйтэй. Энэ үзэл санаа хоёр өвөрмөц шинжээс бүтэж байгааг харж болно. Үүнд: (1) хувь хүний эрх чөлөөний үнэ цэнэ: Хувь хүний эрх чөлөө чухал зүйл бөгөөд зөв нийгэмд хамаарах

хэнд ч болов баталгаажсан байх ёстой, (2) Тэгш эрх чөлөө: хүн болгонд хамаатай бөгөөд хувь хүний эрх чөлөө хүн бүрт адилхан баталгаажих ёстой. Аристотель эхний санааг дэмжиж олонтаа бичсэн, гэхдээ үүндээ хоёр дахийг нь дэмжилгүй эмэгтэйчүүд, боолчуудыг хасаж орхисон. Мэдээж ийм хэлбэрийн тэгш байдлын тухай ойлголт бол харьцангуй сүүл үеийнх. Анги, кастаар давхраажсан нийгэмд ч эрх чөлөөг ямбат хэсгийнхэний (Мандаринууд, бярман нар гэх мэт) хувьд зөв нийгмийн талаарх Грек маягийн ойлголтод байх боол биш энгийн хүнд байх эрх чөлөөтэй тун ижил байдлаар үнэлж чаддаг байсан.

Эсвэл өөр нэг хэрэглэж болох онцлог ялгаа нь: хүлцэн тэвчихийн үнэ цэнэ буюу харилцан адилгүй итгэл үнэмшил, үзэл бодол, өөр өөр хүмүүсийн үйлдлийг хүлцэн тэвчих хандлага байх ёстой гэсэн ойлголт болон адил тэгш хүлцэл буюу зарим нэгэнд нь үзүүлж байгаа хүлцэл бүх хүнд адилхан хүртэх ёстой (заримынх нь гаргаж байгаа хүлцэл бусдынх нь хувьд адил тэгш хүлцэл биш байгаагаас бусад тохиолдолд) гэсэн ойлголт хоёрын хоорондын ялгаа. Мөн л дахин онцлоход зарим нэг хүлцэлийн талаарх маргаан нийтлэг хүлцэлийн тухай маргаант асуудлуудгүйгээр эрт үеийн Өрнийн бичвэр, зохиолуудад элбэг тохиолддог. Орчин үеийн ардчилсан, либерал үзэл санаануудын үндэс, язгуурыг бүхэл бүтнээр нь гэхээсээ үндсэн элементүүдийн хувьд олж болох юм.

Иймэрхүү дүн шинжилгээний хүрээнд эдгээр үндсэн элементүүд Өрнийн үзэл бодол, ойлголтуудад байдаг шигээ Азийн ном судруудад байхгүй юу хэмээн асууж болно. Эдгээр бүрэлдэхүүн хэсэг оршин байдаг гэдэг нь эсрэгээрээ эрх чөлөө, хүлцэлийг үгүйсгэсэн үзэл сургааль огт байгаагүй гэсэн үг биш юм шүү. Дэг

журам, сахилга батыг эн тэргүүнд тавих хандлага Өрнийн сонгодог онол сургаальд ч бас бий. Мэдээж миний хувьд Күнзийн сургааль, жишээ нь, Платон юм уу Августиныхаас илүү авторитар шинжтэй гэдэг нь тодорхой юм. Гэхдээ гол асуудал нь эдгээр эрх чөлөөг үгүйсгэгч үзэл хандлага Азийн уламжлалд бий юу гэдэгт биш харин эрх чөлөөг эрхэмлэх үзэл хандлага Азийн уламжлалд огт байхгүй юм уу гэдэгт байгаа юм.

Энд л Азийн үнэт зүйлийн тогтолцоо нилээн өвөрмөц болж ирнэ. Илт тодорхой нэг жишээ нь үзэл сургаалийн хэлбэр болохынхоо хувьд Буддизмын гүйцэтгэж байгаа үүрэг байна. Буддын соёл уламжлалд эрх чөлөөнд ихээхэн ач холбогдол өгдөг бөгөөд Буддын үзэл сургаальтай хамаа холбоо бүхий эрт үеийн Энэтхэгийн сургаалийн уламжлалд хүсэл зориг, чөлөөт сонголтод ихээхэн анхаардаг. Сайн үйл эрх чөлөөтэй үед бүтэх ёстой бөгөөд энэ шинж чанар нь төгс нөгчихүйн үзэл санаанд ч ордог. Буддын үзэл суртал дахь эдгээр элемент нь Күнзийн чухалчилсан сахилга батын ач холбогдлыг үгүйсгэдэггүй боловч Күнзийн сургааль нь Азид, түүний дотор Хятадад байгаа цорын ганц соёл уламжлал гэж үзвэл алдаа болно. Азийн үнэт зүйлийг авторитар үзлээр тайлбарласан орчин үеийн ихэнх тайлбар Күнзийн сургааль дээр төвлөрдөг тул энэ төрөл ялгааг тухайлан онцолж байна.

Азийн үнэт зүйлсийн авторитар төлөөлөгчдийн хувьд жишиг болсон Күнзийн сургаалийг иш татах нь Күнзийн өөрийнх нь сургаальд шударга хандаж байгаа хэрэг биш гэдэгт сүүлийн үед Симон Лейс анхаарал хандуулав. Күнз төрийг сохроор дагахыг сургасан удаагүй.

Зилу түүнээс “Ноёнд хэрхэн зүтгэвэл зохих вэ?” хэмээн асуухад “Хэдий хүндэтгэлгүй хандсан мэт байвч түүнд үнэнийг хэл” хэмээн Күнз хариулжээ. Сингапур, Бээжин дэх шүүмжлэгчид огт өөр байр суурьтай байна. Күнз болгоомж, сэрэмжлэхийн эсрэг байгаагүй ч муу төрийг эсэргүүцэхийг сургахаас татгалзсангүй. “Төрд (сайн) ёс давамгайлж байгаа бол шийдэмгий ярьж, зоригтой үйлд. Төрийн хэрэг хэлтийсэн бол зориглон үйлдэвч зөөлхөн дуугар” гэжээ.

Үнэндээ Күнз Азийн үнэт зүйл хэмээн төсөөлөөд байгаа санааных нь хоёр тулгуур болох гэр бүлдээ үнэнч байх, төрд зүтгэх гэсэн ойлголт нь хоорондоо сүрхий зөрчилтэй байгааг тодорхой заажээ. Ши мужийн захирагч Күнзэд “миний хүмүүсийн дунд гуйвшгүй чигч нэгэн байна. Аав нь хонь хулгайлахад тэр түүнээс татгалзсан юм” гэхэд Күнз хариуд нь “Миний хүмүүсийн дундах чигч хүмүүс огт өөрөөр үйлдмүй. Аав нь хүүгийнхээ, хүү нь аавынхаа үйлийг халхална. Тэдний үйлдэлд байгаа чигч шударга байдал тэр болой” гэсэн байна.

Элиас Канеттийн ажигласнаар Күнзийн сургаалийг ойлгохдоо бид түүний хэлснийг төдийгүй хэлээгүй санааг хүртэл шинжлэх хэрэгтэй ажээ. “Күнзийн нам гүм” гэдэг үгийн нарийн утгыг шууд дэмжээгүй санаа нь дам утгаараа хориотой хэмээн тайлбарлах гэдэг өнөөгийн тайлбарлагчид өөрийнх нь хэлснээс холдуулсан бололтой. Би Күнз ардчилагч байсан гэх буюу эрх чөлөө, олон ургальч үзлийн дууч байсан гэж маргахгүй. Гэхдээ өнөөгийн Азийн үнэт зүйлийг өмгөөлөгчдийн дүрсэлдэг авторитар маягийн Күнзийн тогтчихсон дүр төрхөд эргэлзэх бодит шалтгаан байна.

## III

Одоо Хятадаас Энэтхэгийн хойг руу анхаарлаа хандуулбал бидэнд ойлгомжгүй түгдчих бэрхшээл байхгүй. Эцэс төгсгөлгүй, цуцалтгүй маргах тал дээр Энэтхэгийн зан заншил уламжлалыг давж гарахад бэрх. Энэтхэг бол дэлхий дээр хамгийн том шашны утга зохиолтой төдийгүй эртний түүхт соёл иргэншлүүд дундаа шашингүйн болоод материалист сургаалийн хамгийн олон зохиол бүтээлтэй улс мөн. Ихэнхдээ Илиада, Одиссейтэй харьцуулдаг Энэтхэгийн Махабхарата тууль нь хэрэг дээрээ Илиада, Одиссей зохиолуудыг нийлүүлснээс 7 дахин урт бүтээл юм. Шашин, нийгмийн зүтгэлтэн Раам Мохан Райгийн 19 дүгээр зуунд бичсэн нэгэн алдартай Бенгалийн шүлэгт үхлийн аймшигийг ийн дүүрсэлжээ. “Үхэх өдөр чинь ямар хэцүү байхыг төсөөлөгтүн, бусад нь ярьж байхад чи хариу хэлж чадахгүй” гэжээ.

Цаг нөхцөөж яриа өрнүүлэхийн хувьд энэхүү маргах урлагийн сонирхол нь өөрөө Азийн үнэт зүйлийн тулгуур болох дэг журам, сахилга баттай сөргөлдөж байна. Харин бичсэн зүйлийн агуулгаас эрх чөлөө, хүлцэл, эрх тэгш байдлын тухай олон янзын үзэл санаа харагдах ажээ. Олон талаараа эрх тэгш байдлын үүднээс хүлээцтэй хандахын ач холбогдлыг хамгийн сонирхолтой байдлаар илэрхийлсэн зүйлс Манай тооллын өмнөх 3 дугаар зууны үеийн Ашока хааны бичээсүүдэд байдаг. Ашока Энэтхэгийн бусад хаадынхаас (Моголчуудынхаас, тэр бүү хэл Британичуудын хэвэнд нь орхисон уугуул төрт улсуудыг хасвал Ражуудынхаас) том гүрэнг хаанчилсан юм. Тэрээр одоогийн Ориссагийн нутаг дээр байсан Калингагийн хааны эсрэг тулаанд ялалт байгуулахдаа хийсэн хядлагаасаа

аймшигийг мэдэрснийх дараа нийтийн ёс зүй, гэгээрсэн улс төрийн санаанд анхаарсан байна.

Хаан тэгээд Буддын шашинд оржээ. Тэрээр өрнө, дорны улсуудад элч илгээхдээ бурхны сургаалийг түгээж уг шашныг дэлхийн шашин болоход нөлөө үзүүлсэн бөгөөд зөв амьдрах, сайнаар засаглахын утгыг илэрхийлсэн бичээс бүхий чулуун хөшөөг улс орон даяар босгосон байна. Тэдгээр бичээс олон янзын ялгааг хүлцэн тэвчихийн чухлыг онцгойлон өгүүлсэн утгатай ажээ. Эрагауди дахь нэгэн зарлигт (одоо 12 гэсэн дугаартай) жишээ нь ингэж өгүүлсэн байдаг:

*“..... учрыг ухахгүйгээр өөрийн шашныг шүтэн биширч, шалтгаангүйгээр өрөөлийн шүтээнийг жигших ёсгүй. Дорд үзэхэд ч бас тодорхой шалтгаан байх хэрэгтэй, учир нь өрөөл бусдын шашин ч бас ямар нэг шалтгаанаар итгэл бишрэл хүлээх учиртай.*

*Тийн үйлдсэнээр хүн өөрийн шашныг мандуулж, мөн бусдын шашинд ч сайныг хийнэ. Эсрэгээр үйлдвэл өөрийн шашныг доройтуулж, бусдын шашинд ч бурууг хийнэ. Зөвхөн өөрийнхдөө үнэнч хэмээн өөрийн шашны мандан бадралын төлөө бусдын шашныг гутаан доромжлоод, өөрийн шашныг өргөмжилдөг хүн хэрэг дээрээ тийм үйлээр өөрийн шашинд асар их хор учруулж байгаа хэрэг”* гэжээ.

Манай тооллын өмнөх 3 дугаар зууны үеийн эдгээр зарлигт хүлээцтэй байдлын ач холбогдолыг (төрийн бодлого болон иргэдийн бие биедээ хандах зан араншинд) онцлон тавьсан байна.

Хүлээцтэй байдлын хүрээний тухайд Ашока нийтлэг үзэлтэй хүн байв. Буддын шашинд орохоосоо өмнөх өөрийн үйдлийг



буруушааж тэрээр “Калингагийн дайнд тэр (ялагдсан) улсын нэг бум таван түмэн хүн, малыг (олзлон) авчирсан” хэмээн тэмдэглэжээ. Цааш нь өгүүлэхдээ “тэр үед Калингад амь үрэгдсэн, үхсэн, олзлогдсон хүмүүсийн зууны, бүр мянганы нэгийг нь ч гэсэн хороож, боолчилно гэдэг нь” одоо түүнд харамсан гашуудмаар хэрэг гэсэн байна. Мөн тэрээр “хэдий хүн өөрийгөө буруутгавч хэрэв өршөөж болохоор зүйл бол өршөөл хүртэнэ” гэж үзэж байна гэж мэдэгдсэн байдаг. Түүний засгийн зорилгыг “амьд бүхнийг хорлолгүй, даруу, алагчлахгүй, өршөөнгүй хандах” гэж дүрсэлдэг.

Зарим хүний хувьд Ашокагийн эрх тэгш байдал, нийтээр хүлцэнгүй хандах сургааль Азийн биш харагдаж болох ч түүний үзэл бодол өмнөх зуунуудад нь Энэтхэгийн Бурханы шашны оюунлаг хүрээнд заншил болоод байсан үзэл хандлагад гүн ул үндэстэй юм. Энэ сэдвийн хүрээнд засаглал, улс төрийн эдийн засгийн ухааны талаар ихээхэн нөлөө бүхий бүтээл сургааль бичсэн өөр нэгний тухай яривал сонирхолтой болов уу. Энэ бол эдийн засгийн ухаан буюу Арташастраг зохиосон Каутиля юм. Гэхдээ түүний энэ бүтээл эдийн засгийн асуудалтай эн сацуу хэмжээнд улс төрийн асуудлыг хөндсөн байдаг. Тэрээр Аристотелийн үеийн хүн бөгөөд МТӨ 4 дүгээр зууны үед аж төрж, Ашокийн элэнц эцэг тэр хойгийг дамнасан Маурийн эзэнт гүрнийг байгуулсан Чандрагупта Маурияд тэргүүн сайдын үүрэгтэй зүтгэж байсан байна.

Каутилягийн бүтээлүүдийг ихэнхдээ Энэтхэгийн сонгодог уламжлалд эрх чөлөө, хүлээцтэй байдлыг үнэлдэггүй байсан гэдгийн нотолгоо болгож иш татдаг. Арташастрад либерал ардчиллыг огт

дэмжээгүй гэсэн ойлголт өгөхөөр улс төр, эдийн засгийн мэдээ баримтыг гайхалтай нарийн тоочсон хоёр үзэл санаа бий. Эн тэргүүнд Каутиля бол маш ховорхон таарах учир шалтгаанч хүн байв. Улс орон дахь албат харьяатуудын аз жаргал хийгээд дэг журмыг хөхиүлэн дэмжих зорилгыг тодорхой бодлогын зөвлөмжөөр дэмжихийн хажуугаар хааныг эрх мэдлийг нь сайн зорилгын төлөө тодорхой зохион байгуулалтаар өргөжүүлэх ёстой өршөөлт эзэн гэж харжээ. Ийнхүү Арташастра өлсгөлөнгөөс сэргийлэх, захиргааны үр дүнтэй ажиллагаа зэрэг 2000 жилийн дараа өнөө үед хүртэл хамаатай практик асуудлуудын талаар үзэл санаа агуулсны хажуугаар, мөн хаанд хэрэгтэй бол дайснаудынхаа эрх чөлөөг хяхан боож байгаад хэрхэн хүсэл зоригоо гүйцэлдүүлэх вэ гэдгийг зөвлөсөн утгатай байдаг.

Хоёрт, Каутиля улс төрийн болон эдийн засгийн эрх тэгш байдалд тун бага ач холбогдол өгсөн мэт санагддаг. Сайхан нийгмийн талаар түүний санаа анги буюу кастын системийн дагуу тогтсон байдаг ажээ. Аз жаргалыг хөхиүлэн дэмжих зорилт нь бүгдэд хамаатай боловч түүний бусад зорилт тэгш бус байдлын хэлбэр агуулгыг илэрхийлдэг юм. Нийгмийн хувь зохиол муутай гишүүдэд зовлон зүдгүүрээс ангижирч, амьдралын сайхныг мэдрэхэд нь туслалцаа үзүүлэх үүрэг бий. Каутиля “өнчид, настангууд, сул доройчууд, гамшигт учрагсад, биеэ авч явах чадваргүй хүмүүст дэмжлэг үзүүлэх”-ээс гадна хүүхэдтэй ядарсан эмэгтэйчүүд, тэдний төрүүлсэн хүүхдэд амь зуулгаар туслах үүргийг тухайлан хааны гүйцэтгэх үүрэг хэмээн тодорхойлсон байна. Гэхдээ эдгээр үүрэг хариуцлага нь эдгээр хүмүүсийн хэрхэн аж төрөх вэ гэдгээ шийдэх эрх чөлөөг үнэлэхэд тун хол хөндий байгаа

юм. Буруу номын үзэлд хүлцэнгүй хандах талаар энд байхгүй. Мэдээж Каутиляд нийгмийн дээгүүр зиндааны хэсгийнхэнд үзүүлэх хүлээцтэй байдлыг эс тооцвол хүлцэнгүй байх гэж ойлголт байсангүй.

Тэгвэл эндээс бид ямар дүгнэлт хийж болох вэ? Мэдээж Каутиля бол ардчилагч ч, эрх тэгш байдлын үзэлтэн ч, хүн бүрийн эрх чөлөөг ерөнхийд нь дэмждэг хүн ч биш байлаа. Гэхдээ бас хамгийн ээлтэй хүмүүсийн (дээд ангийнхан) эдлэх ёстой зүйлийг тодорхойлоод ирэхээр эрх чөлөө нилээн тод томруун гарч ирээд байна. Дээд ангийнхны (Ари хэмээх) хувийн эрх чөлөөг үгүйсгэх нь зөвшөөрч боломгүй зүйл болж байна. Энгийн шийтгэлд дансан дахь тийм насанд хүрэгсэд, хүүхдийг боол болгон авахаар заасан байна. Гэхдээ угаасаа боол байгаа хүнийг боолчлох нь бүрэн хүлээн зөвшөөрөх боломжтой гэж тооцдог байлаа. Каутилягаас Аристотелийнх шиг боломжоо чөлөөтэй ашиглахын ач холбогдлыг тодорхойлсон шиг зүйл олж харахгүй байна. Гэхдээ Каутилягийн бүтээлд дээд ангийнхны тухайд ядаж эрх чөлөөний асуудалд анхаарал хандуулсан нь илэрхий байна. Энэ нь туйлдан ядуурч, гуйланчлалд орохоос сэргийлэхэд чиглэсэн эцгийн шинжтэй төрийн дэмжлэгийн хэлбэрээр илрэх доод давхаргад хандсан төрийн үүрэгтэй харьцуулж болохоор байна. Гэсэн ч сайн сайхан амьдралын тухай үзэл энэ бүхэнд гарч ирж байгаа тохиолдолд эрх чөлөөг үнэлэх ёс суртахууны тогтолцоотой бүхэлдээ уялдсан гэдгээрээ зохистой юм. Үнэндээ хязгаарлагдмал хүрээтэй боловч Грекчүүдийн чөлөөт хүмүүсийг боолууд, эмэгтэйчүүдтэй харьцуулан ялгадагаас хол зөрөхгүй байна.

Би үнэмшилтэй боловч хоорондоо ялгаатай Манай тооллын өмнөх 3, 4

дүгээр зууны Энэтхэгийн хоёр жишээн дээр улс төрийн үзэл санаа болон бодит амьдрал дээрх учир шалтгааныг авч үзсэн шалтгаан нь эдгээр нь хожмын Энэтхэгийн бүтээлүүдэд нөлөөгөө үзүүлсэн учраас юм. Би энд Энэтхэгийн улс төрийн бүхий л онолчид Ашокийн, эсвэл Каутилягийнхтай төсөөтэй хандлага барьдаг гэсэн ойлголт өгөхийг хүсэхгүй байна. Харин ч эсрэгээрээ. Ашока, Каутиля хоёроос өмнө ч, хойно ч тэдний үзэл бодолтой таардаг хүмүүс байсны адилаар хэн хэнийх нь үзэл бодолтой эсрэгцсэн байр суурь бүхий хүмүүс ч байсан юм.

Бусдад хүлээцтэй хандахын ач холбогдлыг, бүр түүнийг нийтээр хүлээн зөвшөөрөх шаардлагыг ч, өөр бусад эх сурвалжид тод томруун илэрхийлж ирсэн. Шудракагийн жүжгүүдэд, Акбарын улс төрийн зарлигууд, Кабирын яруу найраг гэх мэт цөөн хэдийг нь товч дурдаж болох юм. Эдгээрийн хувь нэмэр нь эсрэг үзэл бодол, саналыг үгүйсгэхгүй. Утга нь Энэтхэгийн олон янзын соёл уламжлал нь мөн олон янзын үзэл санаа агуулах бөгөөд тэдгээрт өөр өөр байдлаар хүлээцтэй байдал, эрх чөлөө, тэр бүү хэл маш суурь түвшинд тэгш байдлыг дэмжсэн санаанууд ордог.

Энэтхэг дэх ялгаатай байдалд хүлээцтэй хандах үзлийн хамгийн нөлөө бүхий илэрхийлэгч, номлогчдын дунд 1556 оноос 1605 оны хооронд төр барьж байсан Их Моголын эзэн хаан Акбар зайлшгүй орно. Дахин хэлэхэд энд ардчиллын тухай ярихгүй. Харин ч Акбар хаан бол нийгмийн болон шашны зан үйлийн олон янзын хэлбэрийг хүлээн зөвшөөрөхөд онцгойлон анхаарсан, тухайн үед Европын аль ч хэсэгт тийм амархан хүлцэн өнгөрөөхөөргүй шүтэх бишрэх эрх чөлөө

зэрэг олон төрлийн хүний эрхийг хүлээн зөвшөөрсөн хүчирхэг эзэн байлаа.

Нэг жишээг авч үзье. Нийтийн тооллын 1591-1592 онд Исламын шашны Хижрийн тоолол 1000 он болох үед Дели, Агра хотуудад энэ талаар их хөөр баяр (саяхан Нийтийн тооллын 2000 онд болсны адилаар) болж байв. Акбар энэ түүхэн зааг үед олон зарлиг тушаал гаргасан нь тухайлбал шашин хоорондын хүлцэл зэрэгт чиглэсэн байв. Үүнд жишээлбэл:

“Хэний ч шашин шүтлэгт хөндлөнгөөс нь оролцож болохгүй бөгөөд хүн бүр өөрийн хүссэнээр шашнаа сольж болно. Хэрэв Хинду хүн хүүхэд байхдаа буюу өөр ямар нэг шалтгаанаар өөрийн хүсэл зоригийн эсрэг Исламын шашинд орсон бол, хүсч байвал эцэг өвгөдийнхөө шашинд эргэж орохыг зөвшөөрнө” гэжээ.

Мөн эргээд хүлцэн тэвчих, хүлээцтэй хандахын хүрээнд шашны асуудал дээр төвийг сахисан боловч жендэрийн эрх тэгш байдал, залуус, настнуудын эрх тэгш байдал зэрэг бусад асуудлууд дээр харилцан адилгүй байв. Акбарын зарлиг ёсоор Хинду шашинт залуу бүсгүй Исламын шашинт эрийн төлөө гэрээ орхисон бол албадан гэрт нь буцаахыг хуульчилсан байна. Дурлалт залуус болон бүсгүйн Хинду шашинт эцэг хоёрын дундаас сонгох болоход нас дээр гарсан Акбарын өрөвч сэтгэл бүхэлдээ эцгийн талд орсон байна. Нэгэн түвшин дэх ялгааг хүлцэх, эрх тэгш байдал хоёр өөр түвшинд дээр үл хүлцэх, эрх тэгш бус байдалтай огтлолцсон ажээ. Гэхдээ итгэл үнэмшил, зан үйлийн тал дээр ерөнхийдөө хүлээцтэй хандах цар хүрээ нь гайхалтай юм. Магадгүй ялангуяа “Өрнөдийн либерализм” гэж их ярьсантай холбогдуулаад Акбар шашны эвлэрэнгүй байдал дээр эдгээр зарлигуудаа гаргаж

байхад Европт Залхаан цээрлүүлэлт ид гаарч байсныг гэж тэмдэглэх нь зохистой эсэхийг мэдэхгүй байна.

#### IV

Азийн улс төрийн эдгээр зүтгэлтнүүдийн олонх нь эрх чөлөө, хүлээцтэй байдалд ач холбогдол өгсөн төдийгүй ингэх шалтгааныхаа талаар тодорхой онолтой байсан гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Энэ бол Ашока, Акбар нарт зайлшгүй хамаарна. Исламын уламжлалыг заримдаа чанд хатуу гэж үздэг учраас Акбарын тухайд онцгойлон авч үзэх нь зүйтэй. Акбар бол Хинду шашны гүн ухаан, соёлыг гүнээ сонирхсон Мусульман шашинт хаан байснаас гадна бусад шашны үзэл үнэмшил, түүний дотор Загалмайтны, Жайны, Парсын шашны зан үйлийг ихээхэн сонирхдог байжээ. Үнэндээ тэрээр улс орныхоо ялгаатай олон итгэл, үнэмшлүүд дээр суурилан Энэтхэгийн өөрийн нийлэг шашны урсгал “Дин Илахи” гээчийг үндэслэх гэж оролдсон удаатай.

Ашока, Акбар хоёрын шашны ялгааг хүлээн зөвшөөрөх хандлагын хооронд сонирхолтой ялгаа бий. Аль аль нь шашны ялгааг төрөөс хүлээн зөвшөөрөхийн төлөө зүтгэж, хоёулаа хүлээн зөвшөөрөх гэдэг нь бүхэнд хамаатай журамт үүрэг гэж номложээ. Харин Ашока үүнийг өөрийнхөө Буддын шашны бишрэлтэй холбосон (гэгээрлийг дотоод гадаадгүй түгээх гэж зорьсон) байхад Акбар өөр шашны давуу шинж чанаруудыг хамтатган Энэтхэгийн өөр хоорондоо ялгаатай олон шашныг нэгтгэх гэж оролдсон байна. Акбарын ордонд Хинду шашинтан, Мусульман шашинт сэхээтэн, урчууд, хөгжимчид дүүрэн, тэр өөрөө бүхий л талаараа бүх шашинд ивээнгүй хандаж,

албат харьяатууддаа тэгш шударга хандахыг хичээдэг байжээ.

Акбар бол Моголын эзэнт гүрний хаад дундаа шашнуудад энэрэнгүй хандаж байснаараа хосгүй биш гэдгийг мөн тэмдэглэх хэрэгтэй. Одоо бидний Хинду хүний эрх гэдэгт тооцож байгаа олон эрхийг зөрчиж байсан хожмын Моголын эзэн хаан шашны ялгааг огт тэвчдэггүй Аурангзэв олон талаараа Моголын хаадын дундаас ялгардаг. Орчин цагийн Энэтхэгийн Хинди улс төрийнхний гол төлөөлөгчид их төлөв Моголын эрхшээлийн үеийн маш олон эвлэрэнгүй чанарыг үгүйсгэх гэж оролддог боловч энэхүү тэгш хүлээцтэй хандлагыг эрт үеийн Хинди удирдагчид тун нааштайгаар хүлээн зөвшөөрсөн байдаг юм. Жишээ нь Пондишерид алдартай сүм байгуулсан Шри Ауробиндо Моголын засаглалын энэ талыг тодорхойлохдоо “Мусульманы ноёрхол харийнх байхаа их хурдан больсон.... Моголын эзэнт улс бол агуу сүрлэг байгууламж байсан бөгөөд үүнийг барьж байгуулан түшиж, тулахад асар олон тооны авьяас билэгтнүүд гар бие оруулсан юм. Энэ бол сүр жавхлантай, хүчирхэг, энэрэнгүй төр байсан агаад үүний дээр Аурангзэвийн мухар сүсэг, хөөрлийг эс тооцвол шашны эрх чөлөө, энэрэнгүй хандлагаараа дундад зууны, эсвэл тухайн үеийнхээ Европын улс гүрнүүдээс хавьгүй илүү байсан гэдгийг нэмж болох юм” гэсэн байна.

Аурангзэвийн тухайд ч гэсэн түүнийг дангаар нь биш гэр бүлийн орчинтой хамтад нь авч үзвэл үр дүнтэй юм. Аурангзэвийн шууд ойрын гэр бүлийнхэн дунд нь түүнтэй адил шашны тэвчишгүй хандлагатай хүн байсангүй. Түүний ах Дара Шико Хинди гүн ухаанаар гүнзгий оролдож, зарим судлаачдын тусламжтайгаар МТӨ 8 дугаар

зууны үеийн эртний сурвалжууд болох Упанишадын зарим хэсгийн Перс хэл дээрх орчуулгыг бэлтгэн гаргасан байдаг. Үнэндээ Дара нь Шах Жахан хааны ууган, хамгийн хайртай хүү нь болохын хувьд Аурангзэвээс илүү Моголын хаан ширээнд суух эрхтэй байжээ. Аурангзэв ахтайгаа тулалдаж, хороогоод эцэг Шах Жахан хааныг үлдсэн насных нь (Таж Махалыг байгуулсан Шах Жахан өөрийнхөө бүтээлийг хорионоос харж насыг барсан) турш хорионд байлгасан юм.

Бас л Акбар гэдэг нэртэй Аурангзэвийн хүү 1681 онд эшгийнхээ эсрэг босч, энэ үйл хэрэгтээ эхлээд Ражастаны Хинди вант улстай, дараа нь Маратхагийн гүрэнтэй эвссэн ажээ. (Акбарын бослогыг Аурангзэв эцэст нь дарсан) Эцэгтэйгээ тэмцэж байхдаа Акбар Ражастанаас түүний шашны хүлцдэггүй зан болон Хинди шашинт найзуудыг нь гутаан дорд үзсэнийг буруушаан бичиж байв. Ялгаатай байдал энэрэнгүй бус хандах хандлагын асуудал дайсагнагч талуудын дунд маргах томоохон сэдэв болдог байсан нь ойлгомжтой. Залуу Акбартай гар барьсан Маратхагийн хаан Самбхажийн эцэг нь өнөөгийн Хинди улс төрийн зүтгэлтнүүдийн агуу баатар гэж үздэг Шиважи байв. Түүний нэрээр Хиндигийн аядуу бус үзэлт Шив Сена нам нэрлэгдсэн юм. Шиважи шашны нилээд аядуу үзэлтэй хүн байжээ. Бусад талаар Шиважиг огтхон ч нэг нүдээр үздэггүй Моголын түүхч Хафи Ханы бичсэн нь: “Шиважи дагалдагчдаа талж дээрэмдэхдээ Исламын сүм, шашны судар, бусдын эмэгтэйчүүдэд хор хүргэж болохгүй хэмээн цаазалсан. Ариун Куран судар гарт нь орвол тэрээр хүндэтгэж, мусульман шашинт дагалдагчдынхаа нэгэнд өгдөг байв” гэжээ. Аурангзэвт шашны аядуу хүлцэнгүй хандлагын талаар явуулсан

нэгэн сонирхолтой захидлын эзэнд зарим түүхчид (1919 онд хэвлэгдсэн Шиважи ба түүний цаг үе хэмээх номын зохиогч Сэр Жануда Саркар зэрэг) Шиважи хамааруулдаг. Гэвч энэ таамаглалд зарим нэг эргэлзээ бий. Аурангзэвийн үеийн Хинди шашинтнуудын хэн нь ч энэ захидлыг бичсэн байлаа гэсэн үүнд илэрхийлсэн санаа нь сонирхолтой юм. Захидалд Аурангзэвийн шашны үл хүлцэх хандлагыг өмнөх үеийн Моголчуудын (Акбар, Жахангир, Шах Жахан) либерал улс төрийн бодлоготой харшуулсан байх бөгөөд “Эрхэм дээдэс та эдгээр сударт бурхны гэх ялгаагаар нь аль нэг итгэл бишрэлийг оноох аваас, та бурхан бол дан ганц Мусульманчуудынх биш бүх хүн төрөлхтөний бурхан хэмээн сургах болно. Бурханы өмнө өөр шүтлэгтэн ч бай, Мусульман ч бай ижил тэгш билээ..... Эцэст нь таны Хинди нараас шаардаад байгаа хүндлэл шударга ёсонд харшилж байна” гэжээ.

Шашны уламжлалуудын болон тэдгээртэй холбогдсон улс төрийн ялгаатай бодлогуудын хооронд мөргөлдөөн тэмцэл их болдог байсан энэ үеийн олон зохиолчид үл ялгаварлалын сэдвийг хөндсөн нь олонтой. Энэ сэдвээр бичсэн хамгийн эрт үеийн зохиолчдын нэг нь Газний Махмудын булаан эзлэгч армитай хамт Энэтхэгт ирж, булаан эзлэгчдийн үйлдсэн харгислалыг жигшин бичсэн 11 дүгээр зууны Ираны зохиолч Алберуни юм. Тэрээр улмаар Энэтхэгийн нийгэм, соёл, шашин, үзэл санааг судалсан бөгөөд таньж мэдэхгүй зүйлээ үл тэвчдэг хандлагын талаар бичсэн байдаг.

*“.....бүхий л үйл байдлаараа, (Хиндичууд) биднээс эрс ялгаатай, тиймээс биднээр, бидний өмссөн хувцас, байгаа байдал, зан заншлаар хүүхдүүдээ айлгаж, биднийг*

*чөтгөрийн төрөл, бидний үйл бүхнийг сайн сайхнаас эрс эсрэг гэж зарладаг. Үүн дээр шударгаар хэлэхэд харийнхныг ад үзэх хандлага зөвхөн бидний болон Хинди нарын дунд зонхилдог зүйл төдий бус бүхий л үндэстэн угсаатнууд бие биедээ гаргадаг нийтлэг араншин билээ.”*

Энэ бүхнийг дурддагийн учир нь Азийн уламжлалын тодорхой, чухал хэсгүүдэд ялгааг хүлээн зөвшөөрөх, эрх чөлөөний асуудлыг эрүүл саруулаар дүгнэх хандлага байж ирснийг харуулах гэсэн юм. Бид эрт үеийн Араб, Хятад, Энэтхэгийн, болон бусад соёл уламжлал дахь эх сурвалжуудаас ийм жишээ олныг харж болно. Мөн ардчилал, улс төрийн эрх чөлөөний асуудлыг өнөөгийн утга учраар нь өмгөөлөх хандлага Өрнө, Дорно, дэлхийн аль ч өнцгийн соён гэгээрлээс өмнөх үеийн уламжлалд байгаагүй юм. Үүний оронд бидний энэ бүрэлдмэл санааны бүтэц, бүрэлдэхүүн хэсгүүдийг шинжилж үзэх шаардлагатай болж байна. Эдгээр элементүүд Өрнийн болон Өрнийн бус нийгэмд байдаг нь маш тод илэрч байгаа учраас би онцолж байгаа юм. Энэрэнгүй нийгэм дэх эрх чөлөө, эрхийн ойлголтын үндэс болж байгаа суурь санаанууд нь “Өрнийн” үзэл ойлголт гэх нь утгагүй, ойлгоход бэрх мэт боловч Азийн авторитар үзэлтнүүд, Өрнөдийн дээрэнгүй үзэлтнүүд ийм үзлийг гаргаж тавьдаг.

## V

Би Азийн үнэт зүйлийн мөн чанар, хамрах хүрээний талаарх маргаантай гэхдээ заримдаа үүнтэй холбогддог арай өөр нэг асуудлаар дүгнэхийг хүсч байна. Азийн үнэт зүйлсийг магтан дуулах нь их төлөв Өрнийн дээрэнгүйллээс хамгаалах шаардлагаар гарч ирдэг. Сүүлийн жилүүдэд улам бүр давтагдах болсон энэ хоёр

асуудлын холбоо нь колоничлолын дараах Азийн орнуудад иргэний болон улс төрийн эрхэд халдахад колоничлолын эсрэг улс төрийн хүчийг ашигладаг байна.

Энэ харилцан холбоо нь хэдийгээр нилээд зохиомол боловч уран яриа хөөрөөнд маш нөлөөтэй байж чаддаг зүйл. Тиймээс Ли Куан Ю Азийн үнэт зүйлийн онцлог чанарыг онцгойлон тавьж, Азийн өвөрмөц онцлогийг хамгаалж Өрнөдийн манлайллыг эсэргүүцэхийн тулд голлон ашиглаж байна. Энэ яруу илтгэл нь Сингапур бол “Америкийн дагуул улс биш” гэсэн илт сөргүү тунхаглал болсон юм. Энэ баримт бол гарцаагүй үгүйсгэх боломжгүй бөгөөд түүнийг уухайлан дэмжих гүн үндэстэй боловч эндээс асуувал зохих асуулт бол энэ нь Сингапур эсвэл Азийн бусад орон дахь хүний эрх, улс төрийн эрх чөлөөний асуудалтай ямар хамаатай вэ гэдэг асуулт байна.

Энэ маргаанд улс төрийн болон бусад эрх нь хөндөгдөж байгаа хүмүүс бол Өрнөдийн биш Азийн орнуудынх. Хувь хүний эрх чөлөөг Өрнөдийн орнуудад эн тэргүүнд тавьж, үүнд Өрнөдийн улс төрийн зүтгэлтнүүд тэргүүлэн оролцдог нь Азид хүмүүсийн эрх чөлөө өөрөөр байж болно гэсэн санаатай нийцнэ гэхэд хэцүү юм. Үнэндээ өрнөдийн улс төрийн зүтгэлтнүүд дэлхийн бусад хэсэг дэх эрх чөлөөний асуудалд тун бага анхаардаг гэж шүүмжлэх үндэс бий. Өрнөдийн орнуудын засгийн газрууд Азийн орнуудтай худалдаа, наймаа хийж байгаа өөрийн иргэдийн ашиг сонирхол болон бизнесийн бүлэглэлүүдийнхээ Азийн орнуудын засгийн газруудтай ашигтай хэлцэлд хүрэх гэсэн шахалтад л ач холбогдол өгдөг тухай хангалттай баримт бий. Цагтаа Маогийн цаасан бар гэж нэрлэж байсан зүйл улмаар цаасан хулгана болсон бололтой.

Тийм хэдий ч, Өрнөдийн засгийн газрууд Ази дахь улс төрийн болон иргэний эрхийг хөхиүлэн дэмжихийг оролдож байгаа нь үнэн байсан ч Азийнхны эрхийн статустай энэ нь хэрхэн уялдаж болох вэ? Энэ сэдвийн хүрээнд “хүний эрх” гэдэг ойлголтыг зөв утгаар нь ойлгох хэрэгтэй. Хамгийн энгийн хэлбэрээр бол хүний эрхийн ойлголт нь хүн байх тухай нийтлэг ойлголтод тулгуурлана. Эдгээр эрх нь аль нэг улсын иргэний харъяалал, эсвэл аль нэг үндэстний гишүүнчлэлээс үүдэн гардаг зүйлс биш юм. Эдгээр нь бүхий л хүн төрөлхтөний эдлэх эрх мөн гэж ойлгоно. Тиймээс эдгээр эрх нь тодорхой хүмүүст (Америкийн иргэд буюу Францын харьяатууд гэх мэт) зориулан үндсэн хуулийн хүрээнд баталгаажуулан бий болгосон эрхээс ялгаатай юм. Хүний эрүү шүүлтээс ангид байх эрхийг тухайн хүний иргэний харьяаллаас нь хамааралгүйгээр, мөн тухайн орны (эсвэл өөр бусад орны) төр засаг нь юу хүсч байгаатай холбоогүйгээр баталгаажуулдаг. Мэдээж засгийн газар тухайн хүний эрүү шүүлтээс ангид байх хууль зүйн эрхийн талаар маргаж болох ч тухайн хүний эрүү шүүлтээс ангид байх хүний эрх ямар байх талаар маргах хэмжээнд хүрэхгүй нь ойлгомжтой.

Хүний эрхийн цогц ойлголт нь дотоодын хууль тогтоомж, хүний иргэний харьяаллын хил хязгаараас давсан учраас эрх нь аюул заналд өртсөн хүнтэй адил иргэний харьяалалтай ч бай үгүй ч бай хэнээс ч гэсэн хүний эрхийн төлөө дэмжлэг ирж болно. Эрх чөлөө нь зөрчигдсэн хүнд туслахын тулд гадаадын хүн тухайн дарангуйлагч төр засгаас зөвшөөрөл авах шаардлагагүй юм. Хүний эрх нь хүн болохынхоо хувьд (тодорхой нэг улсын иргэн гэсэн утгаар биш) хүн бүрт байх ёстой эрх гэж үзэж байгаа цагт л түүнтэй

хамааралтай үүрэг хариуцлага бүхий л агуулгаараа мөн л хүн бүрт (иргэний харьяаллаас үл хамааран) хамаарах нь тодорхой.

Мэдээж ингэж нийтээр хүлээн зөвшөөрлөө гээд бүгдээрээ бусдыг хамгаалж, туслах гэж байнга хөндлөнгөөс оролцох ёстой гэсэн утга илэрхийлэхгүй. Тэгэх нь утгагүй, түвэгтэй байх болов уу. Энэ чиглэлд хүний үйл ажиллагааны бусад аль ч чиглэлээс илүүтэй тодорхой бодитой шалтгаан байх хэрэгтэй гэдэгтэй маргах аргагүй юм. Тодорхой нэг улсын дотоодод ч, хилийн чанадад ч байнга хаа ч гэсэн хөндлөнгөөс оролцоод байх нь бүтэлтэй, хүсүүштэй зүйл биш. Дэлхийн өнцөг булан бүрээс хамгаалбал зохих хүний эрхийг хайх шаардлага байхгүй. Миний хэлэх гээд байгаа зүйл бол бол үндэс угсаа, иргэний харьяалал хүмүүсийг бусдын хууль ёсны ашиг сонирхлыг өмгөөлөн дуу хоолойгоо нэмэрлэх, тэр бүү хэл үүнтэй холбоотой зарим үүрэг хүлээхэд саад болохгүй гэсэн санаа юм. Хүний үйлдлийг тодорхойлоход голлох үүрэгтэй ёс суртахууны болон улс төрийн хэм хэмжээ нь улсын хилийн дотор төдий бус хил дамнан байх ёстой зүйл.

Дүгнэхэд авторитар дэглэмийг зөвтгөхөөр гаргаж тавьсан Азийн үнэт зүйл гэх зүйлс нь ямар нэгэн утгаараа тухайлан Азийн ухагдахуун биш юм. Тэдгээр нь юугаараа Өрнөдийн эсрэг, Азийн болоод байгааг энгийн уран тайлбараар ойлгуулахад ч хялбар бус. Эрх нь маргаантай байгаа хүмүүс бол Азичууд бөгөөд Өрнөд ямар ч буруутай байлаа гэсэн (Дэлхий даяар хагархай олгойтой тогоо хаа сайгүй бий) Азичуудын эрхийг эдгээр үндэслэлээр эрсдүүлж байна. Эрх чөлөө,

улс төрийн эрхийн асуудал нь эцэстээ гол утга агуулга, амьдралд гүйцэтгэх үүрэг рүүгээ чиглэдэг. Энэ нь Азид дэлхийн бусад хаана ч байдгийн адилаар хүчтэй илэрдэг.

Ази болон Европын үнэт зүйлийг судалснаар олж мэдэх зүйл маш их байгаа ч эдгээр нь их хуваагдлын (буюу иргэншлүүдийн мөргөлдөөний) онолыг нотлох буюу дэмжлэг өгөхгүй. Улс төрийн болон хувь хүний эрхийн талаарх бидний ойлголт нь саяхнаас л тодорхой хэв шинжээ олсон бөгөөд тэднийг зөвхөн Өрнөдийн соёлын “уламжлалт” үзэл үнэмшил гэж үзэхэд аргагүй. Эдгээр үзэл үнэмшилд чухал урьдач нөхцлүүд байсан боловч тэдгээрийг Азийн соёлд ч Өрнийн соёлд ч хангалттай олныг олж харж болно.

Нэгэнт бид “Өрнийн соёл иргэншил,” “Азийн үнэт зүйлс,” “Африкийн соёл” гэх мэтчилэнгийн хэт ерөнхий ойлголтуудад байнга бөмбөгдүүлж байгаагаас хойш өөр өөр соёл дахь ялгааг хүлээн зөвшөөрөх нь өнөөгийн ертөнцөд онцгой ач холбогдолтой билээ. Өдгөө ул үндэс муутай түүхэн болон соёл иргэншлийн тухай ойлголтууд тун өнгөц сэтгэлгээ төдийгүй бидний амьдарч байгаа ертөнц дэх зөрчилдөөнийг даамжруулахад хувь нэмэр болж байна. Зарим газар улам бүр газар авч буй авторитар шинжтэй Азийн үнэт зүйлсийн ойлголтууд нь шүүмжээс зугтаж чадахгүй. Азийн үнэт зүйлс, Европын үнэт зүйлс хоёрын их ялгаа нь бидний мэдлэг ойлголтод нэмэр багатайн дээр эрх чөлөө, ардчиллын хэвшсэн үндсийн талаарх төөрөгдөлд нэрмээс болохоос цаашгүй юм.

Монгол хэлнээ орчуулсан  
Хүний эрхийн Үндэсний Комиссын  
референт Ө.Ундрах

#### Эх сурвалж:

“The New Republic” сэтгүүлийн  
1997 оны 7 дугаар сарын 14-21, 33-40 дэх тал

## МОНГОЛ УЛСАД ЭРЭГТЭЙ СУДЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ БАЙНА



*Баруун гар талаас: Д.Бадамцэцэг, З.Бадмаарэг*

*Монголын Эрэгтэйчүүдийн холбооны гүйцэтгэх захирал  
Д.Бадамцэцэгийг дугаарын зочноор урьж ярилцлаа.*

**Монголын эрэгтэйчүүдийн холбоо анх байгуулагдахдаа нэлээд амаргүй, бэрх гэмээр зүйлстэй тулгарч байсан санагддаг. “Эрэгтэйчүүдийн эрх зөрчигдөж байгаа гэж үү, эрэгтэйчүүдийг юунаас хамгаалдаг юм” гэх эсэргүүцэл байсан. Тэгвэл та тэр хүмүүст өнөөдөр ямар хариулт өгөх бол?**

Тиймүлөйлголцолбайсныгүгүйсгэхгүй. Гэхдээ маш цөөхөн хувь байсан байх. Манай холбоо байгуулагдсан цагаас эхлэн эрэгтэйчүүдийн асуудлыг шийдвэр гаргагчид болон олон нийтийн хүрээнд тодорхой хэмжээнд мэддэг болсон. Улсын хэмжээнд анх эрэгтэйчүүдийн ганцхан эмнэлэгт үйл ажиллагаа явуулдаг байсан бол одоо хувийн хэвшлийн 10 орчим эмнэлэг нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна зарим дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд эрэгтэйчүүдийн тасаг кабинет нээн ажиллуулж эхэлсэн гээд яривал эрэгтэйчүүдийн асуудал өөр болж ирж байгаа. Өнгөрсөн хугацаанд бид аав хүний үнэлэмжийг дээшлүүлэхэд

түлхүү анхаарсан. 2004 онд олон нийтийн дунд “Аав нарын өдөр байх ёстой юу?” гэсэн санал асуулга явуулахад 5000 хүний дэмжлэг авч байсан.

Эцэг хүнийг аав хүнийг урамшуулдаг тогтолцоо манайд байдаггүй. Тэр утгаараа аавуудын өдөр нь хүүхэд аав хоёрыг улам ойр дотно болгоход тусална гэсэн саналууд ирж байсан. Тиймээс 2005 оноос эхлэн 7 дахь жилдээ “Аавуудын өдөр”-ийг тэмдэглэлээ. Хүүхдүүдийг ааваараа бахархах албан ёсны өдөртэй больё гээд бид саналаа боловсруулаад Ерөнхий сайдад хүргүүлсэн байгаа.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд онцгой анхаарал тавьж, 2006 онд “Эрчүүдээ хайрлая” сарын аян, 2008 онд Эрэгтэйчүүдийн эмч нарын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, 2009 онд Монголын бэлгийн анагаах ухааны нийгэмлэгтэй хамтран Ази Номхон далайн орнуудаас мэргэжилтнүүдийг урьж ирүүлэн үндэсний 150 орчим эмчид



эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшүүлэх сургалт явуулсан.

Мөн Гэрлэх ёслолын ордонтой хамтран гэр бүлийн менежмент, эрүүл ахуйн асуудлаар 39000 орчим шинэ хосуудад сургалт зохион байгуулж байлаа.

5 жилийн ойн босгон дээр буюу 2008 оны гуравдугаар сард Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Монгол Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Жендерийн Үндэсний Хороотой хамтран аймаг, нийслэлийн шийдвэр гаргагчдын төлөөллийг оролцуулсан “Монголын эрэгтэйчүүдийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” сэдэвт эрэгтэйчүүдийн анхдугаар чуулганыг зохион байгуулж, зөвлөмж гаргаж байлаа.

**Тэр зөвлөмжид ямар асуудлыг тусгасан юм бол. Зөвлөмжийн хэрэгжилт хэр байна вэ?**

Хэрэгжилт боломжийн хэмжээнд байгаа. Хамгийн гол нэг асуудал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх ижил, тэгш байх ёстой гэдэг утгаараа Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль зайлшгүй шаардлагатай гэсэн санал байсан. Эрэгтэйчүүдийн дунд суурь судалгаа явуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг олон асуудлыг тусгасан. Тэдгээрээс эхнээсээ биелэлээ олоод явж байгаа гэж бид үзэж байна.

Бид эрх нь зөрчигдсөн эрэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг. Энэ утгаараа 2006, 2007 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Амгалан дахь хорих ангид сэтгэл зүйн тусгай лекц, сургалтын материалуудыг бэлтгэн өгч байсан. Ховд аймаг руу ч бас явуулсан.

Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу суллагдсан залууст “Итгэл найдварын

хуудас” гардуулах, зарим хүнийг хүлээн авч ажлын байранд зуучлах зэрэг ажлыг зохион байгуулж байлаа.

**Эрэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, тэдний асуудлыг шийдвэрлэх, холбоог нь удирдах ажилд та хэдийнээс оров. Холбоо байгуулах санаа юунаас үүдэлтэй вэ?**

Миний мэргэжилбагш. Өмнөнъерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хороо, багшийн сургууль зэрэг байгууллагад ажиллаж байлаа. Хэсэг хугацаанд гадаад ажиллаж, амьдарч байгаад эх орондоо ирэхэд орчин нөхцөл их өөрчлөгдсөн нь “Гадны хүний нүдээр” гэдэг шиг харагддаг юм билээ. Манай эрэгтэйчүүд нь хэтэрхий их архинд орчихсон, ажилгүйдэл ихэссэн, гэр бүлийн уур амьсгал эрүүл биш, ер нь асуудал байгааг анзаараад Эрэгтэйчүүдийн холбоог байгуулах саналыг тухайн үед УИХ-ын гишүүн байсан Л.Одончимэд даргад тавьсан. Санаа нийлсэн хэдэн хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Эргээд харахад манай холбоо их зөв цаг үедээ байгуулагдсан байсан. 2003 онд холбоог байгууллаа гээд зарлаж байх үед Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг Засгийн газар батлах гэж байсан. Тухайн үед манай удирдах зөвлөлийн гишүүдийг тэр хөтөлбөрийг батлах хуралд бүрэн бүрэлдэхүүнээр нь оруулсан.

**Монгол эрчүүдийн бусад улс үндэстнээс ялгарах онцлог шинжийг тодорхойлох боломжтой юу. Тэдэнд ямар тулгамдсан асуудал байдаг бол?**

Анх холбоогоо байгуулж байх үед “гадны” хүний нүдээр бол манай эрэгтэйчүүд гутранги, өмссөн зүүсэндээ анхаарал тавьдаггүй, үлбэгэр, унжгар харагддаг байлаа. Дэргэд нь манай бүсгүйчүүд цэцэг дэлбээ шиг. Өөртөө

хайнга хандаж байгаад дан ганц эрчүүдийг буруутгахыг би хувьдаа хүсдэггүй. Тэдэнд эмэгтэй хүний оролцоо, хайр халамж маш их хэрэгтэй. Анх надад их сонин санагдаж байсан. Миний урдхан нэг хос явж байлаа. Эмэгтэй нь булган шубатай учиргүй ганган дэгжин. Харин эрэгтэй нь өмднийх нь шуумаг эргэчихсэн, нэлээд ядруухан, бас жаахан халамцуухан. Надад их содон туссан. Европт иймэрхүү асуудал байдаг ч нэг их элбэг биш. Зөвхөн гадаад үзэмжээс харахад ялгаатай байдал нэг иймэрхүү. Тэгвэл харилцааны талд манай залуучууд нэлээд бүдүүлэгдүү болчихсон. Автобусанд яваа настанд суудал тавьж өгөхгүй, сонин үг хэллэг, хараал хэрэглэж, түүнийгээ гэр бүлдээ, үр хүүхдийнхээ дэргэд ашиглаж байгаа нь эмзэглүүштэй санагдаж байлаа.

Монголчууд нэгэн цаг үед эцгийн эрхт ёс давамгайлж байсан. Ургийн бичгийг сэргээх асуудлыг ажил хэрэг болгох санал манайд ирсэн. Бид дэмжиж байгаа. Цөөхөн улс үндэстэн удам угсаа, гарал үүслээ мэддэг байх шаардлагатай. Гадаадад байгаа монголчуудад ч хамааралтай чухал асуудал. Эрэгтэйчүүд өөрсдийгөө өөрчлөх, нийгэмтэйгээ хөл нийлүүлэх шаардлагатай байна. Боловсролын салбар дахь жендэрийн тэнцвэргүй байдал нийгэмд сөрөг нөлөө үзүүлж байгааг үгүйсгэхгүй.

Сэтгэл гутралд орж, дарамтад орсон эрэгтэйчүүд архинд орох асуудал байсаар байна. Хүчирхийлэлд дан ганц эмэгтэйчүүд өртөж байна гэж үзэх нь өрөөсгөл. Монгол эрчүүд бусад улс орныхтой харьцуулахад хүчирхийлэлд өртөх нь харьцангуй бага хэдий ч аливаа хүчирхийлэлд эрэгтэйчүүд өртсөөр байгаа.

Ноднин манай холбоо Монгол эрэгтэйчүүдийн үнэлэмжийн түвшинг тогтоох судалгааг “Идэр” дээд сургуулийн социологийн тэнхимтэй хамтарч хийсэн.

Эрэгтэйчүүдийг үнэлэх үнэлэмж манай нийгэмд маш доогуур байгааг тогтоосон.

Өнөөдөр эрчүүдийн нийгэмд оролцох оролцоо, үнэлэмжийг сайжруулах нь олон талын ач холбогдолтой. Гэмт хэрэгт өртөж буй, бүтэхгүй тодотголтой хүүхдүүд ихэвчлэн өрөөсгөл гэр бүлээс үүдэлтэй байдаг. Гэр бүл дэх эцэг хүний үүрэг, үнэлэмжийг сайжруулах зорилготой “Аавуудын өдөр”-өөр олон хүн баяр хүргэж байсан.

Түүнээс гадна эрэгтэйчүүдийн гэр бүлдээ хандах хандлага, оролцоо, үүрэг хариуцлагыг ухамсарлуулах асуудал чухал. Хүүхдийнх нь нүдэн дээр ээжийг нь зоддог аавын буруу үлгэр дуурайлал ирээдүйд ямар хүнийг бэлтгэж байна вэ гэдгийг ч анхааралдаа авах шаардлагатай юм.

**Эрэгтэйчүүдийн холбоог эмэгтэй хүн удирдахад ямар нэг бэрхшээл тулгардаг болов уу?**

Эхэндээ амаргүй байсан. Эрэгтэй хүний сэтгэл зүйг ойлгож байж харилцах шаардлагатай тулгарсан. Эрэгтэй хүн ерөнхийдөө их сонин, хүүхэд шиг гэж зохиолчид тодорхойлдог доо. Ерөнхийдөө ойлгоод, хичээвэл тийм ч хэцүү зүйл биш. 9 жил холбооны гүйцэтгэх захирлаар ажиллалаа. Эрэгтэйчүүдийн асуудлыг анхаарч, дэмжиж ажилладаг байгууллага олширч байгаад баярладаг. Хэл устай, өндөр боловсролтой залуучууд хамтарч ажиллах санал тавьж байна. Бид суурийг нь тавьж өглөө, одоо цаашдаа манай залуус бидний эхлүүлсэн үйлсийг үргэлжлүүлээд аваад явах байх гэж найдаж байна.

**Танай холбоо байгуулагдаад 10 жилийн ойтойгоо золгож гэж байна. Та зорьсондоо хүрсэн үү?**

Зорилгодоо хүрч яваа гэж хэлж болно. Цаашдаа ч хийх ажил, төлөвлөсөн зүйл их л байна. Холбоогоо байгуулаад удаагүй

байхад хошин шогийн жүжигчин Амбий радиогоор “Эрүүлжүүлэхээс өөр эрчүүдэд үйлчилдэг байгууллага байхгүй” хэмээн ярьж байгааг сонсоод их эмзэглэсэн. Нэг жил хагасын дараа над дээр орж ирээд “Танайхыг залуу гэр бүлд зориулсан сургалт явуулдаг болохыг сонслоо. Одоо ёстой холбоогоо дэмжинэ” гээд гарсан.

Эрэгтэйчүүдэд зөвлөгөө (андөвсөөрөө) зүйн төвийг байгуулсан нь багагүй эрэлт хэрэгцээтэй байгаа. Манай сэтгэлзүйч чин сэтгэлээсээ ажилладаг. Хорих ангиас санал ирдэг, Бүгд Найрамдах Солонгос Улсаас ч холбоо барьж байсан. Эрх толгойлсон эрэгтэйчүүдэд туслах ажлыг зохион байгуулдаг. Эрх толгойлсон эхчүүд манай улсад 82 000 байгаа. Үүний цаана 82 мянган аав алдаа хийсэн байна гэсэн үг.

Гэр бүл цуцлах шийдвэрийг гаргахдаа эхэд нь хүүхдийг нь үлдээдэг практик манайд бий. Энэ асуудлыг өөрчлөх цаг ирсэн. Хариуцлагагүй аавуудад хариуцлагыг оногдуулах тогтолцоог бий болгох шаардлага бий.

Мөн өнөөдөр уул уурхай дагасан гэр бүл салалт, эрэгтэйчүүдийн цаг бусын нас баралт ихэсч байна. Эрэгтэйчүүдийн биологи, сэтгэл зүйн онцлогтой холбоотойгоор амиа хорлолт харьцангуй их байна. Эмэгтэйчүүдийн эмчийг олноор бэлтгэсэн ч эрэгтэйчүүдийн эмч тун цөөхөн. Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн мэдлэг нимгэн байна.

Түүнчлэн хөвгүүдийн хувьд аавуудын үлгэр дуурайлал чухал үүрэгтэй гээд яривал асуудал их. Холбоо байгуулагдаад үйл ажиллагаа нь тасралтгүй явж байгааг эргээд харахад сайхан байна. Гэхдээ өнөөдөр эрэгтэй судлалыг бий болгох зайлшгүй шаардлагатай юм. Яахав, хүн судлал талаас нь эрэгтэй, эмэгтэй хүний

зүрхний хэмжээ, жин зэргийг судалсан байдаг. Тэгвэл Монгол эр хүний бусад үндэстнээс ялгагдах сэтгэл зүйн онцлогийг ч юм уу, арай өөр өнцгөөс харах хэрэгтэй болоод байна. Гэрлэх ёслолын ордны дарга н.Оюунчимэг нэгэн сонирхолтой баримт ярьсан юм. 1970-аад оны үед анх түүнийг ажлаа хүлээж авсны дараахан залуучууд 19-20-ын хуримын бөгж захиалдаг байж л дээ. Гэтэл одоо бүсгүйчүүд 19-20-ын хуримыг, эрэгтэйчүүд нь бүр 17-ын хуримыг зүүдэг болсон гэж байсан. Энэ нь цаагуураа нэг зүйлийг илэрхийлээд байгаа хэрэг. Ноднин цэрэг татлагаар манай залуусын олонх нь жиндээ хүрээгүйгээс тэнцээгүй. Анхаарахгүй өнгөрч боломгүй асуудал шүү. АНУ-д эрэгтэйчүүдийн үс халзралт, сахал ургалт, хүн хоорондын харилцааны талаас судалдаг нэлээд олон институт ажилладаг гэж сонссон. Манайд бол ямар ч судалгаа байхгүй. Жендэр судлалыг ч үүнтэй хослуулж болмоор санагддаг. Ер нь эрэгтэйчүүд судлалд төрийн бодлого хэрэгтэй байна.

*Цаг, зав гарган ярилцсан танд баярлалаа.  
Ажлын амжилт хүсье.*

Ярилцсан: Хүний эрхийн Үндэсний  
Комиссын референт З.Бадмаараг

